

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 5
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 - 71
1.	<i>“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий/</i>	7 - 22
2.	<i>“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Боловсролын зээлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/</i>	22 - 50
3.	<i>Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх</i>	50 - 71

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
10 дугаар сарын 15-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Ч.Ундрэм;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах гэсэн горимын санал гаргав.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, О.Батнайрамдал, Г.Дамдинням нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Рэгдэл, Ж.Галбадрах, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, О.Саранчулуун, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Г.Дамдинням: Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 0
Бүгд: 11
100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Боловсролын зээлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Найдалаа, О.Саранчулуун, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, О.Батнайрамдал, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Д.Бум-Очир, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Б.Хэрлэн, Г.Дамдинням нар үг хэлэв.

Г.Дамдинням: Боловсролын зээлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 0
Бүгд: 11
100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуултын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Бум-Очир, Ц.Мөнхтуяа, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд асуултын хариу, мэдээлэлтэй танилцав.

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 15 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 04 минут

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Дамдинням: Өглөөний мэнд эрхэм гишүүд ээ,

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болж, гишүүдийн ирц хүрсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц. Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн байна, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн байна, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн байна, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн ирц 66.7 хувьтай болсон тул Байнгын хороо оны хуралдаан эхэлснийг мэдэгдье. /алх цохив/

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэхэд 3 асуудалтай. 4 асуудал байсан. Нэгийг нь хойшлуулчихъя гэж ярьж байна.

Нэг. “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур

байрны нүхэн жорлонг орчин үеийн шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батална.

Хоёр. “Боловсролын зээлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл батална.

Гурав. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт. “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл батлах тухай байсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо цаглаврыг өөрсдөө нэгтгээд явчихъя гэсэн ийм хүсэлт тавьсан учраас энэ асуудлыг хойш тавья.

Ингээд үндсэн гурван хэлэлцэх асуудалтай байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. . /алх цохив/

Хэлэлцэх асуудлын дөрөвт байгаа асуудлыг хойшлуулах горимын саналтай байгаа. Үүнийг даргын дэргэдэх зөвлөлөөр орчихсон байгаа. Хэлэлцэх асуудлын дараалалд.

Тэгээд үүнийг бид Байнгын хороогоороо санал хурааж байж хойшлуулдаг ийм дэгтэй.

Тэгэхээр хуралдаан даргалагчийн зүгээс дөрөвдүгээр асуудал буюу “Цаглавар батлах тухай” байнгын

хорооны тогтоолын төслийг хойшлуулах горимын санал оруулж байна.

Горимын санал дээр асуух саналтай гишүүн байхгүй байгаа. Санал хураалт. /алх цохив/

Д.Бум-Очир, О.Батнайрамдал, Г.Дамдинням нарыг оруулаад 100 хувийн саналаар хойшлуулах санал дэмжигдлээ. Протокол тэмдэглэчихье.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл
/Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий/

Нэг.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулья.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 2хоёрдугаар зүйлийн 22.3.3, 22.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилтын хүрээнд туссан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн

стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Ч.Ундрам Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга. Гишүүд Ц.Мөнхтуяа, Д.Рэгдэл, М.Сарнай, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх холбогдох байгууллага албан тушаалтныг тухай бүр татан оролцуулах ажлын хэсэг Ч.Ундрам зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төслийг Та бүгдэд танилцуулж байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг батлах санал хураалт явахаас өмнө одоо энэ дээр хэлэлцүүлэх

байлгүй дээ. Бодвол. Хэлэлцүүлгийг нь хийх байх.

Тогтоолын төслийг танилцууллаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Д.Рэгдэл гишүүнээр тасаллаа. /алх цохив/ Ж.Галбадрах гишүүн орж байгаа юм байна. Тийм ээ. Ж.Галбадрах гишүүнээр тасаллаа. /алх цохив/

С.Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

Байж байгаарай. Асуултын өмнө. Түр байж байгаарай. Ажлын хэсгийг оруулъя даа. Тэгье. Тийм. Асуулт асуух юм чинь. Ажлын хэсэг хаана байна.

Ажлын хэсгийг оруулчих. Ажлын хэсгийг танилцуулъя.

П.Наранбаяр Боловсролын сайд, Улсын Их Хурлын гишүүн, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга ирээгүй байна. Т.Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга ирсэн байна, Т.Оюунаа Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга ирээгүй байна Ж.Ариунболд Дээд боловсролын газрын дарга ирсэн байна. Б.Энхбаяр Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга ирээгүй байна. О.Сийлэгмаа Боловсролын зээлийн сангийн дарга ирсэн байна.

Ирээгүй хүмүүсээ ирүүлээрэй яамныхан.

Асуулт хариултдаа орёе.
С.Эрдэнэбат гишүүн асууя.

С.Эрдэнэбат: Нүхэн жорлонгийн орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар хангая гээд.

Миний санахын 4 жилийн өмнө Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 100 тэрбумын хөрөнгө оруулалт хийгээд шийдэх ёстой асуудал байсан байх. Тэгээд энэ байдал ямархуу байдалтай байгаа юм? Хэдэд нь бариад хэдэд нь бариагүй юм?

Их Хурлын гишүүдийг ажлын хэсэг байгуулж дэмжлэг үзүүлэх хүртэл нь энэ асуудал юу нь болохоо больчихсон юм гэдэг зүйлийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, ажлын хэсгийг шууд байгуулахын өмнө Байнгын хороонд санал хэлэхэд урьдчилж энэ байдлыг нь танилцуулж байгаад алинд нь орох орохгүйгээ шийдэхгүй бол зүгээр ингээд шууд хуваарилаад шууд байгуул, ингэ тэг гэдэг дээр процессын хувьд бас жоохон ойлгомжгүй байдалтай байгаад байна.

Уг нь энэ асуудлыг Засгийн газраас хэрэгжүүлэх ёстой хүмүүс нь тайлан мэдээллээ өгөөд. Энэ тал дээр нь Их Хурлын гишүүдийн дэмжлэг хэрэгтэй. Энэ тал дээр нь бидний зүгээс ажлын хэсэг гараад яах юм, төсвийг нь нэмж төсөвт оруулах гээд байгаа юм уу гэх мэтчилэн асуудлууд дээр асуулт тавина.

Чухал асуудлын хувьд бол энэ чухал. Хөдөө орон нутагт одоо ялангуяа сум, зах хорооллын дэд бүтцэд холбогдоогүй газар жорлон нолийн асуудал, хүүхдийн асуудал маш чухал.

Тийм учраас энэ тал дээр би нэмэлт тодруулга авч байж. Тэгээд Их Хурлын гишүүд баахан ажлын хэсэг байгуулдаг. Яг юу хийх, яах ийхийгээ урьдчилж зөвлөж ярьж, Их Хурлын гишүүдээс яг ямар дэмжлэг хэрэгтэй болчихоод байгаа юм гэдэг тал дээр нь би

нэмэлт тодруулга авч асуулт асуумаар байна.

Г.Дамдинням: Эхний асуултад яамнаас хэн хариулах юм. Ажлын хэсгийн 8. Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир хариулъя.

Т.Ням-Очир: Та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая. С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих зорилт дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газраас 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлаад, энэ төслийг 4 үе шатад хувааж хэрэгжүүлэхээр төсөл батлагдсан.

Нэг, хоёрдугаар ээлжид нийтдээ 373 объектыг шинэчлэх. Тэгээд үлдсэн гурав, дөрөвдүгээр ээлжид нэг ч сургууль, цэцэрлэг, дотуур байр үлдээхгүйгээр Монгол Улсын хэмжээнд бүх орон нутгийн сургууль, цэцэрлэгүүд орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болохоор энэ төслийг баталсан байдаг.

Нэг, хоёрдугаар ээлжийн жагсаалтыг орон нутгаас гаргуулж аваад түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр энэ худалдан авах ажиллагааг зарласнаас шалтгаалаад энэ төсөл, хөтөлбөрт нэлээн асуудлууд үүссэн.

Өнөөдрийн байдлаар 142 сумын 424 объект орчин үеийн болоод ашиглалтад орчихсон, үйл ажиллагаагаа

хүүхдүүддээ, багш нартаа үйлчлээд явж байгаа.

Комисс ажиллахад бэлэн болоод хүлээж авахад бэлэн болсон 72 объект байгаа. Өөрөөр хэлбэл 4 жилийн хугацаанд нүхэн жорлонтой байсан 800 гаруй цэцэрлэг, сургууль, дотуур байраас өнөөдрийн байдлаар 500 орчим нь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болчихсон.

241 объектын барилга, байгууламжийн ажил үргэлжлээд явж байна. 21 объект дээр тендер зарлачихсан. Ажлын зураг магадлал хянагдаж байгаа 37 объект, гэрээ цуцлагдаад дахин зарлах процесстой 26 объект гээд ийм нөхцөл байдалтай явж байгаа.

Өнөөдрийн байдлаар эхний батлагдсан 100 тэрбум төгрөгөөс 72 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдчихсон. Яг гүйцэтгэлээрээ санхүүжилт нь олгогдоод явж байгаа.

Гурав, дөрөвдүгээр ээлжийг зураг төсвийг нь хийгээд, зураг төсөв батлагдсаны дараа тендер зарлагдаж байгаа учраас гурав, дөрөвдүгээр ээлж дээр ямар нэгэн асуудал үүсэхгүй байгаа.

Одоогоор ашиглалтын нөхцөл байдалдаа харахад нэгэнт олон жил бид нүхэн жорлонд тоо явчихсан. Шинээр орчин үеийн ариун цэврийн байгууламж орж байгаатай холбогдуулаад өвлийн хэт хүйтрэлтэй холбогдуулаад хөлдөх барих гээд гээд янз бүрийн асуудлууд үүсэж байгаа учраас цаашдаа ашиглалтын зардал, хүний нөөцүүдийг мэргэшүүлэх арга зүйн дэмжлэгүүд үзүүлэх чиглэлийн ажлууд хэрэгтэй байгаа гэж хэлж болно.

Г.Дамдинням: Т.Ням-Очир оо, чи яг одоо хэдэн хувьтай явж байгаа юм. Энэ гишүүний асууж байгаа асуултад маш тодорхой хариулаадхаач.

Энэ хэзээ дуусахаар төлөвлөж байгаа юм. Та нар. Ажлын хэсгийн 8.

Т.Ням-Очир: Ер нь 796 объект одоо яг жагсаалтад байгаа. Үүнээс 424 нь ашиглалтад орчихсон. 72 нь ашиглалтад оруулах комисс ажиллахад бэлэн болчихсон гэхээр 60 хувь хүрчихсэн байгаа. Гүйцэтгэлийн явц.

Бид 2024 оны 11 дүгээр сард багтаагаад гүйцэтгэлийг 80 хувьдаа хүргэчихнэ гэсэн зорилт дэвшүүлж ажилласан. Тодорхой санхүүжилтээс шалтгаалаад яг 80 хувьдаа одоогоор хүрээгүй байна.

Гэхдээ бид 11 сар хүртэл 72 объектоо ашиглалтад хүлээж авах 241 объектоо шахаж ажиллах юм бол 80 хувьдаа хүргэнэ гэсэн зорилттой. 2025 оны 6 сар гэхэд бүрэн дуусах боломжтой.

Г.Дамдинням: Нэгдүгээр асуулт болсон уу? С.Эрдэнэбат гишүүн.

Хоёрдугаар асуултад би хариулчихъя даа.

Нэгдүгээрт, нүхэн жорлонтой холбоотой энэ асуудал манай, ялангуяа орон нутагт ажиллаж амьдарч байгаа хүний хүүхдүүдэд, дотуур байранд ажиллаж амьдарч байгаа, хүүхдүүд нь дотуур байранд байдаг хүүхдүүдийн, ялангуяа охидуудын хувьд үнэхээр чухал юм билээ.

Өнгөрсөн 2020-2024 оны Их Хуралд бид, манай ялангуяа эмэгтэй гишүүд Б.Баярсайхан, Ч.Ундрэм,

Б.Жаргалмаа гээд манай хуучин гишүүд их анхаарал тавьж манай Байнгын хорооны гишүүд энэ дээр анхаарал тавьж явж байгаад Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс нийгмийн хариуцлагын хүрээнд энэ зардлыг гаргуульга гэж яриад улс орон даяар боловсон нольд хүүхдүүдээ ордог болгоё гэдэг ийм зорилго тавиад ажилласан.

Харамсалтай нь манай Боловсролын яам энэ дээр их сэтгэл дутуу ажилласан юм. Сэтгэл дутуу ажилласан юм.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг хууль батлах.

Хоёрдугаарт, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх ийм л үндсэн үүрэгтэй ажил бид хийж байгаа хүмүүс. С.Эрдэнэбат гишүүн ээ.

Тэгээд яах вэ улсын үйлдвэрийн газраас гарч байгаа төрийн бодлогоор хэрэгжиж байгаа ажил учраас хуулийн дагуу Улсын Их Хурал хэрэгжилтийг нь шаардах бүрэн эрхтэй.

Тэр хүрээнд өмнөх Улсын Их Хурлын даргын захирамжаар хамтарсан ажлын хэсэг Улсын Их Хурлаас гараад ажиллаад явж байсан юм.

Одоогийн байдлаар ажлын явц 60 хувьтай яваа юм байна. Үлдсэн 40 хувь дээр нь шахаж шаардаад явахгүй бол болдоггүй юм.

Ялангуяа энэ тойрогтой гишүүдийн хувьд очоод уулзахад ард иргэд аягүй их нэхдэг байхгүй юу, хөөрхий. Яачхав аа, энэ чинь яагаад хийгдэхгүй байна. Сайн болсонгүй ээ гээд.

Тэгээд одоо Их Хурлын тухай хуулиар, Үндсэн хуулиараа ч тэр өмнөх парламентын бүрэн эрх дуусахаар бүх ажлын хэсгүүд бүгдээрээ хүчингүй болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ шинэ парламент бид гарч ирээд ажиллаад үндсэндээ хоёр дахь, гурав дахь хурлаа л хийж байна шүү дээ.

Тэгээд Байнгын хорооны дарга Ч.Ундрам гишүүний санаачилгаар ажлын хэсгийг дахин байгуулаад үргэлжлүүлээд ажиллая гэдэг ийм зорилготой.

Хоёрдугаарт, Ч.Ундрам гишүүн гадагшаа явах ажилтай. Яаралтай явсан байгаа. Чөлөө авсан байгаа.

Тэгээд намайг энэ Байнгын хорооны хурлыг удирдах ийм хүсэлт тавьсан. Их Хурлын даргатай зөвшилцөөд.

Ч.Ундрам гишүүнийг би та бүгдтэй зөвлөөд энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон. Одоо оруулж ирж байгаа байх гэж бодож байна. Та орох боломжгүй бол бас нэрээ хасуулж болно. Ийм боломжтой байгаа. Тийм.

Д.Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа.

Тэгэхээр би бол дотуур байрны хүүхэд байгаа юм л даа.

Тэгэхээр бид нарын үед дотуур байранд ер нь орчин үеийн ариун цэврийн байгууламжийн тухай ямар ч ойлголтгүй л байсан. Харанхуй. Зүгээр нүхэн жорлон олох уу, үгүй юу гэсэн асуудал байсан.

Тэгэхээр ахиц дэвшил явж байна. Харьцангуй удаан явж байна.

Удаан явах учир шалтгааныг нь би бас дотуур байрны хүн байсан учраас мэдээд байгаа юм.

Зүгээр миний асуулт юу байна вэ гэх дээр зэрэг одоо ингээд улсын хэмжээнд тэр 700 гаруй сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг 100 хувь орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих яг бодит боломж байдаг юм болов уу, үгүй юм болов уу?

Би бодоход энэ нэлээн амар биш асуудал санагдаж байгаа. Жишээлбэл, Говь-Алтай аймгийн Халиун сумын Олон булаг баг гэж байна.

Тэр бол 10 хүүхэдтэй сургуультай байгаа юм.

Тэгэхээр тэнд яг орчин үеийн байгууламж байгуулах боломж нь ямар байдаг юм. Тэрийг байгуулахад их хүнд нөхцөлтэй хэчнээн объект байдаг юм бол? Түүнийг нэг тодруулж өгөөч.

Г.Дамдинням: Сайд хариулах юм уу? П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Энэ таны хөндөж байгаа үнэн. Бодитой байдал дээр их бэрхшээлүүд учирч байгаа нь үнэн.

Гэхдээ 2025 оны 6 сар гэхэд 100 хувь дуусгахаар ажиллаж байгаа. Энэ ажил ч гэсэн явж байгаа. Боломж бол бий.

Зүгээр зарим нэг асуудал нь нэгдүгээр ээлжийн ажлыг хийхдээ тухайн үед түлхүүр гардуулах гэсэн ийм юугаар

зураг төсөвгүй хийсэн нэг ийм жорлонгууд асуудал үүсгээд байгаа.

Одоо тухайн орон нутгийн нөхцөл байдалд нь тохирсон зураг төсвүүд хийгдчихсэн. Яг түүнийхээ дагуу 27 аж ахуйн нэгж орж ирээд ажиллаж байгаа. Заримд нь жишээлбэл зөөврийн байдлаар шийдэх ч юм уу, ийм байдлаар.

Тэгээд хамгийн бэрхшээлтэй асуудал нь зарим суманд ерөөсөө ийм ус суваг байгаагүй. Тэгээд тэнд мэргэжилтэн байхгүй гэсэн ийм асуудал бас байгаад байдаг.

Өөрөөр хэлбэл слесарь ийм хүмүүс байхгүй. Ялангуяа хэрэглүүлэх тал дээр бид сургалт явуулж энэ тал дээр хүмүүст зөв ойлголт өгөхгүй бол бас энэ чинь нийтийн жорлон учраас хэрэглэх дээрээ энэ дээр давхар дадуулах ажлууд явж байгаа.

Тэгэхээр бодитой боломжууд байгаа. Тэр боломжоороо хийж байгаа. Энд эргэлзэх хэрэггүй.

Харин зураг төсвүүд өөр өөрөөр гарч, яг орон нутагт нь тохирсон байдлаар шийдэж байгаа гэдгийг л танд хэлье. Баярлалаа.

Г.Дамдинням: Д.Рэгдэл гишүүний асуулт тоо асуугаад байна шүү дээ. Яг ямар газруудад байгаад байдаг юм бэ? Гишүүдийн асуултад тодорхой хариулчихвал зүгээр байдаг юм шүү. Төөрүүлээд байлгүй. Хэн хариулах юм. Т.Ням-Очир уу? Ажлын хэсгийн 8 хариул.

Т.Ням-Очир: Түрүүн сайдын хэлснээр говийн бүсэд яг ямар технологи хэрэгтэй вэ? Газар, геодези, хөрсний шинжилгээ хийгдээд, энд зөөврийн байна

уу, септик байна уу, яг энэ чиглэлээр нь юунуудыг нь хийгээд.

Тэгэхээр одоо яг жагсаалтад бид 796 цэцэрлэг, сургууль, дотуур байрны жагсаалтыг гаргахдаа орон нутгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулаад, Газрын харилцаа, хот байгуулалтын газрыг нь оруулаад, яг энд хийж болох бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрны жагсаалтыг гаргаад, болно гэдэг дээр нь жагсаалтыг сайдын тушаалаар батлаад, жагсаалт гараад ирмэгц зураг төслөө зарлаад, мэргэжлийн компаниуд зураг төслөө хийгээд, Барилгын хөгжлийн төв эцэслэж магадлаад, тендер зарлаж болно гэдэг зөвшөөрөл зарлагдаж явж байгаа.

Г.Дамдинням: Т.Ням-Очир оо, П.Наранбаяр сайд аа, тоог нь өгөөч. Тоог нь мэдэхгүй байгаа бол мэдэхгүй байгаагаа хэлчих.

Наад ажилтайгаа чи 4 жил зууралдлаа шүү дээ. Т.Ням-Очир оо. Сайд бас энэ дээр очоод л, манай эмэгтэй гишүүдийн хамгийн их ярьдаг асуудал шүү дээ. Тоог нь өгчхөөч энэ хүмүүст. Байгаа юм уу, байхгүй юм уу. Микрофон дээр хэл. Ажлын хэсгийн 8.

Т.Ням-Очир: “Зөөврийн”, “септик”, “эколос” гээд яг технологийнх нь шийдлээр нь тоог нь гаргаж өгье.

Г.Дамдинням: Техникийн боломжгүй байгаа юмнууд гэж. Орчин үед чинь барилгын технологи чинь их мундаг л болчихсон шүү дээ.

Т.Ням-Очир: Тийм. Техникийн боломжгүй гэдэг зүйл бараг байхгүй.

Г.Дамдинням: Тийм. Тэр тоонуудыг нь нарийн өгөөч. Та нар.

Т.Ням-Очир: Тэгье.

Г.Дамдинням: Хэдүүлээ тэгээд хурлаа бас нэг гурилдаж хийгээд яах вэ дээ. Хүмүүс юм асууж байгаа бол.

Д.Рэгдэл гишүүн тодруулах юм уу? Ж.Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Энэ өглөөний мэндийг хүргэе. Та бүхэндээ.

Нүхэн жорлонг арилгах энэ асуудал маш чухал асуудал. Би өөрөө хөдөө орон нутгаар 60 сургуулиар тойроод, яваад. Миний тэр төсөл хэрэгжүүлж байсан сургууль дээр хэд хэдэн сургууль таарсан.

Түүн дотроо бас гайгүй явж байгаа. Дундговийн Луус сум ч гэдэг юм уу.

Гэтэл бас хөлдөөд зогсчихсон нолиуд бас харагдсан. Тэр нь эргээд сургуульдаа хүндрэл учруулчихсан байх жишээний ийм зүйлүүд гарсан.

Тэгэхээр энд нийт хэдэн сургууль яг хамруулаад байгаа юм бэ гэдгийг түрүүн 800 сургууль гэсэн зорилго тавьсан гэж байна. 792 гэгчхэв үү. Тийм ээ. Түүнээсээ 400 хэд нь ашиглалтад орчхоод байна гэж байна.

Тэгээд 400 хэдэд нийтдээ 72 тэрбум төгрөгөө зарцуулчихсан байна гээд бодохоор нэг сургуульд ойролцоогоор 200 сая төгрөгөөр энэ нолийг бариад байна уу. Ойролцоогоор. Тийм ээ.

Тэгэхээр дундаж зардал нь. Энэ бол мэдээж тэр технологийнхоо шийдлээс тэр 3, 4 шийдэл хэлж байна.

Тэгээд энэ шийдлээсээ хамаараад үнэ өртгийн асуудал яригдаж байгаа байх.

Тэгэхдээ яг өвөл болоод, яг хэрэгцээтэй үе дээрээ ашиглалт багатай болчхоод байгаа гэдэг ийм зүйлүүд яригдаад байгаа.

Тэгэхээр өнөөдөр ашиглалтад өгчхөөд байгаа гэдэг энэ тоонууд дотроос хэчнээн нь яг хүчин чадлаараа ажиллаад байна, хэд нь ажиллахгүй ахиж бид засвар хийх, засах залруулах шаардлагатай болчхоод байгаа юм. Тэр тоог би бас сонсмоор байна.

Тэр хөрөнгийн эх үүсвэр бас ахиад хаанаас гарах вэ гэдэг асуудлыг бас асууя гэж ингэж бодож байна.

Технологийн шийдлийн хувьд эхний нэг, хоёрдугаар үе дээр тэр зураггүйгээр, түлхүүр хүлээлгэж өгөхөөр хийсэн байгаа гэж ярьж байна.

Тэгвэл өнөөдөр бид одоо яг зураг шийдлийнх нь хувьд ямар юм байна?

Саяхан “NHK” /Nippon Hoso Kyokai/ телевизээр монгол залуу хөдөө орон нутгийн дотуур байр, сургуулийн нолийг эко байдлаар шийдсэн С.Ган-Од гэж залуугийн тухай нэвтрүүлэг гарч байна лээ.

Тэр Хөвсгөлийн 2, 3 ч сумд очоод ширээ, сандлыг нь шийдээд явж байсан.

Тэгэхээр тэр технологи энэ тэр. Тэр бол өтгөн нь нэг талаараа гараад. Өтгөнийг нь нөгөө бактери энэ тэрээр тэнд нь булчихдаг. Шингэн нь өөр сувгаар орж ирээд шингэн нь гараад явчихдаг.

Тэгэхээр тэр бол нэлээн удаан ашиглалттай гараад. Тэгээд хэчнээн хүүхэд байх вэ гэдгээсээ хамаарч тэрийг нь гаргаж ирж байгаа зүйлийг бас харж байсан л даа.

Тэгэхээр технологийн шийдэл талаас нь бас нэг жоохон ойлголт өгвөл сайн байна гэж бодож байна.

Тэгээд ашиглалт нь ер нь.../минут дуусав/

Г.Дамдинням: Т.Ням-Очир.
Ажлын хэсгийн 8.

Т.Ням-Очир: Ж.Галбадрах
гишүүний асуултад хариулья.

Бид 2024 оны 4 сард эхний ээлжийн ашиглалтад орсон 296 объект дээр ашиглалтын нөхцөл байдлын судалгаа хийж үзсэн. Нийт 296 объектын 35 хувь дээр нь ямар нэгэн засвар үйлчилгээ, гүйцэтгэгчээс шалтгаалсан нэмэлт ажил хийх шаардлагатай байна гэдэг үр дүн гарсан.

Энэ 296 объектоос 35 сум дээр, 35 объект дээр хөлдөлт үүссэн. Өөрөөр хэлбэл өвлийн хэт хүйтрэл, хүндрэлтэй үеийг, одоо тэр цэвэр усны шугам, бохирын шугам хоолойнууд тэсвэрлэхгүй нөхцөл байдал дээр хөлдөлт үүссэн.

Хөлдөлтийн нөхцөл байдал нь ашиглагч талаас байна уу, гүйцэтгэгч талаас байна уу гэдгийг нь ажлын хэсэг газар дээр нь үзээд гүйцэтгэгч талаас байсан бол ашиглалтын 3 жилийн хугацаан дахь гүйцэтгэгч нарт шаардлага тавьж алдаануудыг өөрчилсөн байгаа.

Энэ 296 объектын хүрээнд 1754 угаалтуур, 1960 орчим суултуур гэх мэтчилэн ашиглалтад орсон.

Эндээс хагарсан, эвдсэн, гэмтсэн суултуур, угаалтууруудыг нөхөн засварлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нэг, хоёрдугаар ээлж дээр дийлэнх нь “эколос” гээд тоног төхөөрөмжийг суурилуулсан байдаг.

Үүнтэй холбоотойгоор яг “эколос” гээд энэ тоног төхөөрөмжийг цахилгаан тасарвал яах вэ, бөглөрвөл яах вэ, хөлдөлтийн үед яах вэ гэдэг гарын авлага, зөвлөмжүүдийг гаргаж орон нутаг болгон дээр нэг хүнийг бэлтгэж өгсөн байгаа.

Энэ хүрээнд нэг, хоёрдугаар ээлж дээр ихэвчлэн “эколос” явж байгаа.

Гурав, дөрөвдүгээр ээлж дээр. Түрүүн хэлдэг. Яг газар дээр нь очиж хөрс усны судалгаа, бүх төрлийн судалгаануудыг аваад, одоогийн байдлаар ирж байгаа зургууд бол ихэвчлэн “септик” суулгахаар ийм зураг төслүүд ирж байгаа ийм нөхцөл байгаа.

Тэгэхээр одоо бол “эколос”, “септик” гэсэн хоёр технологийг түлхүү зургийн компаниуд санал болгож тухайн онцлог онцлогтойгоор оруулж ирж зургаа баталж байгаа.

Г.Дамдинням: Ж.Галбадрах
гишүүн тодруулья.

Ж.Галбадрах: Ер нь нэг нольд ер нь хэдэн төгрөг зарцуулж байна?

Тэр дунджийг. Би өөрөө энд бодоод 200 гэдэг нэг тоо хэлээд байна. 200 сая. Тийм ээ. Тэрийг тодруулчихъя.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн 8.

Т.Ням-Очир: Ерөнхийдөө дэлгэрүүлээд жоохон тодорхой.

Эхний ээлжид бид жил болгон 100-аас доошгүй нүхэн жорлон гэдэг зорилт дэвшүүлээд 100 тэрбум төгрөг Эрдэнэт үйлдвэрээр батлуулсан.

Энэ хүрээндээ нэг, хоёрдугаар ээлж түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарласан учраас зураг төсөв араас нь хийгдсэн. Үүнтэй холбоотойгоор 2024 оны нэг сард Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч, 160 тэрбум төгрөг. Нэмэлтээр 60 тэрбум төгрөг баталсан.

Одоо жагсаалт эцэслэгдээд 800 орчим объект гэж батлагдаад, ингээд энэ төслийг гүйцэтгэхэд 160-аас 180 тэрбум төгрөг байхад энэ төсөл бүрэн дуусаж, Монгол Улсын хэмжээнд нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байр үлдэхгүй юм байна гэсэн ийм тооцооллын гаргасан.

Тэгэхээр таны хэлж байгаагаар тухайн зураг төслөөсөө цэцэрлэг, сургууль, дотуур байр гэдгээсээ шалтгаалаад зураг төсөл 180-аас 200 орчим саяын хооронд боловсруулагдаж хийгдэж байгаа.

Тэгээд бид байршил нөхцөл байдлаас нь холбогдуулж багцлаад тендерээ зарлаж байгаа.

Г.Дамдинням: Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Энэ их сайн ажил. Тэгээд би ч одоо их олон сургуулийн нолиор янз бүрийн шалтгаанаар орж үзсэн.

Түрүүн Ж.Галбадрах гишүүн асуучихлаа. Энэ Баянхонгорын хойд тал, Завханы сумууд нэлээн цэвдэгтэй байдаг. Сум сумаар нь нэрлэвэл.

Тэгээд очихоор нөгөө бие засах ариун цэврийн байгууламж нь хөлдчихсөн, ажиллаж өгдөггүй ийм сумууд миний мэдэхээр байгаа.

Сая тэгээд Т.Ням-Очир дарга ерөнхийдөө хариулж байх шиг байна. Яг энэ цэвдэгтэй сумууд дээр ямар технологи хэрэглэж байгаа вэ? Нөгөө халаасгуур утас энэ тэр явуулдаг. Тэр нь ажилладаггүй гээд. Очихоор хөөрхий бөөн зовлон тоочоод сууж байдаг.

Тэгэхээр тэр цэвдэгтэй сумуудад миний ойлгож байгаагаар арай өөр технологи явах ёстой юм болов уу гэж ойлгоод байгаа юм. Тэр асуудлаа шийдэж чадсан уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Сургуулийн слесарийн асуудал юу болж байгаа вэ?

Мэдээж ариун цэврийн байгууламжтай хотын сургуулиуд слесарьтэй. Орон тооны ч юм уу хүмүүс байдаг болов уу гэж бодож байна.

Сумд чинь угаасаа ариун цэврийн байгууламж байхгүй байсан учраас орон тоо нь слесарь гэж байдаггүй юм байна гэж би ойлгосон.

Тэгэхээр нэгэнтээ ариун цэврийн байгууламжтай болохоор нөгөөдөх нь эвдрэл гэмтэл, урсгал засвар гээд янз бүрийн асуудал гардаг. Тэрийг нь мэддэг хүн байдаггүй.

Тэгээд орон тооны слесарь тавьж өгөх юм уу, яаж шийдэж байгаа юм бол? Энэ хоёр дахь асуулт.

Гуравт нь, би хэрвээ буруу ойлгосон байвал та бүхэн залруулаарай. Зарим сургууль, цэцэрлэгүүд ариун цэврийн байгууламж нэмэлтээр хийхэд өрөө талбай, тасалгааны асуудал тулгарсан санагдаад байна.

Тэр чинь угаасаа ариун цэврийн байгууламжтай байгаагүй. Гадаа нүхэн жорлонтой байсан. Шинээр аль нэг өрөө байгуулах, эсвэл шинээр нэг таамбар маягийн юм барих нэг ийм ажлууд гараад байх шиг санагдаад байсан даа.

Үүнийг Боловсролын яам биш орон нутгаас тэр төсвийг нь тавьж өгөөд, орон нутгийн сумд ч юм уу, ямар нэгэн байдлаар төсөв, мөнгийг нь гаргаад нэмэлтээр хажууд нь сургуультайгаа залгаад өргөтгөл маягийн байгууламжууд бариад тэр дотроо ноль хийж байгаа харагдсан.

Энэ ажлыг нь миний ойлгож байгаагаар орон нутаг нь хариуцаж байгаа санагдаад байх юм.

Гэтэл орон нутаг нь хариуцаад заримдаа их тийм, одоо юу гэдэг юм стандартад нийцмээргүй гэх юм уу, ийм байгууламжууд бариад өгчихсөн.

Хөөрхий, сум чинь мөнгөгүй газар. Тэгээд мөнгө төгрөгтөө л баригддаг юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ байгууламжийн асуудал нь, барилгынх нь асуудал юу болж байгаа юм болоо? Иймэрхүү асуудлууд хэр их гарч байгаа вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Тэр эхний асуулттай холбогдуулаад. Тэрийг түр орхичихъё доо. Баярлалаа.

Г.Дамдинням: Т.Ням-Очир уу? Ажлын хэсгийн 8. Гурван асуулт асууж байна.

Т.Ням-Очир: Тийм. Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя.

Түрүүн би хариулахдаа яг жагсаалтыг аймаг дээр батлаад, аймаг дээр жагсаалтаа гаргаад энэ сургууль, энэ цэцэрлэг, энэ дотуур байранд бид хийлгээ гэдэг жагсаалтаа гаргаж ирж байгаа.

Тэгээд сургууль дотроо яг энэ ангиа, энэ нийтийн эзэмшлийн талбайгаа бид ариун цэврийн байгууламж болгож тохижуулж авах хүсэлтэй байна гэдгээ шалгарсан зургийн компанид хэлээд, компани түүн дээр нь зургаа тохируулж хийж байгаа.

Нэмэлтээр барилга, байгууламж гаргах, барих ийм хэрэгцээ шаардлагууд. Хана өрөх, өрөө тасалгааг дундуур нь хуваах шаардлагууд гарч байгаа. Энэ бол бүгд зураг төсөл дотроо ороод явж байгаа.

Түүнээс биш орон нутгаас тусгайлан нэмэлт хөрөнгө гаргаад өөрөө тасалгаа бэлдэж байгаа тохиолдол бараг байхгүй байгаа гэдгийг онцолж хэлэх нь зөв болов уу гэж бодож байна.

Бид ерөнхий боловсролын сургуулийн удирдлагууддаа, цэцэрлэгийн эрхлэгч нартаа хэлээд та нар ялангуяа нэг, хоёрдугаар ээлж дээр ихэвчлэн “эколос” хийгдсэн учраас яг энэ ариун цэврийн байгууламжийн засвар үйлчилгээтэй холбоотой сургуулийн бүтэц, орон тоон дээр байгаа ямар хүнээ давхар бэлдүүлж авах вэ гэдэг судалгааг нь аваад,

▸ зарим нь манаач жижүүрээ давхар бэлдүүлж авъя,

▸ зарим нь цахилгаанчин, мужааны орон тоон дээр байгаа хүнээ давхар бэлдүүлж авъя

гээд нэг удаагийн сургалтыг бид 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулаад.

Одоогоор ямар ч байсан эхний ээлжид ашиглалтад орсон 296 объект дээр хариуцаад ажиллах эхний ээлжийн сургалтаа авчихсан, гарын авлага, зөвлөмжөө авчихсан хүмүүс явж байгаа.

Бид нарт хүндэрсэн зүйл юу гэхээр орон нутгаа жагсаалт гарч ирж байгаа учраас актлагдсан барилга дээрээ хийлгэе гээд жагсаалт өгчихдөг ч юм уу.

Дээрээс нь манай сум нэгдсэн ариун цэврийн байгууламж, дэд бүтэц хийгдэж байгаа учраас тэрийг хүлээнэ гээд хойш нь тавьчихдаг ч юм уу, ийм асуудлууд нэлээдгүй гарсан. Одоо ч энэ асуудлууд байгаа.

Тэр нэгдсэн зураг төсвийг нь хүлээгээд, манай сургууль, цэцэрлэгүүд хүлээгдэж байгаа зүйлүүд байгаа.

Энэ дээр нэлээн тийм хүндрэлүүд гарсан.

Хоёрдугаарт, хамгийн эхний асуултын хувьд мэдээж цэвдэгтэй газрууд дээр бид гүний худаг гаргана. Гүний худгаасаа халаагч юутай барина гээд зураг төсвөө хийчихсэн. Тэгээд 100 метр ухаад ч, 200 метр ухаад ч ус гардаггүй газрууд байгаа.

Тийм учраас зураг төсөв дээрээ тохирвол Барилгын хөгжлийн төвтэйгөө

зөвшилцөөд, зураг төсөв дээрээ өөрчлөлт оруулаад зөөврийн усаар солих ийм зориулалтын зүйлүүдийг яг тэр орон нутгийн онцлогтой, ялангуяа Завхан, Хөвсгөлийн цэвдэгтэй хэсгүүд дээр төлөвлөсний дагуу ус гарахгүй байх.

Тийм учраас хэрвээ бид нарт хэмнэлт үүсэх юм бол зарим сумын сургууль цэцэрлэгүүд дээр зөөврийн усны машин авч өгөх.

Үүнийг зураг төсөвт нь багтааж шийдвэрлэх энэ чиглэлээр судалгаа хийгдэж байгаа.

Г.Дамдинням: П.Наранбаяр сайд нэмж хариулах юм уу? П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэр слесарийн асуудлыг хөндлөө.

Тэгэхээр сая хүргүүлэх сургалтаар бэлдэж байгаа гэдгээс гадна 2018 онд Сангийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн ажилтны жишиг нормативыг тогтоосон байдаг. Үүнийгээ шинэчилж байгаа.

Энэ хүрээндээ сургуулийнхаа суралцагчдын тоог сургуулийн барилгын суурилагдсан хүчин чадлаар тооцсон слесарийн тоог оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр ариун цэврийн байгууламж дээр стандарт тоон дээр байж байх юм бол тэнд слесарь ажиллана гэсэн үг. Ийм байдлаар зохицуулж явж байгаа.

Г.Дамдинням: Хариулт хангалттай байх. Тийм ээ.

Гишүүд асуулт асууж дууслаа.
/алх цохив/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгье. Кнопоо дараарай.

Д.Рэгдэл гишүүнээр хаая.
Б.Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Нүхэн жорлон.

Монгол Улсын Их Хурал дээр “нүхэн жорлон” ярьж байна шүү дээ. Бид. Тэр байтугай ажлын хэсэг томилоод нүхэн жорлонг дэмжих тухай ярих гэж байна шүү дээ.

Энэ бол үнэхээр завхарсны шинж байхгүй юу.

Улсын Их Хурал ажлын хэсэг байгуулаад. Ажлын хэсэг гэдэг чинь ер нь ажил нь явахгүй байгаа газар л байгуулдаг зүйл. Тэгээд нүхэн жорлонг дэмжих тухай. Гишүүд нь ороод ажиллах нь.

Энэ бол харамсалтай. Ер нь бол шившиг.

Тэгэхээр энэ нүхэн жорлон дээр 100 хүүхэдтэй газар 300 хүүхдийн сургууль барьчихсан байж байгаа. 3 давхар гоё байшин. Тэгсэн хэрнээ нүхэн жорлонтой.

Барилгын тэр стандарт, нормд нь энэ байдаггүй юм уу. Одоо болтол.

Тэгэхээр шийдэл нь байхгүй газар нь нэмээд жорлон хийх гээд ухнатаад байх биш, яг тэр стандарт, нормд нь оруулмаар байна.

Байшин барьсан л бол боловсон жорлонтой баймаар байна. Үүнийг хийж байгаа гэж найдаж байна.

Дээр нь “сумын жорлон” биш “сургуулийн жорлон” биз дээ. Яг ингэж хийвэл зөв шийдэл болно.

Бас дахиад. Эрдэнэт үйлдвэрээс 100 тэрбум гээд ярьж байна л даа. Энэ бас л итгэж болмооргүй. Энэ утгагүй зүйл л дээ.

Улсын үйлдвэрийн газар. Тэр чинь компани шүү дээ. Өөрийн бизнестэй, ашиг орлоготой, зорилготой.

Түүнээс ямар нэгэн байдлаар жорлонд байна уу, хандивт байна уу, сумын ойд байна уу, улсын ойд байна уу мөнгө татах нь өөрөө зарчмын хувьд буруу зүйл. Дахиж иймэрхүү юм огт хийхгүй байх ёстой гэж бодож байна.

Тэр компанийн бизнесийг нь хийлгэ л дээ. Төрийн өмчит компанийг хувийн ажилдаа, улсын ажилдаа хольж хутгаад байдаг чинь өөрөө бидний энэ авлигын сүлжээ, бүх юмыг өөхшүүлж байгаа зүйл байхгүй юу.

Тэгэхээр үүнийг болих хэрэгтэй.

Тэгэхээр эцэст нь зүгээр дүгнээд хэлэхэд үнэхээр Монгол Улс хүүхдүүдээ, сургуулиа боловсон жорлонтой байлгаж чадахгүй байгаа нь арчаагүй явдал.

Тэгэхээр одоо үүнийг ажлын хэсэг томилдог л байх даа.

Тэгэхдээ цаашдаа тэр норм дүрэмд нь оруулаад, төсөв зардлыг нь аль нэг газраас биш, гуйлгаар биш, яг тэр сургуулийнх нь байшин барилга, урсгал зардалд нь төсөвтөө суулгадгаар нь суулгаад, зориулалтаар нь ашиглаад явах хэрэгтэй байна.

Тэгээд энэ дээр Боловсролын яам, хариуцаж байгаа хүмүүс анхаарч өгнө үү. Баярлалаа.

Г.Дамдинням: Б.Найдалаа гишүүн. Яах вэ, одоо бас аргагүй л байх.

Зүгээр жорлонгүй болгоё гэж байгаа л ажлын хэсэг л дээ.

Улсын Их Хурал янз янзын л юм ярина.

Гэхдээ Монгол орны зах хязгааргүй энэ өргөн уудам тал нутагт Монголын ард түмний тал нь амьдардаг юм шүү дээ. Б.Найдалаа гишүүн ээ.

Ард түмэн амьдарч байгаа. Зүгээр л жирийн аав, ээжийн хувьд бодоод үзэхэд бид ярих ёстой сэдэв. Би бол үүнээс ичихгүй байна. Манай Байнгын хороо энэ дээр ажлын хэсэг гаргах ёстой. Тэнд олон мянган охид, олон мянган хүүхдүүд тэнд дотуур байранд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр зүгээр энэ “нүхэн жорлонг нь арилгах тухай” асуудлыг стандартад нь оруулаад өгөөч ээ гэдэг таны ярианд санал нэг байна.

Зүгээр үүнийг Их Хурал дээр ярьж байна гэдгээсээ ичээд байх юм бол бид нарт байхгүй байх.

Хоёрдугаарт, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд энэ зардлыг гаргаж байгаа.

Саяхан таны орж ирээд батлалцсан Татварын тухай хууль байгаа. Татварын тухай хуульд бид нэг хувь хүртэл татвар ногдох орлогыг бүх аж ахуйн нэгжүүдэд

- ▶ *хүүхдийн боловсролын чиглэлээр,*
- ▶ *эрүүл мэндийн чиглэлээр,*
- ▶ *ахмадын асрамжийн чиглэлээр,*
- ▶ *спортын чиглэлээр,*
- ▶ *соёл урлагийн чиглэлээр*

зарцуулах юм бол хөнгөлж, чөлөөлж өгдөг тогтолцоог бид сууж байгаад кнопдоод баталчихсан хууль байгаа шүү дээ.

Тэгэхээр дэлхийн аль ч улс оронд ямар ч төрлийн компани нийгмийн хариуцлагын зардал гаргана.

Харин хаанаа гаргаж байна. Гаргасан юмнаас нь хэр хумсалж байна гэдэг бол дараагийн тусдаа асуудал шүү.

Тэгэхээр үүнийг бас ойлгоорой гэж хүсье.

О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Нүхэн жорлонг нь солих тухай маш чухал асуудлыг хөндөж байгаа юм байна.

Тэгээд энд би нэг юмыг бас давхар. Энэ мэргэжлийн хүмүүс нь ирчихсэн, салбарын хүмүүс нь ирчихсэн байгаа дээр хэлмээр байгаа юм.

Их сургуульд оюутнууд нэгдүгээр курст орон нутгаас орж ирдэг. Ариун цэврийн өрөөгөө хэрэглэж чаддаггүй тийм дадал зуршилтай байгаа. Ариун цэврийн суултуур дээрээ гишгээд бохир заваан хэрэглэдэг.

Тэр нь юутай холбоотой гэхээр угаасаа хүүхдүүд орон нутагт нээрээ л нүхэн жорлонд бие засдаг байж байгаад л хотын сургууль руу ирэхээр чинь ариун цэврийн өрөө хэрэглэх дадал зуршил

суугаагүй байгаатай л холбоотой. Ер нь ихэвчлэн тийм байгаа.

Бид жорлонгийн барилга, байгууламжийг шийдчихэж байгаа юм байна. Тэгээд саванг нь одоо яах вэ. 9 сарын эхээр сургуулиудад гар угаах саван байгаад байдаг. Тэгээд л сарын дараанаас саван байхгүй болчихдог шүү дээ.

Тэгээд ер нь манай бүх цэцэрлэг, сургуулийн, ер нь боловсролын байгууллагын ариун цэврийн өрөөнүүдэд саван байдаг юм уу? Тэр саванг нь ер нь яаж шийддэг юм. Тэр саван яагаад дуусаад байдгийг би дандаа гайхдаг.

Тэгэхээр одоо энэ дээр бүр зориуд хэлмээр байгаа юм. Энэ бол савангийн асуудал биш. Энэ чинь томуугийн өвчний асуудал байгаа. Ханиад байна. Дээрээс нь төрөл бүрийн халдварт өвчин байгаа байхгүй юу.

Тэгэхээр гараа угаах дадал зуршил суугаагүй хүүхдүүд халдварт өвчинд илүү өртөмхий л байдаг гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг одоо яг энэ ажлыг хийхдээ жорлонг барих. Тэр суултуурыг. Тийм ээ. Суултууртай баймаар байна. Зарим нь жорлон барьчихсан нэртэй мөртлөө суултуур байхгүй байгаа шүү дээ.

Түүн дээр чинь хүүхэд яаж суух юм. Тийм ээ. Бид өөрсдөө ч гэртээ тийм юман дээр суухгүй шүү дээ.

Тэгэхээр эрүүл мэндийн дадал зуршлийг сайн бий болгохын тулд тэр орчин нь хангагдсан байх ёстой. Бид ганцхан жорлон бариад тэгээд тэр хүүхэд гараа угаадаг болоод, бүх юм нь шийдэгдээд давхар давхар бүх юмыг нь оруулж өгөхгүй бол.

Жорлон барьсан ч гэсэн саван байхгүй. Тэгээд дутуу дулимаг юм хийх вий дээ. Одоо нэгэнт нэгмөсөн хийж байгаа юм чинь бас нэг бүрэн сайхан жорлонтой, савантай, кранттай, бүлээн устай болмоор байна шүү.

Энэ дээр жилаад өгөөч ээ. Энэ мөнгө төгрөг нь ер нь хаанаас гардаг юм. Үүнийг бол би дандаа асуумаар байдаг юм. Тэгээд өнөөдөр ёстой сайхан боломж гарлаа гэж бодож байна.

Тэгээд түрүүн асууж амжсангүй. Тэгээд санал хэлье. Монгол Улсаараа гараа угааж чадахгүй байгаад байна шүү дээ. Хүүхдүүд бол.

Тэгээд одоо ингээд хамгийн оргил үеэр хүйтрэхээр хүүхдүүд өвддөг. Тэр чинь хүйтэнд гарч бие засаад гараа угаах манатай байгаа байхгүй юу.

Тэгээд тэр үеэр чинь халдварт өвчин бүр өснө. Томуу, ханиад чинь гар угаахаас болж өвддөг шүү дээ, халдварладаг шүү дээ. Хүмүүс ээ.

Ийм л юм байна даа. Савангаа л шийдчихмээр байна. Бас давхар.

Г.Дамдинням: О.Саранчулуун гишүүн маш тодорхой чухал санал хэллээ.

Миний ойлгож байгаагаар Боловсролын ерөнхий хуульд “аж ахуйн зардлаа өөрсдөө хагас бие даасан тогтолцоогоор шийддэг болсон” гэж ойлгож байгаа. Тийм ээ.

Тэрийгээ төсөвтөө төсөвлөөд явж байгаа байлгүй дээ.

Д.Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ их чухал ажил.

Тэгэхээр бид жорлонг ярихдаа ерөөсөө ичиж болохгүй байгаа юм. Тийм.

Улаанбаатар хотын хувьд энэ орчны бохирдол гээд л энэ нүхэн жорлон, 200-аад мянган нүхэн жорлон чинь үнэхээр гамшиг л болоод байгаа.

Гэхдээ бидний ярьж байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг өөрчлөх асуудал үүнээс илүү чухал гэж би бодоод байдаг юм.

Хөдөө яваад үзэхэд 8 настай эгч нь 6 настай дүүтэйгээ дотуур байранд байж байгаа. Тэд нар чинь тэр нүхэн жорлонд хоёулаа унаад сүйд болно шүү дээ.

Тэгэхээр энэ их сайн ажил.

Манай яамныхны хариултаас харахад ямар ч байсан энэ ажлаа шат шатаар сайжруулаад яваад байгаа юм гэсэн ойлголт төрлөө. Одоо ингээд хамгийн чухал асуудал бол хөлдөөхгүй байх тухай асуудал.

Тэгэхээр хариуцах хүний тухай асуудал энд чухал байдаг юм.

2008, 2009 онд эрдэмтдийн баг нийлж байгаад цөөн хэдүүлээ хангайн бүсэд нэг сумд, говийн бүсэд нэг сумд ус цэвэрлэх байгууламж хийж өгсөн юм. Жижигхэн.

Тэгээд тэр чинь говийн бүсийн сумын нөхөр бол ус цэвэрлэх байгууламжийн дараа сумынхаа эмнэлгийн сувилагчийг ажиллуулаад, орон тоогоор нь. Тэр 8 жил дээд зэргийн усаар сумаа хангаж чадсан.

Хангайн бүсийн нөхөр бол зүгээр нэг хүн гуйж тавьснаас болоод жилийн дараа тэр байгууламж байхгүй болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ “хариуцах хүний асуудал” дээр бас их анхаармаар санагдаад байгаа юм.

Ажлын хэсэг байгуулах саналыг дэмжиж байна. Тэгэхдээ П.Наранбаяр сайд дараа нь энэ ажлын хэсэгт яг Их Хурлын зүгээс ямар дэмжлэг их чухал байна вэ гээд тодорхой санал бичээд бичгээр ч болсон өгчихвөл бид чинь тэр дагуу нь мэргэжлийн хүнийхээ санал дээр үндэслээд бас үр дүнтэй ажил хийж болох байх гэж бодож байна.

Тэгэхээр тогтоол гаргахыг дэмжиж байна.

Г.Дамдинням: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсэг маань томилогдоод гараад явахаар. Ер нь юу шүү. Манайхан. Бас нэг хэлчихье. Зүгээр.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль гэж өнгөрсөн парламентын үед батлагдсан юм.

Тэгээд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үндсэн зорилго нь ерөөсөө л энэ.

Манай Д.Рэгдэл гишүүн Засгийн газрынхнаас яг юун дээр нь. Одоо манай зарим нэг гишүүд хэлээд байна. Юун дээр нь Их Хурлын гишүүдийн дэмжлэг хэрэгтэй байна гээд асуухаар наадуул чинь бид мундаг байгаа л гэж хэлэх байх.

Тэгэхээр бид өөрсдөө хяналт шалгалтынхаа хуулийн хүрээнд хэрэгжилтийг нь шууд өөрөө шалгаад ажлын хэсэг дээрээ яриад ингээд Байнгын хороогоороо хэлэлцээд явах нь зохицлын хувьд зөв болох байх л гэж бодож байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсэгт өөр нэмж орох саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 100 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Боловсролын яам болон ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд энэ гишүүдийн ярьж байгаа санал бодлыг сонсож, бас ажлын хэсэг дээрээ тодорхой ажлын төлөвлөгөө гаргаж танилцуулаад Байнгын хороонд танилцуулах чиглэлийг өгчихье.

Дараагийн асуудалдаа орёе.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл
/Боловсролын зээлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

“Ажлын хэсэг байгуулах тухай”.
Хоёрдугаар асуудал.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, Боловсролын зээлийн сангийн журмын биелэлтэд хяналт, шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл

боловсруулах үүрэг бүхий Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

О.Батнайрамдал Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ш.Бямбасүрэн Улсын Их Хурлын гишүүн

Д.Бум-Очир Улсын Их Хурлын гишүүн

Б.Найдалаа Улсын Их Хурлын гишүүн

Б.Хэрлэн Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх холбогдох

байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг О.Батнайрамдалд зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл орж ирж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Ж.Галбадрах гишүүнээр тасалъя.
С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ нэлээн чухал, нийгмийн сэдэв болсон асуудал.

Бараг өнгөрсөн 30 жил дээр хүртэл дүгнэлт хийх ёстой.

Эргээд харахаар үүний өмнөх Боловсролын сайд анх мэдэгдэж байсан. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Боловсролын зээлийн сангаас зээл авсан хүмүүс 70 хувь нь мэдээлэлд ойрхон дарга, эрх мэдэлтэй хүмүүс, төлбөрийн боломжтой компанийн захирал, удирдлагууд авсан байна гэдэг ийм дүгнэлтийг ярьж байсан.

Тэгэхээр энэ үнэхээр харамсалтай л зүйл л дээ.

Тийм учраас цаашдаа миний саналаар одоо нэгдүгээрт тэр зээлээ төлөөгүй байгаа хэчнээн хүн байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт. Одоо энэ төлбөрийн зээлийн журам дээр аваад үзэхээр яг ямар журам, шалгуураар энэ зээлийг олгож байгаа вэ?

Тодорхой санал хэлэхэд хэдэн жилдээ боловсрол, эрүүл мэндийн салбар гээд энэ салбарууд чинь ерөөсөө бараг энэ зээлийн сангийн журамд хамрагдаагүй, бид багш нараа гадагшаа, дотогшоо сургаагүй ийм зүйл байгаа.

Тэгэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт багш нар, эрүүл мэндийн салбар, тэгээд чухал хэрэгцээтэй, эргэж ирдэг, тэр нь өөрөө эргээд олон хүнд хүртээмжтэй байдаг ийм салбарууддаа энэ зээлийн багцыг нь гэдэг юм уу, тодорхой секторыг нь гэдэг юм уу, өгчихвөл яасан юм бэ.

Ийм боломж байгаа юу. Эсвэл одоогийн байгаа журмаар ер нь хамгийн топ сургуулиуд гээд яваад байдаг.

Сурч байгаа чиглэлийг нь харахаар дандаа л янз бүрийн төдийлөн чухал биш ийм салбарууд руу түлхүү олгоод яваад байх байдал ажиглагдаж байгаа.

Тэгэхээр цаашдаа ер нь боловсролын зээлийн сангийн олгох зээлийг тодорхой секторлож олгох боломж бололцоо дээр ямар төлөвлөгөө байгаа вэ?

Г.Дамдинням: Хэн хариулах юм? П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Тэгээд манай ажлын хэсгийн О.Сийлэгмаа Боловсролын зээлийн сангийн дарга ирсэн байгаа учраас тодорхой нарийвчилсан тоо баримтыг хэлээрэй.

Ер нь Боловсролын зээлийн сан чинь зөвхөн тэр шилдэг 50 сургуульд тэнцсэн хүнд зориулаагүй.

29 төрлийн үйлчилгээ хийж байгаа. 29 төрлийн.

Тэгээд тэр дотор нь:

▷ багшийн хүүхдүүд,
▷ өнчин,
▷ хөгжлийн бэрхиээлтэй гээд,
тэгээд
▷ гадаад, дотоодын 3 төрлийн
зээл”, тэгээд

▷ буцалтгүй тусламж,
▷ тэтгэлэг гэсэн ийм байдалтай
явж байгаа.

Тэр нарийвчилсан мэдээллийг танд бичгээр бид хүргүүлэе. Тэр бүгд Таны хэлсэн яг секторлосон тийм байдлаар олгогддог.

Хүмүүс бол зүгээр тэр гадаад руу сурч байгаа, тэр зээл аваад явж байгаа хэсгийг нь л яриад байдаг.

Өнгөрсөн хугацаанд яах вэ зээлийн төлөлт сайжирсан.

Ноднин би санаж байхад 13 тэрбум билүү. 13 тэрбум төгрөгийн эргэн төлөлт ороод ирчихсэн байгаа юм.

Зүгээр цаашдаа бид бас энэ чөлөөлөх бодлогыг, зээлээс чөлөөлөх бодлогыг их нарийвчлах ёстой юм байна гэсэн ийм бодлого барина.

Урьд нь 15 удаа, нийт 6 сайдын тушаалаар зээлийн эргэн төлөлтийг хөнгөлсөн, чөлөөлсөн байдаг.

Тэгэхээр эдгээр асуудлыг бид бодох ёстой зүйлүүд байгаа юм. Бид яг энэ журам, дүрмийнхээ дагуу л энэ хөнгөлөлт чөлөөлөлтийн олгох ёстой гэсэн бодлого барьж байгаа.

Энэ журмаа бид шинэчлэх ажлыг харин Улсын Их Хуралтайгаа нийлээд хамтдаа хиймээр байгаа юм.

Тэгээд тэр 29 төрлийн үйлчилгээндээ зориулсан дэд журам гэдэг юм уу, том малгай журмынхаа доор бас ингэж нарийвчилсан уян хатан заалтуудтай юм оруулж ирэхгүй бол бас амьдрал дээр хэцүү. Ийм хүний эрх хөндөгдчихсэн юмнууд байгаа юм.

Тийм учраас Хүний эрхийн комисст ч хүртэл бид бичиг явуулчихаад байна. Тэгээд хамтарсан байдлаар Улсын Их Хурлынхаа энэ ажлын хэсэгтэй хамтраад “Боловсролын зээлийн сан”-гийнхаа журмыг тодорхой болгох шаардлага байгаа юм.

Нарийвчилсан тоо баримтуудыг манай О.Сийлэгмаа хэлнэ. Баярлалаа.

Г.Дамдинням: Тэр асуусан тоонуудтай нь холбоотой ажлын хэсгийн 7. Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Одоогийн байдлаар төлөгдөөгүй байгаа нийт зээл, хөнгөлөлттэй зээл буюу 1993 оноос 2016 он хүртэлх хугацаанд олгогдсон зээлийн 13 мянган иргэний 14.1 тэрбум төгрөгийн зээл яг өнөөдрийн байдлаар төлөгдөөгүй байна.

Өнгөрсөн хугацаанд Үндэсний аудитын актад дурдагдсан зээлүүдээс 2024 оны байдлаар нийтдээ 2 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна.

Гадаадад суралцагчдын зээл нийтдээ зээлийн яг одоо өрийн

үлдэгдэлтэй байгаа 1427 суралцагчийн 220 тэрбум төгрөгийн зээл байна.

Энэ зээлийн өрийг барагдуулах асуудлаар бид улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтарч мэдээлэл солилцоод, санал зөвлөлдөөд явж байна. Монголбанк, Улсын прокурорын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудит энэ 4 байгууллагатай хамтраад санал солилцоод ажиллаж байна. Одоогийн байдлаар. Боллоо.

Г.Дамдинням: Б.Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Хоёр асуулт байна.

Нэгдүгээрт, ажлын хэсгийг ахлах гэж байгаа О.Батнайрамдал гишүүнээс.

Энэ ажлын хэсэг маань би орчихсон байна. Дотор нь. Яг юу хийгээд, одоо ахлах гэж байгаа хүний хувьд нөгөө төсөөлөл нь, үр дүн нь яг юу юм.

Хоёрдугаарт, Боловсролын зээлийн сантай холбоотой яамнаас яг ямар дэмжлэг хэрэгтэй байгаа юм. Юу нь болохгүй байгаа юм. Яг яалгах гээд байгаа юм. Гишүүдээр. Яг яалгах гээд байгаа юм. Юун дээр саад болчихоод байгаа юм. Тэрийгээ тодорхой хэлж өгөөч ээ гэж асуулт байна.

Гуравдугаарт, түрүүн Г.Дамдинням гишүүнтэй холбоотой.

Та Байнгын хорооны хурлыг даргалж байгаа гишүүн. Би танаас асуулт асуугаагүй. Гишүүдийн хэлсэн үгэн дээр коммент хэлээд, өөрөөр тайлбарлаад, буруу ойлголт өгөхийг би зөвшөөрөхгүй байна.

Та энэ дээр бас жоохон хариуцлагатай хандана уу.

Нүхэн жорлонг ярих нь шившиг биш байхгүй юу. Ярих ёстой, шийдэх ёстой. Аль хэдийн.../минут дуусав/

Г.Дамдинням: Дэгийн тухай хуулиа уншсан нь дээр байх. Б.Найдалаа гишүүн ээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хэдүүлээ ярья.

Гишүүний асуултад хариулья. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээрээ Боловсролын зээлийн сангийн асуудлыг бас нийгэмд талцуулах, хуваах их айхтар улс төржилт ч явчихсан тал байгаа.

Тэгэхээр бид Улсын Их Хурал дээрээ сайн ярилцаад энэ зээлийн сан чинь өөрөө хэрэгтэй. Монгол Улсын ирээдүйг авч явах ийм боловсон хүчнийг бэлдэж байгаа сан.

Тэгээд энэ чинь дотроо бас гадаад, дотоод хоёр үйлчилгээтэй.

Ингээд энэ чинь өөрийнхөө үүргийг гүйцэтгээд яваад байгаа ийм “Боловсролын зээлийн сан” гэж бид ойлгодог.

Ийм учраас энэ дээр түрүүн би хэлсэнчлэн энэ журмыг нь сайн батлаад, эргэн төлөлтийн бодлогыг нь аягүй нарийн гаргаж ирмээр байгаа юм.

Тэгэхгүй бол жишээлбэл эргэн төлөлтийг нь их сайн. Заримыг нь бэлнээр нь авна, заримыг нь Монгол Улсдаа хэдэн жил ажилласан юм, яасан гэдгээр нь нарийн бодож ингэж яахгүй бол гадагшаагаа хүн гараад өндөр өртөгтэй, өндөр цалинтай ажил хийгээд,

тэгсэн хүн л эргүүлж мөнгөөр нь төлж чадна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр эргэн төлөлтийг нь бас нэгдүгээрт сайн хиймээр байгаа юм.

Хоёрт, зөвхөн гадаадад нэртэй 50 сургуульд орж байгаа хүн гэхээсээ илүүтэй “2 дээр нэмэх нь 2” хөтөлбөр ч гэдэг юм уу, Монголдоо илүү бэлдээд цаашаагаа яваад сурах боломжтой гэж энэ үйлчилгээг нэлээн олон талтай болгомоор санагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ болгон дээр бас хамтран ажиллах хэрэгтэй.

Гуравдугаарт нь, бид хүнээс үл хамаарсан байдалтайгаар энэ журмаа хүнээ сонгохдоо ингэж оруулахгүй бол өнөөдөр жишээлбэл 50 их дээд сургууль тэнцчихсэн хүнээс ахиад TOEFL-ийн /Test of English as a Foreign Language/ шалгалт шаардаж байна.

Тэгээд янз бүрийн шалгалтыг нэмж өөрсдөө авч байна. Ингэснээрээ их л хэл амтай байж байдаг ийм л юм.

Тэгэхээр малгай журмаа хамтдаа хийчихье ээ л гэж байгаа юм. Үүнээс үүдээд тэр жижиг дүрмүүдыг хамтдаа бид бас яг энэ боловсролынхоо салбарт хийгээд явж болно.

Ялангуяа Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдаж байгаа энэ процессыг нэлээн уян хатан зохицуулахгүй бол бас болохгүй.

Тэгэхээр энэ малгай журмаа хамтдаа хийгээд, ингээд энэ ажлын хэсгийн гол үр дүн нь бол энэ гарч ирнэ ээ л гэж харж байгаа юм. Ийм юутай байгаа шүү. Баярлалаа.

Г.Дамдинням: О.Батнайрамдал гишүүнээс асуулт асуусан. О.Батнайрамдал гишүүн хариулах уу.

О.Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

“Боловсролын зээлийн сан”-гийн асуудал ер нь зөвхөн аудитын дүгнэлтээс аваад үзсэн ч гэсэн сүүлийн 10 жилийн аудитын дүгнэлт дээр дандаа асуудалтай гарч ирсэн боловч хамгийн гол нь шийдэгдээгүй одоог хүрчихсэн юм.

Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал дээр ч гэсэн Байнгын хороон дээрээ тэгвэл ажлын хэсэг гаргаад, тэгээд сайд бас хамтарч ажиллая гэж байна. Боловсролын зээлийн сангийн дарга нь бас ирчихсэн байна.

Тэгэхээр бүгдээрээ энэ дээрээ олон жил энэ бугширч явсан асуудлыг цэг тавья гэж байгаа юм.

Эндээс болоод явж явж хэн хохирч байгаа вэ гэхээрээ Боловсролын зээлийн сангаар сурчихсан, тэгээд журам нь, одоо жишээлбэл дүрэм нь ч юм уу. Тийм ээ. Хууль бус, эсвэл ойлгомжгүй байснаас болоод олон хохирогчид бас давхар яваад байгаа юм.

Тэгэхээр үүнийг нэг цэг тавьж эцэслэх ёстой. Тэгээд цаашдаа ч гэсэн дараа дараагийн Боловсролын зээлийн сангаас зээл авах хүүхдүүд. Яг үнэнийг хэлэхэд энэ бас улс төржөөд, Боловсролын зээлийн сан аягүй муу нэр хүндтэй л болчихсон байна л даа. Үүнийг бас засах хэрэгтэй гэж бодож байгаа.

Боловсролын зээлийн санг буцаад Монгол Улсын хөгжилд үнэхээр хамгийн ач холбогдолтой татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг сангуудын нэг мөн шүү дээ.

Тэгэхээр үүнийг бас зөв голдирол руу нь оруулах ёстой. Маш олон хүүхдүүд мэддэг болчихсон. Одоо үүнийг ер нь 10 жил, их сургуулийн хүүхдүүд Боловсролын зээлийн санг бүгдээрээ мэддэг болчихсон. Гэхдээ ихэнх нь сөргөөр мэдэж байгаа.

Тэгэхээр үүнийг бүгдийг нь цэгцлэх цаг нь болсон. Үе үе хууль бус сайд нарын тушаал ч гарсан. Тэрийг ч гэсэн бас цэгцлэх ёстой.

Энэ чинь одоо 220 тэрбум төгрөг. Татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Бас төлөгдөөгүй л байна. Үүнийг цаашаагаа яах юм. Яг энэ үл ойлголцсон юмнуудаас болоод дараа дараагийн орох хүүхдүүд нь хүртэл асуудалтай хэвээрээ байгаа юм.

Тэгээд энэ асуудал одоог хүртэл шийдэгдээгүй. Тэгээд журмаараа ч орж байгаа хүүхдүүд дундаас гомдолтой хүүхдүүд зөндөө гарч ирээд байгаа юм.

Тэгэхээр үүнийг хамтарсан ажлын хэсэг гаргаад эцэслэе гэж байгаа юм.

Хажуугаар нь Авлигатай тэмцэх газар, Прокурорын ерөнхий газар дээр бас ажлын хэсэг гараад энэ чинь бараг 1500 хүнээс.../минут дуусав/

Г.Дамдинням: Б.Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Миний асуугаад байгаа нь О.Батнайрамдал гишүүн ээ,

Өнгөрсөн явдлыг гэж дүгнэж хааж, тэрийг шийдэхэд дэмжих гээд байна уу? Эсвэл цаашдаа Боловсролын зээлийн сан ч юм уу, зээлийн сангүйгээр боловсролыг гадаадад монгол залуучуудыг сургах талын бодлого дээр нь илүү анхаарч шийдэл дээр нь ажиллах гээд байна уу?

Өнгөрсөн юм руу хандах гэж байна уу, ирээдүй рүү яах гээд байна уу? Аль нь илүү юу юм бэ?

Би ажлын хэсэг гишүүн болчихсон болохоор сонин байгаад байгаа. Тэгвэл таны хариулсан сая өнгөрсөн нь байгаад байна шүү дээ. Тийм ээ.

Г.Дамдинням: Ажлын хэсэг байгуулагдвал ажлын хэсэг дээрээ ярьчихвал яасан юм бэ дээ.

О.Батнайрамдал гишүүн нэмж хариулах юм уу? О.Батнайрамдал гишүүн хариулъя.

О.Батнайрамдал: Тэгэхээр таны хэлж байгаа тэр хоёулаа ороод байна л даа.

Одоо жишээлбэл, цаашдаа өнгөрсөн асуудал шийдэгдэхгүй болохоор ирээдүйд хэчнээн бид журам батлаад тэр чинь бас асуудал дагуулсан хэвээрээ байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ингээд л дахиад л хаяад л, асуудлаа мухарлахгүй яваад байх юм уу, эсвэл үүнийгээ бүгдээрээ хамтарч байгаад шийдэх юм уу л гээд байгаа юм.

Тэгэхээр Б.Найдалаа гишүүн ээ, танаас би асуусан. Ажлын хэсэгт орооч ээ гээд.

Тэгээд ажлын хэсэгт эндээс нэг их нам, элдэв янзын юм хамаарахгүйгээр бүгдээрээ ороод энэ асуудлыг эцэслэмээр байна.

Яг үнэнийг хэлэхэд бид үүнийг эцэслэх нь арагшаа харж улс төрөө яах гээд байгаа биш, хамгийн гол нь ирээдүйд явах тэр хүүхдүүдийн замыг л шулуун болгож өгөх ёстой.

Тийм учраас энэ заавал хамтдаа энэ ажлын хэсэг гаргаж эцэслэе л гэж байгаа юм. Тэгээд та бас хамтдаа орж ажиллаарай гэж урьж байгаа юм.

Г.Дамдинням: О.Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Надад хоёр асуулт байна.

Боловсролын зээлийн сангаар гадагшаа яваад сураад буцаж яг хэдэн хувь нь яг эх орондоо ирж ажиллаж байгаа юм бэ гэдэг яг тоо байна уу?

Хоёр дахь асуулт нь, хөгжлийн бэрхшээлтэй олон нийт буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхтэй оюутнуудаас суралцдаг гэж байгаа.

Энэ дээр яг нарийвчилсан тоо мэдээллүүд байвал хэлж өгч болох уу гэсэн асуулт байна.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн 7. Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт нь, өнгөрсөн хугацаанд зээлдсэн гадаадад суралцсан

2347 зээлдэгчийн 230 суралцагчаас бусад нь дотооддоо ирж ажилласан, ажиллаж байгаа. Зарим нь гэрээний үүрэг биелж байгаа буюу мэдээлэл ирүүлээд явж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд 2024 оны 3 сарын 06-ны 102 дугаар тогтоолоос өмнө “зорилтот бүлэг” гэдэг хэсгээр зохицуулагдаж санхүүжилт явж байсан. Буцалтгүй тусламжаар.

2024 оны 102 дугаар тогтоолоор “зорилтот бүлэг” дотор “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гээд тусдаа сектороор ороод ирчихсэн байгаа.

Яг одоогийн байдлаар 2024 оны төсөв дээр тусгайлан яг хөгжлийн бэрхшээлт иргэдийн санхүүжилтийн төсөв батлагдаагүй.

Бид бусад ангиллын төсвөөс зарцуулаад явж байгаа.

2024 оны эхний 6 сарын байдлаар 886 сая төгрөг зарцуулчихсан. Яг одоогийн байдлаар 2024 онд шинээр гадаадад суралцагчийн 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн дээр тушаал гаргаад, гэрээ хийгдээд, санхүүжилт нь олгогдоод явж байгаа.

Г.Дамдинням: О.Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Би яг сайн ойлгосонгүй. Сүүлчийнх нь.

Тэгэхээр 2024 оны байдлаар, одоо л энэ шинэ 102 гэдэг тогтоол гараад тэгээд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олгохоор болсон юм байна гэж би ойлголоо.

Энэ хүрээнд 2 хүн байгаа юм байна гэж ойлголоо. Зөв үү? Тийм ээ. Энэ хоёр хүн нь гадаад юм уу, эсвэл дотоодынх юм болов уу?

Г.Дамдинням: О.Сийлэгмаа хариулъя. 7. Хүлээж бай. Өөрөө асна.

О.Сийлэгмаа: Сая 2024 оноос тусдаа “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж сектороор журам дээрээ тусаж өгсөн юм.

Өмнө нь “зорилтот бүлэг” буюу “буцалтгүй тусламж”-ийн хэсэгт зохицуулагдаж явсан.

Саяын 2 суралцагч бол зөвхөн 2024 оны тушаалын гадаадад суралцаж тусад нь бие даасан тушаалаар гарч ирсэн суралцагчдын тоо.

Дотоодод нийтдээ 886 сая төгрөгийн санхүүжилттэй суралцагчид байгаа.

Г.Дамдинням: Дээд боловсролын газрын дарга. Чи чинь хуучин Зээлийн сан дээр байсан биз дээ. Тийм ээ. Тэр нөхөр. Хэн билээ? Ж.Ариунболд хариулъя. Ажлын хэсгийн 9.

Ж.Ариунболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Боловсролын зээлийн сангаас 1993 оноос оюутны хөгжлийн зээл болон бусад зээл, санхүүжилтийг төрөөс олгож эхэлсэн.

Яг буцалтгүй тусламж буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 1997 оноос санхүүжилтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож эхэлсэн юм.

Тэгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгохдоо тодорхой хувиар хөгжлийн бэрхшээлийн 70 хувиас дээш, 61 хувиас дээш гэсэн үзүүлэлтээр тодорхой хувьтай нь дүйцүүлээд тодорхой санхүүжилтийг 1997 оноос хойш олгосон байгаа. Тийм.

Г.Дамдинням: Тоо асуугаад байна шүү дээ. Хэдэн хүнд өгсөн юм, яасан юм.

Яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье. Б.Батцэцэг дарга хариулчих. Бас нэг дарга нь байсан байх аа.

Б.Батцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Боловсролын зээлийн сангийн хүрээнд нийтдээ

→ **2024 онд** “зорилтот бүлгийн суралцагч”-дад “буцалтгүй тусламж” хэлбэрээр 12.8 тэрбум төгрөгийг, нийт 4218 хүүхдэд,

→ **2025 оны Улсын Их Хуралд өргөн барьсан төсвийн хүрээнд 17.5 тэрбум төгрөгийг, нийтдээ 3667 хүүхдэд санхүүжүүлэхээр төсөвт тусгагдсан.**

Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бас энд ороод явж байгаа.

Мөн өрхийн амьжиргааны доод түвшнээс суралцдаг хүүхдүүдийн тоо нийтдээ хамрагдаад явдаг.

Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энэ жил журамдаа тусгайлан өмнө нь “зорилтот бүлгийн суралцагч”

гэдэг дотор нь нийлээд, одоо жишээлбэл 4218 дотроо багтаад явдаг гэсэн үг.

Тэгэхээр одоо тусгайлан тусад нь тайлан гаргаад явах боломжийг Боловсролын зээлийн сангийн шинэ журмаар хэрэгжүүлээд явж байгаа.

Г.Дамдинням: О.Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Уучлаарай. “Зорилтот бүлэг” гэдэг 4218 хүн байгаагийн дотор “хөгжлийн бэрхшээлтэй нь” хэдэн хувь бэ?

“Зорилтот бүлэг” гэдэгт нь яг ямар ямар хүмүүс орж байгаа юм бэ?

Тэгвэл тэрийг нь тодруулчихъя. Тэгэх үү?

Г.Дамдинням: Хэн хариулах юм?

О.Саранчулуун: Яг одоо хэн хэн байх юм, яг хэн. Одоо жишээлбэл “бүтэн өнчин” гэх юм уу, яг тодорхой хэлж өгөөч.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс яг хэдэн хувь байгаа вэ? Энэ 4 мянга дотор нь. Пропорц байгаа юу? Ядаж пропорц ч юм уу. Тийм ээ.

Г.Дамдинням: Гишүүн түрүүнээс хойш хоёр, гурван удаа л асуугаад байна л даа. Яамныхан та нар ингээд нэг ийм тоогүй л багц л юм хэлээд яваад байх юм. П.Наранбаяр сайд аа.

О.Сийлэгмаа дарга хариулъя. Ажлын хэсгийн 7.

О.Сийлэгмаа: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Саяын Б.Батцэцэг даргын хариулсан “зорилтот бүлэг” гэдэг дотор

- ▶ бүтэн өнчин,
- ▶ “цаатан өрх”,
- ▶ хагас өнчин”,
- ▶ “эцэг, эх нь хөдөлмөрийн чадвараа алдсан”,
- ▶ “нэг гэр бүлийн 3-аас дээш гишүүн”,
- ▶ “хөгжлийн бэрхшээлтэй иргэн”,
- ▶ “хөдөлмөрийн чадвараа алдсан”

гээд 7 төрлийн санхүүгийн дэмжлэг суралцагчдад олгодог.

Энэ дотор “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” 2024 оноос өмнө явсан. Энэ жилдээ яг тусад нь санхүүжилт олгож эхэлж байгаа учраас яг нарийвчлан “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” хэд вэ гэдэг асуудлаар нь нийт санхүүжилтийнхээ 10 орчим хувьд санг “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд” олгогддог юм.

Г.Дамдинням: Яамныхан та нар ингээд, одоо танай яамны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандаж байгаа, ард иргэддээ хандаж байгаа хандлага л харагдаад байна даа. Ард түмэн харж байгаа шүү дээ.

Наадхаа тоотой болго. За юу. Тоотой болго, тодорхой болго.

Тэгээд энэ “зорилтот бүлэг” гэдэг чинь хуулиараа саяын хэлж байгаа категориуд бүгдээрээ л орж байгаа шүү дээ. Түүн дээр бүгдээрээ тоо байгаа шүү дээ. Тэрийг нь гаргаад өгчих л дөө. Та нар.

Д.Бум-Очир гишүүн асууя. Д.Бум-Очир гишүүний микрофоныг өгье.

Д.Бум-Очир: Нэг зүйл тодруулах гэсэн юм.

Кембридж, Оксфордод миний мэдэхээр систем нь бусад орныхоос өөр.

“Коллежийн төлбөр” гэж байдаг. “University fee”, “College fee” гээд хоёр “fee” байдаг.

Тэгээд “college fee” нь бол нэлээн бага.

Тэгээд “Боловсролын зээлийн сан”-гийн дүрмээр сургалтын төлбөрийг нь олгоно гэж байгаа.

Тэгээд яах вэ, би бас тэнд сураад төгссөн учраас тэнд сурч байгаа, Боловсролын зээлийн сангаас тэтгэлэг авсан оюутнууд надад зарим нь санал хүсэлт ирүүлээд байсан тал байгаа.

“College fee”-г нь төлж өгөх боломжтой юм уу, үгүй юм уу?

“College fee” гэдгийг яг сургалтын төлбөр гэж ойлгох юм уу, үгүй юу?

Тэгээд яг тайлбар дээрээ тэр чинь их зовлонтой. Би их олон юм ярих болчихоод.

Кембридж, Оксфорд бол хуучиндаа коллежийн системтэй байгаад, коллеж дээрээ хичээл үздэг байсан. Хуучин тэр нь “сургалтын төлбөрт тооцогдож байсан”. Түүхэндээ.

Гэтэл одоо сүүлийн үед тэнхимүүд, факультетууд нь гараад, тэндээ илүү их сургалтын төлбөрөө

төлдөг болчихсон. Нэг ийм сонин эрлийз уламжлал, тогтолцоотой сургууль байгаа.

Тэгэхээр Оксфорд, Кембриджид орж байгаа хүүхдүүдийн “college fee”-г цаашдаа юу гэж тооцох юм бэ?

Тэрийг нь заавал төлөх хэрэгтэй болдог. Яг одоо Та бүхэн. Би яасан л даа. “College fee” гэж юу юм. Үүнийгээ тайлбар авчир гээд.

Тэгээд Кембриджээс тайлбар өгсөн байна лээ. Тэгээд би тэрийг нь мэдэж байна л даа.

Тэр коллежийн гишүүн болдог. Тэнд байр, хоол, элдэв юмаар хангадаг. Зарим нэг хичээлд тэнд суудаг.

Ингээд тэр коллежид тодорхой хэмжээгээр одоо юу гэдэг юм, мөнгөн төлбөр төлөх болдог. Маш олон үйлчилгээг тэндээс хямдаар авдаг учраас.

Ингээд коллежийн төлбөр төлөөгүй бол үндсэндээ сургалтын төлбөр бараг төлөөгүйгээс ялгаагүй ийм нөхцөл байдал үүсээд аль нэг коллежийн гишүүн болж орж чаддаггүй ийм зүйл байдаг.

Тэгэхээр Та бүхэн маань энэ коллежийн төлбөрийг цаашдаа яах юм бэ? Энэ дээр. Миний мэдэхээр хоёр, гуравхан сургууль байгаа. Английн.

Тэгэхээр энэ хүүхдүүддээ бас нэг ойлголт өгөх юм уу. Нөгөөдүүл маань бид ингээд сургалтын зээлийн сангаас, боловсролын зээлийн сангаас юу авсан. Тэгсэн чинь “college fee”-г нь төлж чадахгүй байна гээд санал хүсэлтүүд яваад байдаг.

Та бүхэн үүнийгээ нэг талд нь гаргаж тайлбар өгөх үү? Шийдэж байна уу?

Г.Дамдинням: Нөгөө “tuition fee”^[сургалтын төлбөр]-ийн тухай л яриад байна шүү дээ. Тийм ээ?

Хоёр тусдаа төлбөрийн тухай. Тийм ээ? Нөгөө “college fee”. Тийм тийм.

Хэн хариулах вэ? Ажлын хэсэг. 7 дугаар микрофон. Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя.

Английн 3 сургууль дээр 17 коллежийн хамтарсан хөтөлбөрүүд байдаг.

Түүн дээр яг сая гишүүний асуусан “кэйс” үүсэж байсан. Манай журам дээр “бакалаврын үндсэн ангийн сургалтын төлбөрийг олгоно” гэгчихсэн.

Гэтэл коллежийн төлбөр “university fee”-сээ тусад нь дахиад хоёр хавсралтаар ороод ирдэг.

Тэгээд бид дунджаар 11-ээс 13 мянган долларын санхүүжилтийг нь хаах буюу коллежийн төлбөрийг нь хасах ийм шийдэлд хүрч байсан.

Тэгээд тухайн сургуулиас нь тайлбар авахаар яг сая гишүүний хэлсэнчлэн “коллежийн төлбөр юунд зарцуулагддаг юм бэ” гэхээр тухайн коллежийн гишүүн болсноор “сэтгэл зүйн болон бусад үйлчилгээ авах, сургалт, дадлага хийх бааз дээр очиж ажилладаг” гээд ийм мэдээлэл ирээд тухайн суралцагчийн санхүүжилтийн асуудлыг нэг улирал зогсоож байсан.

Одоогоор ч гэсэн манай журам дээр зөвхөн “бакалаврын үндсэн ангийн төлбөрийг олгоно” гээд санхүүжилт заасан учраас коллежийн төлбөрийг тайлбар авч байгаад суутгаж олгогдож байгаа.

Одоогоор олгохгүй байгаа. “Бакалаврын үндсэн анги” гээд журамлачихсан учраас.

Г.Дамдинням: Ер нь тэгээд яах вэ, дэлхийг өөрсдөдөө тааруулах гээд байх ч одоо хаашаа ч юм. Тийм ээ. Хэдүүлээ ярьж байгаад шийдмээр юм байна даа.

Тэгээд манай О.Батнайрамдал гишүүн ажлын хэсэг байгуулаад явахаараа Д.Бум-Очир гишүүний яриад байгаа юмыг энэ яамныхантайгаа ярьж байгаад хийчихнэ биз дээ, бодвол. Тийм ээ.

Ж.Галбадрах гишүүн асууя.

Ж.Галбадрах: Би хэд хэдэн асуулт асууя.

Нийт зээлийн сангийн санхүүжилт хэд юм бэ? Ер нь Тийм ээ.

Өнгөрсөн жилээс нэмэгдсэн үү, хасагдсан уу? Үүнийг нэг хэлээд өгөөч.

Тэгээд дотор нь түрүүн П.Наранбаяр сайд хэлж байна лээ.

29 төрөл бүр их байгаа гэж байна. Ер нь гишүүд ч гэсэн бас хэлээд байна. Энэ зээлийн санг бид дотоод руугаа чиглүүлье.

Бид чинь 14 мега төсөл хийх гэж байна. Энд эрэлттэй мэргэжил гэх юм бол

инженерүүдийн мэргэжил маш чухал байгаа.

Тэгээд инженерүүд ШУТИС-иас эхлээд энэ инженерүүд бэлдэж байгаа сургуулиудаа харахаар үнэхээр л оюутнууд нь тэр төлбөр дээрээсээ бас орж ирж асуудал зөндөө байдаг юм билээ.

Тэгэхээр энэ дээр тэр мэргэжлүүдийг хэр тусгаж байгаа вэ?

Нөгөө талаас багш, эмч гээд бас ярьж байна. Би боловсролын салбар учраас багш нарыг сургах тал дээр яг энэ дээр нарийвчлаад ямар мэргэжил дээр нь ямар юм тавьж байна, ямар босго оноо тавиад төлбөрийн хэдэн хувийн хөнгөлөлтөөр явдаг юм. Тэр журам нь гарсан уу?

Боловсролын ерөнхий хууль гарсан шүү дээ. “Бид багш нарыг төлбөрийн хөнгөлөлттэйгөөр сургана” гээд заачихсан байж байгаа.

Энэ талын тодорхой журам юм уу, энэ нь хэр туссан байдаг юм.

Тэгээд боловсролын сангийн нийт санхүүжилт. Энэ орлого зөвхөн улсын төсвөөс бүрдээд байна уу, эсвэл өөр эх үүсвэр байгаа юу? Хандив гэсэн юмнууд байна уу? Үүнийг бас нэг асуучихъя.

Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийнхний тэтгэлгийн санг та нар хамтарч ажилладаг уу? Үүнийг оруулж ирээд үүнийг дэмжих тал дээр нь. Бид чинь нэг хувийн татвараас чөлөөлөх энэ тэр гээд зүйлүүд ороод ирчихсэн. Энэ үед их сайн хамтармаар байна.

Түүнээс гадна гадаадын тэтгэлгийн сангууд бас байдаг. Жишээ

нь, Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр маш олон хүүхдүүд яваад байдаг.

Тэгээд энэ хүүхдүүдийг буцааж ирүүлж энд нь ажиллах гэдэг чинь бас л.

Японы Засгийн газар бол буцаж ирээд Монголдоо өөрийнхөө сурсан мэдсэнийг зориулах гэдэг утгаар нь л тэтгэлэг өгч байгаа.

Тэгээд тэр оюутнууд тэгээд тэр чигээрээ ингээд яваад байх уу? Үүнийг манай зээлийн сан дээр буцаж ирэх тал дээр нь яагаач гэдэг. Өөрөөр хэлбэл зээлийн сангаар явсан бол буцаж ирж Монголынхоо нийгэмд энэ бүтээн байгуулалтад оролцох энэ талыг их сайн барих хэрэгтэй байна.

Тэгээд түрүүн сайд бас хэлж байна лээ. Энэ дээр хөнгөлөлтүүд гэдэг юмыг. Тийм ээ. Зайлшгүй гадаадад л өндөр цалинтай ажиллавал төлөөд байдаг. Гэтэл энэ авсан зээлээ буцааж төлж чадахгүй нөхцөлд хэдэн жил ажиллах юм, яах юм гээд.

Жишээлбэл, багш дээр яг МУБИС төгсөөд эх орондоо, ялангуяа орон нутагт ажилласан хүмүүсийг 5 жилийн дараагаас юм уу тогтвортой ажиллавал энэ өндөр оноотой хүүхдийг гадаадад сургая гэдэг ч юм уу.

Одоогийн энэ хүүхдүүд чинь нэг л дутуугийн комплекстой яваад байна шүү дээ. Гадаадад явж сурах ёстой. Өндөр оноотой төгссөн бол багш болохгүй байгаа гэнэ. Тэгвэл багш болоод 5 жил ажиллавал чи явна гэдэг ийм тэтгэлгийн.../минут дуусав/

Г.Дамдинням: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 7. Боловсролын зээлийн сангийн дарга.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулья.

Нийт өнгөрсөн 30 жилийн хугацаанд Боловсролын зээлийн сангаас 1.4 сая иргэнд 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт олгогдсон байгаа.

Эдгээр санхүүжилтийн сүүлийн 10 жилд буюу 2010 оноос хойш гадаад чиглэсэн санхүүжилтийн дүн 55-аас 58 хувь болж өссөн байгаа. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуултад. Нийт суралцагчдын 2023-2024 оны төсвийн гүйцэтгэл, 2023 онд 91 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан бол 2024 онд 124.0 тэрбум төгрөгийн төсөвтэй байгаа.

Энэ төсвийн 97 хувь нь суралцагчдад чиглэсэн санхүүгийн дэмжлэг олгогдож байгаа.

Гуравдугаарт нь, багшид чиглэсэн хөтөлбөр дээр 2024 оны 103, 2024 оны 102 дугаар тогтоолоор нийтдээ 6 төрлийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор зохицуулсан байгаа.

Ямар ямар төрлөөр байна вэ гэхээр 103 дугаар тогтоолоор тодорхойлогдсон “багш, ажилтны нэг хүүхэд буюу 15 жил тасралтгүй ажилласан” тохиолдол гэж байгаа.

Мөн “Багш” хөтөлбөрөөр суралцагчийн санхүүгийн дэмжлэг байгаа. Энэ хоёр дэмжлэг аль аль нь эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр, магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж байгаа тохиолдолд 100 хувь

зээлийн сангийн санхүүгийн дэмжлэг олгогдож байгаа.

Мөн үүнээс гадна 102 дугаар тогтоол дээр 6 төрлийн бас багшид чиглэсэн санхүүгийн дэмжлэг байгаа.

Сонгон бүлгээ төгсөөд суралцагч, багшийн дадлага, эрэлтээ тэргүүлэх мэргэжлээр сурч байгаа багшийн нэг удаагийн тэтгэмж, тэтгэлэг, багшийн дадлагын тэтгэлэг гээд 6 төрлийн тэтгэлгийг 102 дугаар тогтоолоор олгогдоод эхэлчихсэн байгаа.

2024 оны төсөвт 6.9, 14.5 тэрбум төгрөгийн санхүүжилтүүд суусан. 2024 оны эхний гүйцэтгэлээр 6.9 тэрбум төгрөгөөс 555 сая төгрөгийн 233 багшид олгогдсон байж байгаа.

Г.Дамдинням: П.Наранбаяр сайд нэмж хариулья.

П.Наранбаяр: Ж.Галбадрах гишүүний асуултад нэмж хариулья.

Энэ чухал асуудал хөндөж байна. Яг 5 дахь жилдээ багшилж байгаа, 5-аас дээш жил багшлах багш нарыг эргэж магистрт бэлдэх, гадаад дотоодын сургуульд бэлтгэх.

Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусчихсан байгаа. 11 мянган багшийг бэлдэнэ гээд.

Үүнийг Боловсролын зээлийн сангийн шинэ журамтай нь уялдуулаад үйлчилгээгээ илүү төгөлдөржүүлэх. Сая 6 гэж ярьж байна. Энэ дотор нь оруулаад төгөлдөржүүлэх ийм шаардлага бий гэж харж байна.

Мөн гадаадын эх үүсвэр. Одоо энэ боловсролын зээл чинь цэвэр төсвөөсөө,

тэгээд дээр нь эргэн төлөлтөөсөө яваад байгаа.

Тэгэхээр энэ дээр гадаадын болоод хувийн аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангахаар бид журамдаа илүү сайн тусгаж өгвөл. Одоо нөгөө 1 хувийн татварын хөнгөлөлт рүү чинь энэ орчхож байгаа шүү дээ. Тэтгэлэг юм олговол тэр аж ахуйн нэгжид татварын 1 хувиар тооцно гээд.

Энэ юманд орсон учраас энэ их сайн санаачилга гэж харж байгаа.

Үүнийг Боловсролын зээлийн санд оруулж ирэх шаардлагатай гэж үзэж байна.

124 тэрбум байгаа. Энэ жил жилд өсөж байгаа. Цаашдаа энэ өсөлт зөвхөн төсвөөсөө биш өөрийнхөө эргэн төлөлтөөс. Түүнээс гадна бас энэ хувийн аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан санхүүгийн эх үүсвэрүүд илүү орж ирвэл илүү менежментийн хувьд ч гэсэн сайжирна гэж харж байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Болсон уу? Ж.Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Энэ дээр сая гадаадын хөрөнгө оруулагч гэдэг юм уу, хандивлагч хүмүүсээс тэтгэлэг татаж авчирч ажиллуулах.

Би өөрөө “Шинэ Монгол-Мабүчи тэтгэлэг” гэдгийг 10 жил хийгээд яваад байгаа хүн байгаа юм.

1.2 сая долларын тэтгэлэг 330-аад хүүхдэд өгчихсөн байгаа.

Энэ дотроос жишээлбэл, эргэн төлөлт нь 69.0 хувьтай явж чадаж байгаа.

Энд бид тэр эргэн төлөлт дээр нь төлбөрөө төлөх юм бол эргээд дараагийн хүмүүстээ ивээн тэтгэгч болж байгаа юм шүү гэдэг сэтгэлгээг тэр хүүхдүүдэд өгөөд, тэгээд эргэн төлөлт хийж байгаа. Тэр тэтгэлэг авсан оюутнуудтайгаа эргэж холбоотой ажиллах тал дээрээ л их анхаарвал эргэн төлөлт сайжрах ёстой гэж бодож байгаа юм.

Тэгэхээр эргэн төлөлтийн нөхцөлийг бүгдээрээ сайжруулах.

Өнгөрсөн 220 тэрбум ч гэдэг юм уу, том тоонууд байгаад байгаа. Тэгвэл одоо үүнээс хойших эргэн төлөлтийн бодлого дээр яг нарийн ярих.

Одоо жишээлбэл, багшийг би сая ярьсан. 5 жил ажиллаад магистрт явуулъя. Явуулахдаа бид бүр Америк ч юм уу, Австрали ч юм уу, том явуулах биш, энэ ойрхон Хятад, Япон, Солонгос ч юм уу арай хямд төлбөртэй газар явуулъя.

Тэгээд эргэж ирээд яаж ажиллавал тэрийг нь хөнгөлөх юм бэ гэдэг тал дээр л тэр хөнгөлөлтүүдийн журмыг сайн гаргаач.

Түрүүн асуугаад байгаа нь багшийн мэргэжлээр элсэх хүүхдүүд дээр журам гарсан уу? Элсэлтийн ерөнхий шалгалт нь ямар босго оноотойгоос хөнгөлөөд байгаа вэ гэдгийг асуух гэсэн юм.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

О.Сийлэгмаа: Гишүүний тодруулсан асуултад хариулъя.

Төрийн өмчийн их сургуулийн магадлан итгэмжлэгдсэн тэргүүлэх

эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа багшийн хөтөлбөрийн суралцагчдад санхүүгийн дэмжлэгийг олгож байгаа.

Босго оноо нь 480 онооноос дээш элссэн суралцагчдад. Нэг.

Хоёрдугаарт нь, түрүүний асуулт дээр бас нэмэлт тайлбар өгье.

Одоо одоогийн 102 дугаар тогтоолоор багш мэргэжлээр зээлийн сангийн санхүүгийн дэмжлэгээр суралцсан тохиолдолд орон нутагт 3 жил, нийслэлд 5-аас дээш жил ажилласан тохиолдолд тухайн тэтгэлгийн гэрээг биелүүлсэн гэж дүгнэх зохицуулалттай журам байгаа. Одоогоор.

Гурав дахь нь, гадаадад багшийг суралцуулах тухай асуудал дээр яг багшийг гадаадад гэж тусгайлан заагаагүй. Төрийн албан хаагчийн хүрээнд ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээрээ тодорхой хугацаанд 3-аас дээш жил, хангалттай үнэлгээтэй тохиолдолд төрийн албан хаагч гэдэг утгаараа гадагшаа сурах боломж нь 2024 оны 102 дугаар тогтоолоор бас зохицуулагдсан байгаа.

Г.Дамдинням: О.Батнайрамдал гишүүн асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа.

Түрүүн О.Сийлэгмаа дарга хэлж байх шиг байна. Одоо гадаад, ялангуяа “Боловсролын зээлийн сан” чинь дотроо гадаад, дотоод гэж ер нь хоёр үндсэн хэсэгт хуваагдаж байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр хоёулаа орж байгаа гэж ойлгож байгаа. Эргэн төлөлт, дотоодын зээл дээрээ хамаагүй илүү байдаг мөртлөө гадаад

зээл дээрээ одоо хүртэл ер нь маш муу явсаар ирсэн.

Яах вэ, сая эргэн төлөлт олон нийтийн мэдээлэл болоод тэгээд хүмүүсийн дунд яриа болоод гарах үед эргэн төлөлт жоохон явсан. Гэхдээ том дүнгээр нь аваад үзэх юм бол нийт дүнгийнхээ 10 хувьд ч хүрэхгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид цаашаагаа энэ ажлын хэсгийн хүрээнд шийдье гэж байгаа юм.

Тэгээд дээрээс нь шинэ журам боловсруулах, эсвэл журам дээрээ одоо жишээлбэл өнөөдөр бид дээр гэхэд л хоёр, гурван коментууд ирж байна шүү.

Тэгэхээр эд нарыг бүгдийг нь нэгтгээд шинэ журмаа маш ойлгомжтой болгох хэрэгтэй. Тэр хүлээлт байгаа.

Түүнээс гадна бас П.Наранбаяр сайд аа, юу шүү дээ. Одоо бас 2014 оноос эхэлсэн санагдаж байна. 2014 оноос эхлээд л баахан одоо ер нь бол хууль бус зээлийн тэглэлтүүд явсан. Тийм ээ. Олон сайд нарын тушаалууд явсан.

Тэгэхээр үүнийг хууль бус гэж мэдсээр байж бид тэгээд яах юм? Хэрэв үнэхээр хууль бус тэглэлт үнэхээр мөн бол энэ тушаалуудыг хүчингүй болгох хэрэгтэй шүү дээ.

Тэгээд цаашдаа бас энэ аудитын дүгнэлтийг бүгдээрээ авч үзэх ёстой.

Ер нь сүүлийн 10 жилийн аудитын дүгнэлт болгоныг ажлын хэсэг дээр авч үзээд дүгнэлтийн хэрэгжилт нь яг яасан юм. Буцаад тэр ер нь цаашдаа аудитын дүгнэлт ингээд л Улсын Их Хурал дээр

нэг чуулганаар орж яригдаад л хаягдаж болохгүй л дээ.

Тэгэхээр үүнийг Боловсролын зээлийн сан дээр, ялангуяа ажлын хэсэг дээр илүү анхаарч авч үзнэ гэж бодож байгаа.

Тэгээд түрүүн дурдагдах шиг боллоо. Авлигатай тэмцэх газар, Тэгээд Прокурорын ерөнхий газар маш том ажлын хэсэг гаргаад, одоо түүний үр дүн нь яасан юм бол оо? Тэрийг бүгдээрээ сонсох хэрэгтэй. Энэ нэг бас нэг мухарлах ёстой том асуудал энэ дээр байгаа.

Тэгээд асуудал ярих юм бол маш олон байна л даа.

Тэгээд Монголбанк руу дотоодын зээлийн эргэн төлөгдөөгүй мэдээлэл Монголбанк дээрх нөгөө “саарал жагсаалт” буюу “зээлийн мэдээллийн сан”-д ордог бол гадаад зээл нь одоо орж байгаа юу?

Монголбанкнаас асуухаар бид Монголбанкны үүрэг биш шүү дээ. Боловсролын яам тэр мэдээллийг өгөх үүрэгтэй. Авсныг нь Монголбанк зээлийн мэдээллийн санд оруулдаг.

Тэгэхээр уг нь орох ёстой энэ мэдээллүүдэд цаашаагаа ороод явах. Жишээлбэл, үүнийг бас ойлгомжтой болгох хэрэгтэй.

Тэгээд жил болгон явах сонгон шалгаруулалтууд байна. Ер нь хэл амгүй сонгон шалгаруулалт бараг ер нь бараг гарч байгаагүй дээ. Тийм ээ. Түрүү жил л нэг ил тод яваад бүх мэдээллийг шууд дамжуулаад явахад арай гайгүй байсан.

Гэхдээ л бас одоо энэ сонгон шалгаруулалтыг ер нь хүнээс хамаарахгүйгээр яаж явуулах ёстой юм. Тийм ээ.

Тэгээд одоо нөгөө 10 хувийн дотаци гэдэг тэр зүйлийг огт байхгүй болгох ёстой шүү дээ. Гэх мэтчилэн олон асуудлууд байгаа.

Тэгэхээр түрүүн Б.Найдалаа гишүүн ч бас асуугаад байна лээ.

Г.Дамдинням: О.Батнайрамдал гишүүн үг хэлчхэв үү? Үг хэлчихлээ.

Надад хоёр, гурван асуулт байна.

Нэгдүгээрт, гаднын тэтгэлгүүд гэхээсээ судалгааны грантууд дээр л байгаад байдаг юм даа. Тэр аргачлалыг ер нь нэвтрүүлчихвэл ер нь яадаг юм?

Энэ нөгөө “matching funds” хийдэг шүү дээ. Хувийн хэвшил гаргасан дүнгээр төр гаргадаг. Тэнцүүлээд гаргачихдаг. Хоёр талаасаа гаргадаг.

Энэ аргачлалыг Боловсролын зээлийн сангийн журамдаа оруулаад өгчихвөл болно гэж үзээд байх юм. Энэ боломжтой юу?

Яагаад гэвэл 2023 оны 7 дугаар сарын 07-нд батлагдсан Боловсролын ерөнхий хууль батлагдсантай хамт Дээд боловсролын байгууллагад суралцагчийн нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болоод, өөрөөр хэлбэл Боловсролын зээлийн сан эрх зүйн цоо шинэ орчинд шилжсэн.

Үндсэн хууль нь өөрчлөгдөнгүүт тэр дотор төр, хувь хоёр олон улсын байгууллагууд хамтарч ажиллах үүд

хаалгыг нээгээд өгчихсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр та нар үүнийг энэ журамдаа хийгээд өгчих бололцоо байна уу. Тийм ээ.

Яагаад гэвэл хувийн хэвшлийн байгууллагууд сая бас л энэ Төсвийн байнгын хороон дээр би ажлын хэсэгт нь өөрөө орж ажиллаж байгаад оруулсан. Энэ хөнгөлөлт чөлөөлөлтүүд дотор нь нөгөө татвар ногдох орлогын 1 хувьд орох өөрчлөлт дотор энэ боловсролын асуудлыг бас оруулаад тавьчихсан байгаа байхгүй юу.

Монгол Улсын Засгийн газраас зарласан нэн хэрэгцээт мэргэжлийн жагсаалтад орсон мэргэжлүүдэд энэ 1 хувийн хөнгөлөлтийг оруулна гээд тооцчихсон байгаа юм. Оруулчихсан байгаа. Татварын хуульд.

Тэгэхээр энэ чиглэлээр сурахад хүмүүс хувийн хэвшил бол өөрийнхөө хүнийг тодруулаад мэргэжилтэй боловсон хүчнээ бэлдээд буцааж авчрах магадлал нь төрөөс хамаагүй илүү байхгүй юу.

Тэгэхээр энэ боломжийг нь Та нар харж хийх боломж байгаа юу гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, би О.Батнайрамдал гишүүнтэй бас ижилхэн байр суурьтай байгаа юм.

Энэ зээлээ төлөхгүй алга болчихсон гэж яригдаад байгаа. Өөрөөр хэлбэл би О.Сийлэгмаа даргаас л асуух гээд байгаа юм.

Журам нь өөрөө ийм тодорхойгүй байсан. Би өөрөө энэ дундуур туучиж

байсан хүн. Эргэж ирээд л 5 жил ажиллаад л. Явсан сургуульдаа сур. Мөн үү. Тийм ээ. Явсан сургуульдаа сур. Тийм ээ. Энэ Д.Бум-Очир гишүүн ч байж байна энд.

Явсан сургуульдаа очиж сур. Тэр нь дэлхийн шилдэг байх ёстой. Монгол Улсад нэн хэрэгцээтэй мэргэжлээр сурах ёстой. Амжилттай төгс. Эргэж ирээд Боловсролын зээлийн санд мэдээллээ өг.

Ингээд Монгол Улсдаа ирээд 5 жил ажиллаад чи гэрээний үүргээ биелүүлсэнд тооцогдоно гэдэг гэрээ бид нартай хийж явуулаад эргээд ирэхэд нь чи өрөө төлөөч ээ гэж дайрсаар байгаад дуусаж байгаа байхгүй юу.

Бид ч яах вэ тэгээд төлчихдөг юм байж. Төлөөгүй хэсэг нь яах вэ?

Энэ дээр та нар нэг хариулт өгөөч. Гэрээ нь асар тодорхойгүй гэрээ шүү дээ. Журам нь ч асар тодорхойгүй. Үүнийг нэг тийш нь бариад. Түрүүн Боловсролын сайд хэлээд байх шиг байна. П.Наранбаяр сайд. Их улс төржсөн шүү. Үүнийг яах вэ гэдэг хоёрдугаар асуулт байна.

Гуравдугаарт, тухайн үеийн журам нь хэдийгээр тодорхой бус байсан ч гэсэн илт хууль зөрччихсөн хүмүүс байгаа шүү дээ.

Би бүр тодорхой ярья. Манай О.Батнайрамдал гишүүн байнга ярьдаг. Таны ажиллаж байгаа Засгийн газрын Тэргүүн Шадар сайдын асуудал явж байгаа шүү дээ. Тэр дотор.

Илт бүр тэнд байсан тодорхой журмыг хүртэл зөрччихсөн. Энэ хүмүүс дээр ямар хариуцлага ярих юм? Ямар ажил хийж байгаа юм? Та нар. Ийм гурван асуулт байна.

П.Наранбаяр сайд хариулъя.

Д.Наранбаяр: Би нэг, гуравдугаар асуултад хариулъя.

Түүнээсээ өмнө сая надад ирсэн мэдээг яачихъя.

О.Саранчулуун гишүүний асуугаад байсан тэр “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд” нийтдээ 2023 онд 636 хүүхэд, 2024 онд 668 хүүхдэд 1.5 тэрбум төгрөг олгосон байна шүү.

Үүнийг би танд яг энэ задаргаатай нь явуулъя. Тэгээд уучлал хүсье. Бид шууд бэлэн тоотой орж ирээгүй дээ.

Хоёрт нь, Г.Дамдинням гишүүний яриад байгаа тэр судалгааны гранд, “matching funds” маягаар 1 хувийн хөнгөлөлттэй хувийн хэвшлийг оролцуулаад явдаг. Энэ бүрэн боломжтой гэж харж байгаа. Үүнийг О.Батнайрамдал гишүүнтэй энэ ажлын хэсэг дээрээ бид нээлттэй ярилцаад оруулна.

Гуравдугаар асуултын тухайд. Илт зөрччихсөн хүмүүс бий гээд.

Надад Авлигатай тэмцэх газраас ирчихсэн бичиг байгаа юм. 9 сарын 30-нд хаяглаж ирээд надад яг орж ирсэн нь өнгөрсөн долоо хоногт л байгаа.

Энэ дээр байна аа байна. 801 хүний асуудал гараад ирсэн.

Гэхдээ бид энэ асуудлыг жишээлбэл бүгдийг нь харлуулаад дайраад байх юм алга. Яг хариуцлага хүлээх ёстой хүнээс нь л шаардаж явна. Илүү нарийвчилж харж байна.

Энэ бол зээлийн сангийн “төлбөрөөс чөлөөлсөн нь” хууль бус байх магадлалтай гэсэн **801 суралцагчийн мэдээллийг** нь бид яг ид шүүж байна. Тийм.

Тэгэхээр ирээд тухайн үеийнхээ гэрээнд хүлээсэн үүргээрээ 5 жил ажиллаад Монгол Улсынхаа хөгжилд яг ирсэн мэргэжлээрээ ажиллаад өөрийнхөө хувь нэмрийг оруулчихсан хүмүүст бид тооцоог нь дуусгах ёстой. Тэгэх ёстой.

Харин элдэв арга саам хайж өөрийгөө чөлөөлүүлсэн хүмүүстэй бид хатуухан ярина. Бичиг нь энд байж байгаа. Энэ бас нэлээн ажил болно.

Тэгэхээр манай Боловсролын зээлийн сан энэ бичиг, энэ дагуу ирсэн мэдээллийг О.Батнайрамдал ажлын хэсгийн ахлагч даргатай хуваалцаад энэ ажлыг эхлүүлнэ гэдгээ хариуцлагатайгаар хэлж байна.

Тэгээд хоёр дахь асуултад нь 7 номероос хариулчих.

Г.Дамдинням: О.Сийлэгмаа дарга.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя.

Хоёрдугаар асуулт дээр гэрээ журмын зохицуулалтын тухайд бид хэд одоогоор хийж байгаа ажил Авлигатай тэмцэх газар, сайдад болон Зээлийн санд хаяглаж ирсэн албан тоотын хүрээнд хамгийн нэгдүгээрт зээлээс тэглэгдсэн суралцагчдын гэрээ дүгнэх асуудал буюу тухайн журмын ямар заалтууд байгаа юм бэ гэдгийг нь тодорхойлж байна.

Хоёрдугаарт нь, Авлигатай тэмцэх газрын бичигт дурдсанчлан “гэрээ

дүгнээгүй байна” гэдэг асуудал байгаа учраас тухайн журмын заалтаар “Гэрээ дүгнэх ажлын хэсэг” төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байна.

Гуравдугаарт нь, хэрвээ гэрээ дүгнэх асуудлаар ажлын хэсэг ажиллаад, гэрээ дүгнэгдээд, хэрвээ үнэхээр гэрээгээ зөрччихсөн, журмаа зөрччихсөн байх юм бол зээл төлүүлэх асуудал байгаа.

Гурав дахь асуулт дээр нэмэлт тайлбар өгчихье гэж бодож байна.

Монголбанктая яаж хамтарч ажиллаж байгаа юм бэ гэж.

Монголбанктая бид журмын зохицуулалтаар 2008 оноос хойш зээлийн сангаас зээл авсан зээлдэгчдийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх зохицуулалттай юм билээ.

Тэгээд энэ хүрээнд Монголбанктая албан бичиг, мэдээлэл солилцоод хөөн хэлэлцэх хугацаатай холбогдуулаад бид мэдээллийг нийлүүлж, хүлээн авах боломжтой гэсэн хариу өнгөрсөн долоо хоногт өгсөн.

Тэгэхээр бид хэд одоогийн байдлаар зээлдэгчийнхээ яг гэрээний хэрэгжилтийг судалж ажиллаж байна. Одоогоор.

Г.Дамдинням: Ойлголоо. Ер нь одоо тэгээд л тодорхой л болгомоор байдаг юм даа.

Үг хэлэх гишүүн байна уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан. Кнопоо дараарай.

С.Эрдэнэбат гишүүний хувьд тасалъя. Ж.Галбадрах гишүүний хувьд тасалъя.

О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Яг түрүүн асууцхсан асуулттайгаа холбоотойгоор энэ хөгжлийн бэрхшээлтэй, одоо ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь нөгөө 70 хувийн өмнө, наана гээд л. Энэ ангилал маань өөрөө шинэчлэгдэж байгаа. Одоо удахгүй шинэчлэгдэнэ гээд **ICF** /International Classification of Functioning/ гээд яриад байгаа.

Тэгэхээр энэ нь эргээд хүүхдүүд, суралцагчид тэтгэлэг авахад асуудалтай холбоотой болно.

Тэгэхээр миний хувьд энэ ажлын хэсэгт оролцох саналтай байна.

Ер нь Боловсролын зээлийн сангийн энэ хөтөлбөр суралцагчийг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нь 600 гаруй гэж би сая сонслоо.

Тэгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролыг харахаар аягүй бага байдаг байхгүй юу. Суралцах боломжгүй.

- ▶ Сургууль нь хүртээмжгүй ч юм уу,
- ▶ дээд боловсролын байгууллагууд нь хүртээмжгүй,
- ▶ байшин нь хүртээмжгүй,
- ▶ багшийн зааж байгаа арга барил нь хүртээмжгүй.

Одоо жишээлбэл сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд Соёл, Урлагийн Их Сургуульд сурч байгаа хүүхэд жишээлбэл ярьж байгаа юм.

Би 4 жилийн дараа төгсөхөд дипломын ажлаа хийх гэхээр би юу ч ойлгоогүй байна гээд надад ийм

асуудлууд байна. Тэгээд би зарим хүмүүсийн амны хайрцгаар харж байгаад нэг иймэрхүү зүйл сурсан гэж байгаа.

Тэгэхээр энэ боловсролын зээлийн сангийн журам, сайжруулах э үйл ажиллагааг хийх чиглэл дотор хүртээмжийг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах боломжийг нээж өгөх хэрэгтэй байгаа. Энэ дээр бүр онцгой анхаарах хэрэгтэй.

Тэгэхгүй бол өндөр боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй хүн ч хэцүү байна. Ажилд оръё гэхээр нөгөө 144 дүгээр заалт, нөгөө 25.1 чинь ажиллахгүй байгаа шүү дээ.

Яагаад гэхээр ажлын зарынх нь дагуу очоод ажиллах хөгжлийн бэрхшээлтэй хүн байхгүй байна. Тэр боловсрол нь, мэдлэг чадвар нь, ажлын байран дээр шаардаж байгаа зүйл нь хоорондоо зөрөөд байгаа.

Тэгэхээр хүн амандаа анхаарал хандуулах зорилгоор зөвхөн сургалтын тэтгэлэг олгоод зогсохгүй хүртээмжийг нь дэмжихтэй холбоотой зүйлийг өргөвөл яадаг юм бэ. Тийм ээ.

Одоо жишээлбэл сонсголын бэрхшээлтэй хүүхэд, харааны бэрхшээлтэй оюутнууд суралцахад энэ дэмжлэг байх боломж байдаг юм уу, үгүй юү гэдгийг анхаарч үзмээр байгаа.

Хоёр дахь нь, Монгол Улсад хэрэгцээтэй байгаа мэргэжилтнүүд гэж ярьж байгаа. Тэгээд харахаар инженерийн мэргэжлүүд их байна. Яах вэ, эдийн засгийн тэр чиглэл энэ тэрээ бодохоор байдаг л байх л даа.

Жишээлбэл, хиймэл хөл хийдэг мэргэжилтэн манай улсад 2-хон байгаа

шүү дээ. Тэгээд протез хийдэг мэргэжилтэн нь байхгүй. Тэр анги нь байхгүй.

Тэгэхээр хэл засал байхгүй, ахуй засал, хөдөлгөөн засал байхгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн дутагдалтай, хоол зүйч дутагдалтай.

Тэгэхээр Монгол Улсад хэрэгцээтэй байгаа мэргэжил чинь зөвхөн эдийн засгийн хөгжлөө дагасан инженерүүдээс дутахгүйгээр тодорхой пропорц нь хүний эрхийг хангах, хүн амдаа үйлчлэх чиглэлийн мэргэжилтнүүдийг тодорхой пропорцоор оруулах хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ эрэлтийн жагсаалтыг хэзээ шинэчилдэг юм байгаа юм. Тэр дотор нь үүнийг оруулах хэрэгтэй гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр ийм шалтгааны улмаас миний хувьд энэ дээр нэлээн анхаарч ажиллах ийм хүсэлтэй байна.

Тэгээд та хэдийг энэ шинэчлэл дээрээ оруулна байх гэж найдаж байна. Ялангуяа хэрэгцээтэй байгаа мэргэжилтнүүд, тэр нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд яриад байна. Тийм ээ.

Дээрээс нь суралцаж чадахгүй байгаа хүн амдаа, хүүхдүүддээ суралцахад нь дэмждэг баймаар байна.

12 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа шүү дээ. Тэр чинь ирээдүйд оюутан болно, суралцах хэрэгтэй байна. Тийм ээ. Тархины саажилттай хүүхдүүд гоц ухаантай. Гэтэл хүртээмж нь байхгүй байна.

Тэгэхээр иймэрхүү юм руу Боловсролын зээлийн сангийнхаа зарим үйл ажиллагааг хүргэмээр байна.

Г.Дамдинням: О.Саранчулуун гишүүн чухал санал хэлж байна. Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Миний нэр ажлын хэсэг дотор байх шиг байна.

Тэгээд ажлын хэсгээс нэрээ татах хүсэлтэй байна. Тэгээд татаж байгаа шалтгаанаа бас тайлбарлая.

Нөгөө шалгагдаад байгаа 1500 гэхэв үү, яачхав. Тийм ээ. 800 билүү. Тэгээд би цагдаа дээр очиж мэдүүлэг өгсөн шүү.

2013 онд бил үү, уг нь нөгөө жил нь гүйцээд. Миний үед тухайн үед гэрээ 6 жил байсан. Тэгээд 6 жил Монголдоо тогтвор суурьшилтай ажиллаад уг нь гэрээ ёсоороо чөлөөлөгдсөн байх.

Сая сайд хэлж байна. Тэгээд чөлөөлөх юм байлгүй гэж бодож байна. Яах вэ, сайн шалгана биз. Сайн шалгана биз. Ер нь шалгах нь зүйтэй. Би ч гэсэн шалгуулах хүсэлтэй байна.

Тийм учраас ажлын хэсэг дотор ороод байж байх нь ашиг сонирхлын зөрчилтэй юм шиг харагдах байх.

Тухайн үед би оюутан байсан шүү. Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгчийн зөвлөх энэ тэр гээд янз бүрийн албан тушаал хашна гэж яаж мэдэх вэ дээ.

Хэдэн зүйлийг тодруулчихмаар. Тэгэхгүй бол буруу зөрүү мэдээлэл яваад байна. Уучлаарай. Энд бас хувийн чанартай юм ярьж байгаад.

Кембриджийн их сургуульд би 2000 онд элсэж орсон. Магистрт. Англиас тэтгэлэг авч орсон.

2001 онд магистраа төгссөн. Шаардлагатай гэж үзвэл би төгссөн дүнгээ хэлж болно. Би “онц” төгссөн.

2002 онд докторт орсон. 2004 онд доктороо төгссөн.

Ингээд докторт 4 жил сурах явцдаа 3 жилд нь Боловсролын зээлийн сангаас. Тухайн үед чинь “Төрийн сан” гэдэг байлуу даа. Тэтгэлэг авсан. Тэгээд жилд. Та бүхэн мэдэж байгаа. 16 мянган доллар төлдөг.

Тэр нь сая би түрүүний асуугаад байсанчлан манай Кембриджийн их сургуулийн гадаад оюутны тэтгэлэгт хүрдэггүй. Бүтэн тэтгэлэг нь 42 мянга орчим доллар байдаг байсан санагдаж байна.

Тийм учраас миний докторын сургалтын явцад би Боловсролын зээлийн сангаас тэтгэлэг авахаас гадна Кембриджийн их сургуулийнхаа антропологийн тэнхим болоод тэнд сурч байсан “Corpus Christi” гэж коллежийнхоо тэтгэлгийг давхар авсан.

Тэгээд би нийтдээ 3 тэтгэлэг авч сурч байсан гэдгийг би бас хэлмээр байна. Та бүхэнд мэдээлэл нь хэрэг болж магадгүй.

Түүнчлэн Боловсролын зээлийн сан 2 жил тэтгэлэг өгдөг. Хүсэлт гаргавал 3 дахь жилдээ өгдөг. Докторын зэрэг хамгаалахад 4 жил болдог.

Тэгээд би 4 дэх жилдээ Боловсролын зээлийн сангаас мөнгө аваагүй шүү. Нийт би Кембриджид

сурахад 200 гаруй мянган доллар болсон болов уу гэж би боддог юм.

Тэгэхээр тэр 16 мянган долларыг 3-аар үржүүлбэл би 230 мянган доллар төлснөөс 48 орчим мянган долларыг нь Боловсролын зээлийн сангаас төлсөн байна лээ шүү.

Тэгээд би энэ ташрамд бас Боловсролын зээлийн санд талархаж байгаагаа илэрхийлмээр байна.

Би үүний бүтээгдэхүүн шүү. Сайд түрүүн хэлж байна. Хэт харлуулаад байдаг.

Энд олон мэргэжилтэн улс орондоо юм хийж бүтээгээд байж байгаа, шинжлэх ухаанаа хөгжүүлж байгаа, улс орныхоо энэ хөгжил дэвшилд хувь нэмэр оруулж байгаа олон сайхан залуучууд мэдлэг боловсрол эзэмшээд ирсэн ийм ач буянтай ийм зээлийн сан байдаг юм шүү.

Мэдээж энэ дээр байгаа асуудлуудыг шалгуулж байцаалгаж цэвэрлэж авах нь зүйтэй.

Гэхдээ энэ зээлийн санг цаашид битгий хэт их харлуулаасай гэж хүсэж байна. Яагаад гэхээр энэ чинь Монголын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулаад ирчихсэн ийм чухал байгууллага шүү.

Зарим улсуудынхаа нэр хүнд энэ тэр юмнуудыг бас цэвэрлэж аваарай. Тэгэхгүй бол тэр олон зуун хүн дотор чинь мань мэтийн нэг ардын хүүхдүүд ороод ирчихсэн. Тэгээд түүнээсээ мөнгө авсандаа харамсах ч шиг, ичих ч шиг энэ нэг ийм эвгүй байдал, сэтгэгдэл төрөөд байх тохиолдол гараад байх юм байна шүү. Баярлалаа. Та бүхний ажилд амжилт хүсье.

Г.Дамдинням: С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Маш олон хүмүүсээс ажиллаж байгаа, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа, цаашдаа мэргэжил, мэдлэгээ дээшлүүлчихье гэсэн ажилчин анги дунд чинь олон хүн байдаг юм.

Харамсалтай нь тэр хүмүүст энэ зээл ерөөсөө олддоггүй. Яах вэ, нэг талаараа мэдээлэлгүй. Яаж хандахаа мэддэггүй. Дээрээс нь нас хүйсний асуудал гээд иймэрхүү байдалтай болчихдог асуудлууд байдаг.

Тэгэхээр бид зарим салбарт, тухайлбал би санаж байна. Одоо чухам бэлтгэгдсэн үү, үгүй юу. Замын хөдөлгөөний зохицуулагчаар замын цагдаа нар голцуу ажилладаг. Манай Монголд замын цагдаагийн нэг дарга хэлж байсан. Яг энэ чиглэлээр гадаадад сургасан хүн бараг байхгүй.

Тэгсэн мөртлөө манай замын хөдөлгөөнийг зохицуулах тэр шинжлэх ухааны үүднээс авч үзэх ийм юм хамгийн том асуудал болчихоод байдаг. Тийм үү. Гэх мэтчилэн салбарууд дээр бид төлөвлөгөө хэрэгтэй байгаа.

Аль салбартаа өгөх вэ, хэнийг бэлдэх вэ гэдэг юмаа ойрын 5 жил, 10 жилээр нь гаргаад, үүнийгээ эрт зарлаад зарим хүмүүсийг урьдаг. Сайн сайн мэргэжилдээ эзэн болчихсон тийм хүмүүсээ ажил хийж байгаа ч гэсэн дээр үед хуучин тэгдэг байлаа.

Заавал ажил хийлгэж байгаад тодорхой хугацаанд үзэж байгаад тэгээд тэндээс нь шалгаруулаад ингээд холиод явуулдаг.

Боловсрол, эрүүл мэндийн хувьд онцгой анхаарах хэрэгтэй юм билээ. Одоо өнөөдөр сумын төв дээр эмчгүй сумууд маш олон байна. Эрүүл мэндийн төвүүд эмч байхгүй.

Тэгээд нэг сургууль төгссөн дөнгөж ирж байгаа хүүхдүүд тэнд очоод юу боддог вэ гэхээр 3 жил ажиллаад, 5 жил ажиллаж байгаад тэгээд буцаад төв рүүгээ гэдэг ийм сэтгэлгээтэй байгаа.

Тийм учраас би энэ “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд, ялангуяа тэр зах хязгаар нутагт. Улаанбаатар хотод ч гэсэн захын дүүргүүд дээр болон сум, аймгууд дээр ажиллаж байгаа, хүн очихгүй байгаа газрууд дээр 5 жил ажиллачихсан багш, эмчийг чамайг гадаадад ийм чиглэлээр сургана. Эргэж ирээд чи дахиад 5-аас 10 жил ажиллана гэдэг ийм бодлого руу чиглүүлэх ийм шаардлага байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараагийн нэг асуудал нь тэтгэлгээ өөрийнхөө хүчээр олоод явж байгаа оюутнууд маш их байна. Хөөрхий. Одоо нэг үеэ бодвол, бид нарын үеийг бодвол маш их нээлттэй болчихсон байна.

Өөрөө хэлээ сураад, тэтгэлгээ олоод ингээд явж байгаа. Ядаж тийм оюутнуудад тэр замын зардал, тэр хоол унд гэдэг юм уу, илүү олон тийм хүмүүсийг бас урамшуулж дэмжих тал дээр бас нэг цонх нээж өгөх хэрэгтэй болов уу гэж би бодож байгаа.

Жилийн ганц 2 мянган доллар өгчихсөн ч гэсэн тэр хүүхдүүдэд асар их мөнгө байхгүй юу.

Ар гэрийн боломжгүй мөртлөө 90 хувийн тэтгэлэг авчихсан. Цаана нь нэг хоолныхоо мөнгийг аргалах гээд, ажил

хийх гээд гүйгээд байдаг хүүхдүүд бас байдаг.

Тэгээд ийм чиглэл рүү бас тэр өөрөө өөрөө олоод яваад байгаа хүүхдүүдийг урамшуулах, дэмжих, төлбөрийн чадамж, боломж байхгүй, өрхийнх нь орлогоос хамааруулаад энэ дээр нь анхаарах нь зүйтэй юм болов уу гэж би бодож байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлаж байгаа тэтгэлэг бас нэг талаараа их зөв бодлого болов уу гэж би харж байгаа.

Тэр хүртэж байсан хүмүүсийг тарааж байгаа. Нэг сургуулиас нэг хүүхэд гээд.

Хуучин бол яах вэ төвийн сургууль гэдэг юм уу, боломжтой, тэтгэлэгтэй, өндөр төлбөртэй, харьцангуй англи хэлний чадвартай тийм хүүхдүүдийг 1, 2, 3 гэж жагсаагаад тавьдаг байсан бол одоо бүх сургуулиудаар ингээд нэг сургуулиас нэг хүүхдийг тэтгэлэгт хамруулна гэдэг энэ бодлого илүү их олон хүнд хүртээх, хүртэж чаддаггүй байсан олон хүмүүст хүртээх гэдэг шиг яг ийм бодлогыг Боловсролын зээлийн сан маань цаашид авч хэрэгжүүлнэ л гэж бодож байна.

Тэгээд ер нь саяын ажлын хэсэг дээр би бас орё гэдэг саналыг хэлмээр байна.

Тэгэхдээ энэ дунд Д.Бум-Очир гишүүн шиг яг тэр том том сургуулиуд дээр тэнцээд, эргэж ирээд амжилттай ажиллаж байгаа энэ хүмүүсийг харж үзэх ёстой.

Яах вэ, нийтийн дунд энэ өөрөө зарим тийм хүмүүс нь муухай

харагдуулаад л ингээд явчихсан болохоос биш. Цаашдаа яг энэ топ сургуулиуд тэнцэнэ гэдэг чинь өөрөө маш том ур чадвар аягүй их шаарддаг.

Тэгэхээр ийм оюутнуудтай харин аль сургуульд хэнийг бэлдэх үү гэдэг юман дээрээ бид бодлого гаргаж зарладаг баймаар байна гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Г.Дамдинням: Ж.Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Бид одоо ингээд урагшаа хараад энэ зээлийн санг улам санхүүжилтийг нь нэмээд явах ийм чухал үе гэж бодож байна.

Тэгээд маш их чухал ажлын хэсэг байгаа учраас надад бас. Түрүүн би хэлсэн. “Шинэ Монгол Мабүчи” /Mabuchi International Scholarship Foundation/ тэтгэлгийн сан гээд бас гадаадын тэр Мабүчигийн олон улсын тэтгэлгийн сантай хамтраад 300 гаруй хүүхдэд өгсөн ийм туршлага байгаа учраас би одоо энэ ажлын хэсэгт бас нэмж оръё гэсэн энэ саналаа нэгдүгээрт хэлж байна.

Тэгээд санхүүжилтийг нэмэх тал дээр л бүгдээрээ, ялангуяа татварын 1 хувийн хөнгөлөлтийн энэ цаг үе дээр дотоодын хандив гаргаж ирээд, өөрсдөө тэтгэлгийн сан гаргаж ирж байгаа.

Тэр нь тэгээд явах тал дээр бид харин зээлийн сангийнхан маш сайн дэмжлэг үзүүлээд явах нь чухал байна. Үүнийг бас тэр журамд оруулж өгөх хэрэгтэй байх гэж бодож байна.

Тэгээд журам маш л тодорхой болгох хэрэгтэй. Журмыг л бид. Тэгээд

сая манай О.Саранчулуун гишүүн яриад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд. Энэ дээр би бүр нэмээд дахиад бага орлоготой хүүхдүүд. Энэ хүүхдүүдээс жишээлбэл энд хандъя гээд ядууралд өртчихсөн манай маш олон өрх байна шүү дээ.

Тэгээд энэ хүүхдүүдийг оруулахын тулд бид яах вэ гэвэл тэр нэг босго, тавьж байгаа шаардлагууд нь аягүй бага болох ёстой гэж бодож байна.

Жишээ нь, байрны барьцаа гээд л нэхчих юм бол энд чинь тийм өрх, гэр бүлээс хүүхэд орохгүй.

Тийм учраас тэр журам дээр үүнийг нь хөнгөлөөд. Бид түрүүний яриад байгаа тэр “Мабүчи тэтгэлгийн сан”-г бид Монголд хийхдээ ямар ч тийм барьцаа хөрөнгө, зээл шаардахгүйгээр, гагцхүү сурах гээд байгаа зүйлийг нь аягүй сайн бичүүлээд, чи тэгээд үүнийг сураад яах юм гээд. Дотоодод хэрэгжүүлээд байгаа.

Тэгээд дотоодын тэтгэлэг маань ер нь мянган доллар байхад жилдээ хүүхэд бас төлбөрөө төлөөд л сураад байдаг. Энэ боломжууд бүрдээд.

Тэгээд эргээд үүнийгээ буцаагаад дараагийн нэг хүүхдэд бид бас боломж өгөх юм гэдэг юмыг хийгээд явах энэ систем рүү. Мэдээж олон л хүүхэд гарах байх.

Тэгэхдээ үүнийг нь хариуцсан тийм ажилтан. Эргэн төлөлт дээр. Нөгөө хүүхдүүдтэй эргээд уулздаг тийм коммунити гаргаад явдаг юман дээр бас анхаараасай гэж ингэж хэлмээр байна.

Тэгээд мэдээлэл ил тод байх гэдгийг л их сайн болгомоор байна. Тэгэхгүй бол тэртээ тэргүй ажиллаж байгаад орох гэж байгаа хүмүүс, ажиллаж байгаад хамрагдахыг хүсэж байгаа зөндөө олон багш, эмч нар, түрүүн тэр замын цагдаа байна гээд ярьж байна.

Тэгээд энэ хүмүүс чинь нэгэнт нас нь өнгөрчихөөр эргээд бид нарт ийм боломж байна уу гэдгийг эргэж хардаг.

Тэгэхээр бид ажиллаад тодорхой хэмжээнд амжилт гаргаад байгаа хүмүүсээс, тогтвортой ажилласан хүмүүсээс цаашаа явуулах гэдэг л энэ зарчмыг бас нэгдүгээрт тавиад. Ялангуяа Монголынхоо нийгмийг мэдээд бакалаврын түвшингөө Монголдоо эзэмшихээд тэгээд ажиллаад явж байгаа хүмүүсийг. Гадаадад явах нь. Тийм ээ. Магистр, докторынх нь тэр сургалтууд руу нэлээн анхаарвал зөв байна.

Тэгээд С.Эрдэнэбат гишүүний тэр сая хэлсэн юмыг би бүр давгаж хэлье гэж бодож байна. 5 жил тогтвортой ажилласан багш, эмч нарт тэтгэлэг олгож сургах гэдэг.

Тэр хүмүүс мэргэжлээ дээшлүүлээд, бас гадаад ертөнцөд яваад сурчих гэсэн. Энэ бол их үр өгөөжтэй.

Тэгээд буцаад багш мэргэжлээрээ яваад ирсэн хүмүүс маань буцаад ажлынхаа байран дээр ирээд дахиад 5 жил ажиллана гэхэд энэ 10 жил ажиллахад тэр хүн насаараа яг сайн багш болоод явах нөхцөл нь бүрдэнэ.

Бид энэ рүүгээ л дотоодын боловсон хүчнээ бэлдэх тал дээр л анхааръя гэсэн. Ийм саналууд хэлье. Баярлалаа.

Г.Дамдинням: Б.Хэрлэн гишүүн. Микрофон өгөөрэй. Б.Хэрлэн гишүүнд.

Б.Хэрлэн: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр энд би хоёр асуудлыг хөндөж ярих бодолтой байна.

Нэгдүгээрт нь, одоо энэ Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, Боловсролын зээлийн сангийн журмын биелэлтэд хяналт шалгалт хийх гэсэн энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбоотой өөрийнхөө саналыг хэлье гэж бодож байна.

Тэгэхээр би өөрөө Боловсролын зээлийн сангаас бас тодорхой тэтгэлэг авч Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Подстамын их сургуульд докторын зэрэг хамгаалахдаа 3 жилийн хугацаанд энэ тэтгэлгийг авч байсан.

Тэгэхээр хэрвээ би энэ ажлын хэсэгт орох юм бол бас ашиг сонирхлын зөрчилтэй мэт харагдаж болзошгүй байгаа учраас энэ ажлын хэсгээс бас нэрээ татах бодолтой байна.

Хоёрдугаарт нь, энэ ажлын хэсэг маань өөрөө Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, тэгээд хоёрдугаарт нь Боловсролын зээлийн сангийн журмын биелэлтэд шалгалт хийх гэсэн ийм хоёр ажлыг хооронд нь нийлүүлээд тавьчихсан байгаад байдаг.

Уг нь би Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилт дээр ажиллая гэж бодсон. Гэвч хоёр дахь үндсэн ажлынх нь үүрэг даалгавар нь Боловсролын зээлийн сантай холбогдчихсон учраас би нэрээ татаж авах бодолтой байна.

Хоёрдугаарт нь, өнөөдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралд Боловсролын яамны хоёр гол асуудал орж ирж хэлэлцэгдэж байна.

Тэгэхээр өнөөдөр бид чинь төрийн байгууллагын бүтээмжийн тухай ярьж байгаа, төрийн албаны бүтээмж ажлын үр дүнгийн тухай их ярьж байгаа энэ цаг үед энэ хэлэлцэж байгаа хоёр асуудлын талаар бид нарт урьдчилаад мэдээллүүдийг бүрэн дүүрэн өгчихсөн байвал өнөөдрийн энэ хурал их үр дүнтэй байх байлаа гэж би бодож байна.

Сая энд гишүүдийн асууж байгаа асуулт, хэлж байгаа зүйлүүд дандаа та бүхнээс, энэ асуудлыг хариуцаж байгаа хүмүүсээс нэмэлт мэдээлэл, тодруулга шаардсан, хүссэн ийм асуултууд байгаад байлаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой мэдээллүүд урьдчилаад бид нарт танилцуулагдсан байсан бол магадгүй өнөөдөр бид бодлогын шийдэл яриад явах ч байсан юм билүү. Тийм ээ. Бий болоод байгаа асуудлын хүчин зүйлсийн талаар бид яриад арай дараагийн түвшний хэлэлцүүлэг энд өрнөж байх байсан болов уу гэж би бодож сууж байна.

Тэгэхээр дараа дараа дараагийн хурал дээр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой мэдээллүүдийг урьдчилаад гишүүдэд өгчихдөг байх ийм боломжоор хангаасай гэж Та бүхнээс хүсэж байна. Ийм хоёр зүйлийг хэлье.

Г.Дамдинням: Би хэдэн санал хэлье.

Нэгдүгээрт, “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийн яг

энэ драфт дээр байгаа, сая Б.Хэрлэн гишүүний хэлж байгаа асуудал байгаа юм.

Юу вэ гэхээр ажлын хэсэг маань хоёр чиглэл рүү явах гээд байна.

Тэгэхээр би ажлын хэсэг байгуулах санал гаргасан О.Батнайрамдал гишүүнтэй ярилцаад ер нь.

Энэ эхний хэсэг нь байгаа байхгүй юу. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилттэй танилцах гэдэг энэ хэсгийг нь авчихъя.

Яагаад гэвэл энэ чинь хэтэрхий өргөн болчихоод байгаа байхгүй юу. Ингээд л тавьчихвал Дээд боловсролын хуулийг тэр чигт нь “ревью” хийх л ийм л утга агуулагдчихаад байгаа юм.

Тэгэхээр зүгээр л “Боловсролын зээлийн сангийн журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төслөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” гэдгээр томъёолоод явчихъя гэдэг ийм томъёололыг санал болгож байна.

Манай байнгын хорооныхон бас энэ дээр найруулгын зохицуулалтыг нь хийчихвэл болчих байх. Тийм ээ. Дээд талд нь чи дурдчихсан байгаа. Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг дээр нь дурдчихсан байгаа учраас болох ёстой.

Хоёрдугаарт, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай асуудлыг манай О.Саранчулуун гишүүн нэлээн ярьж байгаа юм.

Би Дархан-Уул аймгаас сонгогдоод 5 дахь жилдээ Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Өөрийнхөө сонгогдсон тойргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй их ойрхон ажиллана. Ард иргэдтэй уулзаад явахад нэг юм аягүй тодорхой байгаад байдаг байхгүй юу. Яг О.Саранчулуун гишүүний яриад байгаа.

Хүүхдүүдэд битгий хэл бүр ингээд гэмт хэрэгт орооцолдчихсон, өөрийнхөө мэдэх мэдэхгүй байдлаас, эсвэл нийгмийн үйлчилгээ авах гэж байгаа, боловсролын үйлчилгээ авах гэж байгаа, худалдаа эрхлэх гэж байгаа. Ингээд төрийн агентлагууд дээр нь хүртэл, халамж авах гэж байгаа газар дээр нь хүртэл шүү дээ. Одоо жишээ нь гэхэд энэ хэл ярианы бэрхшээлтэй хүнд орчуулга хийдэг хүн байх ёстой хуулийн заалттай. Уг нь бол.

Дарханд гэхэд Монголын хоёр дахь том төв хот гэхэд хүн байхгүй. Арай гэж нэг хүн байдаг. Он энд оф. Ирээд буцаад, ирээд буцаад байдаг.

Тэгэхээр энэ зээлийн сангийн журамд П.Наранбаяр сайд аа, О.Сийлэгмаа дарга аа, хэдүүлээ бүр ярьж байгаад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээнд шаардагдсан хуулийн зориулалтад заагдсан байрлал газар оронд нь зориулаад тэтгэлэг зарладаг байдлаар энэ журмыг хэдүүлээ хиймээр байгаа юм.

Тэгэхгүй бол ёстой өрөвдмөөр юм билээ. Санамсаргүй байдлаас цагдаад шалгагдаад явж байгаа хүмүүс гэхэд цагдаа дээр мэдүүлэг авах гэхээр орчуулагч нь байдаггүй. Хэл ярианы бэрхшээлтэй хүнд туслах хүн байдаггүй.

Тэрийг нь Улаанбаатар хотоос дуудахаар зардал нь гарч өгдөггүй. Хэн нь авчрах нь мэдэгддэггүй ийм байдалтай байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр төр л юм бол ард иргэддээ жигд үйлчлэх ийм бодлого бид барих ёстой. Энэ дээр бодловсролын бодлого уялдаж явах ёстой гэдэг утгаар үүнийг журам дээрээ хэдүүлээ анхаармаар байна.

Дараагийн асуудал. Би өөрөө энэ зээлийн сан байх ёстой. Монгол орон 1989, 1990-ээд оны үед ардчилсан тогтолцоо руу шилжихэд бид нарт барууны боловсон хүчин дутагдаж байсан. Дэлхийтэй харилцах хүн дутагдаж байсан.

Бид нарт боловсон хүчний асар их дутагдалтай байх үед гарсан журам буян энэ үр өгөөжөө асар сайн өгсөн сан байхгүй юу. Энэ уг нь бол.

Одоо л үзэн ядаад л, энэ яадаг юм гээд дайраад байгаа болохоос. Уг нь үүгээр дамжаад гарчихсан. Түүрүүн О.Сийлэгмаа даргын хэлж байгаагаар 1.3 сая хүн үйлчилгээ авчихсан сан байгаа байхгүй юу. Монгол хүн.

1.3 сая мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд хувь нэмрээ оруулчихсан сан юм.

Тэгэхээр ямар ч төр, ямар ч улс өөрийн мэргэжилтэй боловсон хүчнээ бэлтгэх бодлого заавал барьдаг. Үүнийгээ л санхүүжилтийн тогтолцоогоор хийдэг.

Тэгэхээр сан нь байх ёстой. Харин П.Наранбаяр сайд аа, манай яамныхан, манай гишүүд ээ.

Энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийг нь байлгамааргүй юм шиг байна лээ шүү. Больчихмоор юм билээ. Заавал төл. Хүүтэй байх юм уу, хүүгүй байх юм уу, хугацаа нь урт байх юм уу, богино байх юм уу гэдэг л асуудал байх ёстой юм билээ.

Нэгэнт чи хөрөнгө оруулалт аваад боловсролтой болчихсон бол энэ мөнгөө эргүүлж төлдөг чадалтай боллоо л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ ер нь цаашдаа бодлогоо бодоод явмаар юм билээ.

Сая бид Татварын хуульд оруулсан тэр хөнгөлөлтийн тэр нийгмийн хариуцлагын бодлого нь өөрөө төр ер нь энэ сангуудад оролцоод байхаа больё гэдэг рүү л чиглэж байгаа бодлого шүү дээ. Хувийн хэвшил энэ төрийн ачааллыг үүрэлцье, өөрөө өөртөө ажлын байр дээрээ хэрэгцээтэй хүмүүсээ бэлдэж авъя, үүнийг нь төр дэмжье гэдэг ийм л бодлогыг бид хийж байгаа.

Тэгэхээр энэ чиглэл рүүгээ бас анхаармаар байна.

Гуравдугаарт, түрүүн Д.Бум-Очир гишүүний яриад байгаа асуудал байна. Олон нийтийн төлөө ажиллах, эсвэл нийгэмд ил тод ажиллах үүрэг хүлээчихсэн улс төрчид ч гэдэг юм уу ийм ажил хийж байгаа хүмүүс нь.

Бид байна шүү дээ, Монгол Улсын Үндсэн хуулиар хэний ч үр хүүхдийг ялгаварлан гадуурхах ёсгүй байхгүй юу. Аав нь дарга байна уу, ээж нь захирал байна уу, эсвэл 7 буудлынхан байна уу, эсвэл хөдөөгийнхөн байна уу. Хамаагүй шүү дээ. Бүгд тэгш эрхтэй. Гол нь л шалгаруулж байгаа процесс. Тэгээд

эргээд чөлөөлөгдөж байгаа процессыг ил тод, шударга болгоод өгөөч ээ л гэдэг асуудал яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг алдаа дутагдалтай явж ирсэн түүх байгаа нь үнэн. Үүнийгээ хэдүүлээ нэг дүгнээд тэгээд цаашаа үүнийгээ нийтэд нээлттэй ил болгох талаас нь ажилламаар байгаа юм.

Түрүүн Д.Бум-Очир гишүүний хэлдгээр би 10, 20 жилийн дараа Их Хурлын гишүүн болоод сууж байхыг би яаж мэдэх юм бэ? Энэ чинь. Хүний хувь заяаг ямар тааж мэддэг тансан лам биш ямар. Мэдэхгүй шүү дээ.

Тэгэхээр би бас ялгаагүй л ийм л юмаар л явж байгаа юм.

Тэгэхээр мань мэт нь гэрээний үүргээ биелүүлээд, ирээд ажлаа ч хийгээд, 5 жилээ ч гүйцээгээд, нийгмийн даатгалаа ч төлөөд, мөнгөөрөө ч аваачаад төлбөрөө төлчихсөн. Ингэхгүй байгаа эсэхээ яах юм бэ. Үүнийгээ хэдүүлээ бас ажлын хэсэг дээр яримаар байгаа юм.

Хэрвээ энэ хөнгөлөлт чөлөөлөлт нь байх ёстой юм уу гэж үзээд бүгдийг нь чөлөөлөх ёстой юманд оруулаад явчихвал төлчихсөн байгаа хэсэг нь хохирчхож байгаа байхгүй юу. Ялгаагүй шүү дээ.

Тэгэхээр төлүүлж байгаа бол бүгдэнгээр нь л төлүүлэх ёстой. Бүгдэнгээр нь төлүүлэх ёстой. Үүргийг нь биелүүлүүлэх ёстой.

Энэ чинь 2008 оны үед. Биш ээ, 2010-аад оны үед байна уу? Энэ Ё.Отгонбаяр сайдын үед барьцаатай болгосон шүү дээ. Бүр.

Тэрнээс өмнө ямар ч барьцаагүй байсан. Ийм юм байгаа юм.

Тэгэхээр би түрүүн зориуд үүнийг тодотгож хэлж байгаа нь. Би энэ ажлын хэсэгт орж ажиллана. Энэ бүх юман дундуур туучхаад, мөнгөө ч төлчихсөн, үүргээ ч биелүүлчихсэн. Надад ашиг сонирхлын зөрчил энд алга. Тийм болохоор орж ажиллана.

Түрүүний нэр дурдагдсан гишүүд бас орж ажиллах байх. Энд би нэрийг нь дурдчихъя.

Ж.Галбадрах гишүүн орё гэж байна, С.Эрдэнэбат гишүүн орё гэж байна, М.Сарнай гишүүн орё гэж байна, Б.Найдалаа гишүүн орё гэж байна, Ш.Бямбасүрэн гишүүн орё гэж байна, О.Саранчулуун гишүүн орё гэж байна.

Өөр нэр дурдагдаагүй гишүүн байна уу? Ийм гишүүд орё гэж байна.

Зүгээр Ж.Галбадрах гишүүнд нэг юмыг зүгээр сануулчихад.

Эргээд таны аминд орох байх шүү. Ер нь улс төр чинь их төвөгтэй ажил. Та сайхан сэтгэлээр тэтгэлэг өгөөд яваад байдаг. Тэтгэлгийн журам гардаг. Танай сургуулиас хүүхдүүд явчихсан байдаг.

Эргээд ашиг сонирхлын зөрчлийн асуудалд Та орчих вий. Миний хэлж

байгаа үг танд хэрэг болно шүү дараа нь. Та бодоорой. Тийм. Зүгээр сайн санааны үүднээс хэлж байгаа юм шүү. Юм нэг эргэхээрээ их эвгүй байдаг. Тийм.

Аягүй зовлонтой. Тийм. Ашиг сонирхлын зөрчлийн асуудал яригдана шүү. Та өөрөө ийм бизнестэй учраас. Тийм ээ. Тэрийгээ бас бодно биз. Тийм ээ.

Нэрийг нь ингээд оруулчихсан байна. С.Эрдэнэбат гишүүний ярьж байгаа тэр хөдөө орон нутагт, ялангуяа багш, эмч нар дутагдаж байгаа хэсэг дээр тэтгэлгийг хандуулах чиглэл рүү хэдүүлээ ажиллацгаая. Тийм ээ.

Ингэж байж бид орон нутгийн боловсролын ялгаагаа арилгана гэсэн ийм байр суурьтай байна.

Тэгээд одоо нэр дурдагдсан томьёололыг уншчихсан. Тэгээд найруулгын чанартай өөрчлөлтийг хэлчихсэн байгаа.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоолын төсөл батлагдлаа.

Гурав. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх

Дараагийн асуудалдаа орё.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг

Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулна.

П.Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: Тэгэхээр би Ц.Мөнхтуяа гишүүний ирүүлсэн асуулгуудыг 2024 оны 8 сарын 16-ны өдөр эхний асуулгад нь хариугаа өгсөн.

Тэгээд 9 сарын 10-нд ирүүлсэн асуулгад 9 сарын 26-ны өдөр хариугаа өгсөн.

Мөн холбогдох бусад байгууллагууд руу ирүүлсэн асуулгад нь хариунуудаа өгсөн. Нийт өгсөн хариу нь нэг ийм хэмжээний бичиг баримтууд болчихсон байгаа.

Тэгээд ер нь би Ц.Мөнхтуяа гишүүний яриад байгаа цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэхийг дэмжээд байгаа. Энэ бол шаардлагатай.

Үнэхээрийн чадварлаг боловсон хүчнийг боловсролын салбарт оруулж ирэх шаардлагатай байгаа нь үнэн. Үүний тулд цалин хөлсний бодлого нь өөрөө дэлхийн жишиг рүү ойртох л ёстой.

Энэ асуудлыг өнөөдөр бид Үйлдвэрчний эвлэлийн хороотой ярьж хамтын хэлэлцээр 2026 он хүртэл 3 жилийн хугацаанд байгуулсан байгаа.

Энэ жил цалингийн өсөлтийг инфляцын түвшинтэй уялдуулаад төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар өсгөхөөр өнөөдөр төсвийн төсөлд тусгагдаад явж байгаа.

Бид үйлдвэрчний эвлэлийн яг энэ Монголын Үйлдвэрчний эвлэлийн харьяа Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийнхэнтэй өмнөх сайдын үед байгуулсан хамтын хэлэлцээрийн заалтуудыг харахад 30 хувь гэсэн амлалт бий. Доор хаяж 30 хувь гэсэн.

Энэ амлалтдаа 2026 ондоо хүргэж чадна гэж харж байгаа. Тэр явуулж байгаа, тэнд хүлээсэн үүргүүдээ манай яамны зүгээс Ц.Мөнхтуяа гишүүнд ямар ямар хувьтай байгаа гэдгээ албан бичгээр хүргүүлсэн учраас энд дурдаад яах вэ.

Цалин хөлсний асуудал дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өөрөө засаг дотор Засгийн газар дотроо голлох яамны хувьд бодлогоо зангидаж байгаа. Бодлогоо зангидаж байгаа.

Бид цалин хөлснийхөө бодлого дээр төлөвлөгөө боловсруулаад яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газар энэ удаад 14 мега том төсөл гэж оруулж ирээд, энэ дээрээ санхүүжилтийг нь шийдээд.

Энэ өөрөө эхний 5 төсөл нь л хэрэгжээд эхлэхэд манай эдийн засгийн өсөлт ямар хэмжээнд хүрэх тухайд. Мөн нийт иргэдэд оногдох GDP буюу дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ямар байх тухайд манай Сангийн яамнаас, холбогдох сайд нараас олонтоо танилцуулсан учраас би энэ дээр нуршихгүй.

Энэ эдийн засгийн өсөлт яг цалин хэлбэрээр төрийн албан хаагчдадаа, нэн ялангуяа багш нартаа хүрч байх ёстой. Хүрч байх ёстой. Үүнийг бүрэн хүлээн зөвшөөрнө.

Бид цалингийн дундаж хэмжээг өнөөдөр байгаа төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээлэлд үндэслээд үзэхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багш, арга зүйчийн дундаж цалин 2.6 сая буюу 2 сая 698 мянган төгрөгт хүрээд байгаа.

Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, сургалтын менежер...

Г.Дамдинням: П.Наранбаяр сайд аа, уучлаарай. Ингэе. Тэгэх үү?

Улсын Их Хурлын гишүүний асуулт, эсвэл асуулга хоёрт хариулахаар яг асуултынх нь дарааллын дагуу ийм асуулт, тийм хариулт, ийм асуулт, тийм хариулт гээд явчихмаар байна.

Асуулт 1.1 нь хичээлийн жилийн бүтцийн хуультай холбоотой гээд байна л даа.

Тэгэхээр энэ дагуу нь хариулаад явчихвал гишүүдэд ойлгомжтой баймаар байна.

Яагаад би үүнийг танаас хүсэж байгаа вэ гэхээр өнөөдөр 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр. Гэтэл бид нарт өнөөдөр тараагдчихсан байгаа нэмэлт мэдээлэл нь 2020 оны 10 сарын 14-ний өдөр буюу өчигдөр ирсэн байж таараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр юмыг ойлгомжтой байлгах үүднээс нь, тэгээд бас энэ дэгийн явдаг журам, зарчмаар нь явчихъя. Тэгэх үү. П.Наранбаяр сайд аа.

П.Наранбаяр: Ойлголоо.

Тэгэхээр 8 сарын 16-нд ирүүлсэн асуултыг нь би уншаад, тэгээд хариулаад хариулаад л явчихъя. Тийм ээ. Надад хэдэн минут байгаа билээ. 10 минут. Тийм ээ.

Тэгэхээр 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэцтэй холбоотой. 4

улиралтай байсныг 3 улиралтай болгох шийдвэрээ тайлбарлаарай гэсэн.

Тэгээд 18 долоо хоног байхаар суралцагчдад залхах, багш сурагчгүй ядрах, хичээллэх хүсэл сонирхол буурдгийг өмнөх жилийн туршлага харуулсаар байтал энэхүү шийдвэрийг гаргах болсон үндэслэл шалтгааныг тайлбарлана уу гээд.

Хариултыг би хэлье. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ” гээд ийм хуулийн заалттай.

Тэгээд 34-өөс 37 долоо хоног хичээллэхээр баталсан байгаа.

Энэ хугацаанд нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг

- ▶ 1-ээс 2 дугаар ангид 34,
- ▶ 3-аас 4 дүгээр ангид 35,
- ▶ 6-аас 9 дүгээр ангид 36,
- ▶ 10-аас 12 дугаар ангид 37 хоног

байхаар яг хуулийн энэ заалттай нь нийцүүлж гаргасан.

Тэгээд 4-өөс 6 долоо хоногийн амралтыг

- нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад
- өвлийн ид хүйтрэлт буюу томуу төст өвчний дэгдэлт ихэсдэг 12 дугаар сарын сүүлээс 1 дүгээр сарын дунд үеийг дуустал 3-аас 5 долоо хоног,

→ хаврын амралтыг 1 долоо хоног байхаар зохицуулаад,

- харин аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн

→ өвлийн амралт 2-оос 4 долоо хоног,

→ хаврын амралтыг мал төллөх хугацаатай уялдуулан 2 долоо хоног байхаар тус тус төлөвлөсөн.

Энэ болохоороо хэт хүйтрэлт, агаарын бохирдол, томуу, томуу төст халдварт өвчний тархалтын нөхцөл байдлыг харгалзаж энэ амралтын хугацаанд хот хөдөөгийн хувьд ялгаатай тавьсан.

Гэхдээ 10 дугаар сарын сүүлээр, мөн 3 дугаар сард “бие даалтын долоо хоног” гэж оруулж ирсэн байгаа.

Бие даалтын энэ долоо хоног бол сургуулиуд өөрсдөө шийднэ.

Энэ хугацаанд бид эрүүл мэндийн үзлэгт хүүхдүүдийг бүрэн хамруулах, гамшгийн сургалтыг хийх, музей үзүүлэх гэх зэрэг ийм ажлуудыг зохион байгуулах юм.

1 дүгээр улирал нь 16-аас 18 долоо хоног үргэлжилж байгаа хэдий ч хичээлийн жилийн 9 дүгээр долоо хоног зохион байгуулах энэ бие даалтын ажлыг бид ингээд оруулсан гэдгээ хэллээ.

2 дугаар асуулт нь, хичээлийн жилийн нэгдүгээр улирлын дундуур буюу 9 дэх долоо хоногт бие даалтын үйл ажиллагааг тавьснаар ямар үр дүн гарна гэж тооцоолж байна вэ гээд.

Нэгдүгээр улирлын амралтыг зохион байгуулж, хичээлийн жилээ 4 улиралтай байхаар тооцоолж болоогүй юм уу гэсэн ийм асуулт байна.

Тэгээд бас танхим цахимын хэлбэрээр зохион байгуулна гэсэн шалтгаан нь юу вэ гэсэн асуулт.

Түүний дараа 9 дүгээр сарын.../минут дуусав/

Г.Дамдинням: П.Наранбаяр сайдад дахиад 5 минут өгье. Тэгээд багтаагаад явуулчхаарай.

П.Наранбаяр: Тэгье. Энэ нэлээн тийм том асуултууд. Тэгээд хариулт нь ийм юу байгаа.

Тэгэхээр би маш товчхон ярья. Уучлаарай.

Тэгэхээр бид бие даалтын цаг оруулж ирсэн нь энэ дээр ер нь хувь хүний хөгжил, бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, мэдрэхүйн ур чадвар гэж ярьдаг.

Үүнийг хөгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулахаар байгаа юм.

Түрүүнд хийсэн үйл ажиллагаануудыг явуулна. Гамшгийн сургалтыг 3 дугаар сард нь хийхээр Монгол Улсын Шадар сайдтай бид ярилцаад явж байгаа.

Аюулгүй амьдрах ухаан гэсэн нэг аятайхан хөтөлбөр байдаг. Гэвч энэ бас хэрэгжихгүй байгаад байгаа учраас бид гамшгийн сургалтыг 3 дугаар сард бие даалтын долоо хоногоор явуулна.

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.6-д сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй бэлэн байдлыг хангахыг боловсролын сургалтын байгууллагын удирдлагын чиг үүрэгт заасан.

Тэгэхээр цахим хичээлийг оруулж ирж байгаа.

Ер нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан хичээлийн жил эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа болон энэхүү тайлбар бичгийн 1.1-д дурдсан өвлийн улирлын амралтыг байгаль цаг уур, орон нутгийн онцлогт тохируулан нийцүүлсэн зохицуулалтаас хамааран холбогдох хуульд заасан нийтээр амрах амралтын өдрүүдээр нэмж ямар нэгэн амралт зохион байгуулах боломжгүй.

Ер нь бид ингээд 4 улирлаар явахаар маш их карантин зарлагддаг. Амьдрал дээр Та бүхэн харж байгаа. Энэ бол хүүхдүүд хичээл завсардах, зарим нэгэн долоо хоногт ховор ордог хичээлүүд бүр орохоо болих ч гэсэн ийм урхагтай байдаг учраас ингэж зохион байгуулж байгаа гэдгийг Та бүхэн ойлгоорой.

6-аас 12 дугаар ангийн суралцагчдын хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа 36, 37 долоо хоног байгааг 35 болгон 6 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хичээлийн жилийг дуусгах талаар арга хэмжээ олгох эсэх талаар асуусан байна.

Энэ бол хуулийн заалттай. 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр 170-аас 185 хоног хичээллэнэ гэж заасан байгаа учраас дунд, ахлах ангийн хичээллэх долоо хоногийг 35 болгох, 6 дугаар сарын эхний долоо хоногт хичээлийн жилийг дуусгах боломжгүй гэсэн ийм байдалтай байна.

Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг хэзээ шинэчлэн гаргах вэ гээд. Энэ гарчихсан байгаа. Гараад Хууль зүйн яаманд очоод мэргэжлийн зэрэг олгох журам батлагдсан, бүртгэгдсэн байгаа.

Тэгээд багш нарт мэргэжлийн зэрэг олгох ажил нь эхэлчихсэн явж байгаа.

Үүнийг бид эрх ашиг нь хөндөгдөх улсуудаас яг хууль журамд заасны дагуу бид саналыг нь авсан гэдгээ таньд хэлбэ.

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ээлжийн амралтыг хуваан эдлүүлэх чиглэлийн тухайд.

Энэ бол ингэж хуваахад Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-д заасан ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно гэсэн заалтыг ашиглаж байгаа.

Тэгээд Хөдөлмөрийн тухай хууль болон Боловсролын ерөнхий хуульд зааснаар ажлын 48 өдөр байна гэдгийг бид огт хөндөөгүй.

Тэгээд ээлжийн амралтын нэгдүгээр хэсгийн үргэлжлэх хугацаа 5, хоёр дахь хэсгийн тасралтгүй үргэлжлэх

хугацаа 43 ажлын өдөр байх нь яг энэ Хөдөлмөрийн хуульдаа нийцэж байгаа юм.

Ингэснээрээ бид нэгдүгээр сарын эхний долоо хоногт ямар нэгэн сургууль дээр багш нарыг цуглуулах, элдэв сургалт хийх, эд нарыг бүгдийг нь хийхгүй гэсэн ийм чиглэл өгсөн байгаа.

Тэгэхээр багш нар бүрэн яг энэ хугацаандаа амрах боломжтой юм шүү.

Харин зуны 45 хоног нь 43 болсноороо арай жоохон наах нь 8 сарын сүүлээр ажилдаа орж ирээд дундуур сүүлээр орж ирээд хичээлийнхээ жилийн бэлтгэлийг хангах боломжтой гэдгийг хэлье.

Цааш нь 2024-2025 оны хичээлийн жилд үүсэж буй багш, ажилчдын хомсдолын тухайд бид 6 багц арга хэмжээгээ зарласан байгаа.

6 багц арга хэмжээн дээр үүнийг бид Засгийн газрын хуралдааны дараа олон нийтэд дэлгэрэнгүй зарласан.

Энэ дээр ер нь 2024-2025 оны хичээлийн жилд дутагдалтай байгаа тоог би зарлаж ярьж ирсэн учраас энд яахгүй.

Тэгээд дутагдалтай багш ажилтныг нөхөх талаар ямар арга хэмжээ байна вэ гэсэн асуултад миний зүгээс Засгийн газрын хуралдааны дараа нь хариулсан байгаа учраас энэ дээр товчилж өгье.

Сүүлийн 4 жилийн дутагдалтай гээд энэ эд нарыг нь яачихъя. Энэ нэлээн. Уучлаарай. Нэг доор хариулахад жоохон цаг юутай байна.

Боловсролын “Цөм” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргасан эсэх, дүгнэлтийг ирүүлнэ үү гэсэн.

Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг.../минут дуусав/

Г.Дамдинням: Дахиад 5 минут өгье.

П.Наранбаяр: Уучлаарай. Саяын “Цөм” хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдсаны дагуу ажлын хэсэг нь байгуулагдаад өнөөдөр Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол ба бага боловсролын үндэсний хөтөлбөр, түүний зэрэгцээ, сурах бичгүүдийг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа.

Энд дандаа мэргэжлийн улсууд оролцсон.

Тэгэхээр тайлангийн тухайд судалгааны 2 ч тайлан гарсан байгаа.

Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг

- ▷ боловсруулах,
- ▷ хэрэгжүүлэх,
- ▷ үнэлэх

үйл явцын тайлан, түүнд нөлөөлж буй хүчин зүйл гэсэн ийм тайлангууд байгаа.

Чадамжийн шинжилгээг бүрэн хийсэн. Үүнийг асуулгын хариуд бүрэн тусгасан учраас энд товчлоод явчихъя.

Суурь боловсролын тухайд өнөөдөр 19 хичээлийн сургалтын хөтөлбөрийн

- ▷ зорилго,
- ▷ зорилт,
- ▷ агуулга,
- ▷ арга зүйн

үнэлгээ шинжилгээ хийж үзэхэд

- ▶ 22 хувь нь “бүтээлч сэтгэлгээ” нь,
- ▶ 21 хувь нь “нийгэмшил, сэтгэл хөдлөл”-д,
- ▶ 24 хувь нь “хүний хөгжил”-д,
- ▶ 14 хувь нь “мэдээллийн технологийн хэрэглээ”-нд,
- ▶ 19 хувь нь “Монгол болон дэлхийн иргэний чадвар”-т туссан байгаа.

Тэгэхээр эндээс хувь хүний хөгжлийг дэмжсэн чадварууд өндөр хувьтай харагдаж байгаа бол мэдээллийн технологийн хэрэглээ болон Монгол болон дэлхийн иргэний чадварын хувь нэлээн бага байгаа.

Үүнийгээ бид энэ удаагийн үндэсний хөтөлбөртэйгөө нэмэгдүүлэхээр орж ирж байгаа.

Тэгээд бүрэн дунд боловсролын тухайд гээд энэ агуулгууд нь бүрэн гарсан байгаа.

Танд хүргүүлсэн энэ асуулгад бүх нарийвчилсан мэдээлэл нь байгаа учраас товчилж өгөхө.

Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна уу гэсэн асуултыг ирүүлсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн 59.1-д “ажил олгогч ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллага дотроо харьяа нэгж салбарын хооронд дараах үндэслэлээр ажилтныг 3 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.” гэсэн ийм заалт байдаг.

Боловсролын ерөнхий хуулийн 12.14-д “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль. Ингээд политехник, коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.” гэсэн ийм заалтуудыг.

“Шилжүүлэн ажиллах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн энэ заалтын дагуу бид бас энэ журмыг боловсруулаад байгаа юм.

Үндэслэл, шаардлага, гарах үр дүнг асуусан байна. Шилжүүлэн ажиллуулахын тухайд.

Энэ дээр бид ямар хариулт өгсөн бэ гэхээрээ зэрэг 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд нийт 1410 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан. Эдгээр боловсролын сургалтын байгууллагад нийтдээ 1360 эрхлэгч ажиллаж байгаагаас 27 хувь нь тухайн албан тушаалдаа 11-ээс дээш жил ажилласан ийм туршлагатай хүмүүс байгаа юм.

Тэгэхээр үндсэн багш нарын 21 хувь нь багшаараа 11-ээс дээш жил ажилласан.

2024 оны 8 дугаар сарын мэдээгээр ерөнхий боловсролын сургуулиудын 871 ерөнхий боловсролын сургуулийн 157 сургуулийг. Үүнээс

- *нийслэлийн 41,*
- *орон нутгийн 116 сургуулийн захирал тухайн албан тушаалдаа 10-аас дээш жил ажилласан туршлагатай байгаа юм.*

Тэгэхээр эдгээр тэр ажилтнуудын сайн туршлагыг түгээхийн тулд тухайн дүүрэг дотор нь, аймгийн төв дотор нь сэлгэн ажиллуулах байгаа.

Тэгээд журмын төсөлд юу гэж тусчихсан байгаа вэ гэхээр “багш, ажилтныг шилжүүлэн ажиллуулах тохиолдолд цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулахгүй” гэсэн.

Хүлээх үүрэг, хариуцлага зэргийг харилцан тохиролцож гэрээ байгуулахаар. “Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, томилох эрх бүхий албан тушаал солигдсон нь шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг хугацаанаас нь өмнө цуцлах, шилжүүлэн ажиллах хугацаа дууссан багш, удирдах ажилтныг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахаас татгалзах үндэслэл нь болохгүй байх” гэсэн ийм зүйлүүдийг оруулж ирснээрээ тухайн багшийг хамгаалж байгаа юм.

Энэ хариултыг Та бүхэн авсан байх.

Нэмэлт мэдээллийн тухайд 9 сарын 10-ны өдөр ирүүлсэн дээр 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэцтэй холбоотой нэмэлт мэдээллийг танд хүргүүлсэн.

Чиглэлд дурдсан ээлжийн амралттай холбоотой тухайд мэдээллийг хүргүүлээд. Энэ тал дээр бүтэн энэ презентацийг нь хүргүүлсэн байгаа учраас би товчилъё. Баярлалаа.

Г.Дамдинням: Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Ц.Мөнхтуяа гишүүнээр тасалъя.
С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Гишүүний хүргүүлсэн асуултад нэлээн чухал чухал асуудлууд байгаа.

Энэ талаар саяхан багш нарын баярыг тохиолдуулаад “хичээлийн амралт”, “сэлгэн ажиллуулах”, “багшийн дутагдлыг нөхөх”, “цалин хөлсний асуудал” гэх мэтчилэн нэлээн олон багц асуудлын саналаа Боловсролын яаманд хүргүүлээд, зарим саналуудыг авсан.

Тэгэхээр зарим шийдвэрүүдийг гаргахад урьдчилсан байдлаар яг бодит тэр нөхцөл байдалд нь ажиллаж байгаа багш, ажилчид, үйлдвэрчний эвлэлүүдээсээ санал авах гээд энэ процессууд хэр хийгдсэн бэ?

Цаашдаа аливаа нэг шийдвэр гаргахад тэр хүмүүс маш их зүйлийг хэлж өгдөг. Бид нарын анзаараагүй.

Тийм учраас энэ тал дээр П.Наранбаяр сайдын хувьд яг ямар ямар асуудал дээр эцэслэн шийдсэн бэ?

Тэр зөвлөгөөн дээр яригдсан нэлээн олон асуудлыг бид тохирсон гэж ойлгож байгаа. Боловсролын яамныхан маань бүгдээрээ байсан. Бага, сургуулийн өмнөх, их дээд гээд.

Тэгэхээр энэ асуудлуудтай холбоотойгоор яг ойрын хугацаанд ямар шийдвэрүүд гарах вэ гэдэг ийм асуулт байна.

Цаашдаа процессын хувьд хэлэхэд шинэ дэгийн хуулиар гишүүд асуулт асууж, асуулга тавьсан тохиолдолд 10 хоногийн дотор тэрийг нь хэлэлцэнэ гээд тавьчихсан.

Тэгэхээр яах вэ, ер нь цаашдаа бид бүхэн яг тухайн асуудлаар бүх гишүүд сайд нарт асуудал тавиад, тэгээд тэр болгоныг нь 10 хоногийн дотор хэлэлцээд яваад байхаар бас хэр оновчтой байх вэ?

Үүнийг нь урьдчилсан байдлаар альныг нь хэлэлцэх вэ, альныг нь хэлэлцэхгүй вэ гэдэг асуудлаар Байнгын хорооны гишүүдийн саналыг харгалзан шийддэг байвал би зүгээр юм болов уу гэж бодоод байгаа.

Сайд гишүүд хоорондоо ярилцаад шийдчих бололцоотой асуудлыг тэндээ шийдээд явчих нь зүйтэй.

Тэгэхээр цаашдаа боловсролын асуудлаар жижиг гэлтгүй асуудлаар Байнгын хорооны гишүүд нэг уулзаад хэдүүлээ. Тийм ээ. Заавал хурал байдлаар биш. Хоорондоо уулзаад ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, тэгээд хүүхдийн хоол гээд зөндөө асуудал байж байгаа.

Энэ асуудлуудаар хэдүүлээ Байнгын хорооны гишүүдээрээ ажил хэргийн байдлаар яамныхантайгаа уулзаад, энэ асуудлуудаа нэг мөр шийдчихвэл цааш цаашдаа. Надад ч гэсэн маш олон асуулт байна л даа.

Тэгэхээр энэ тал дээр ийм юуг ойрын хугацаанд хийж өгөөч ээ гэдэг бас нэг хүсэлт байна.

Г.Дамдинням: Боловсролын сайд хариулъя.

П.Наранбаяр: Асуултад хариулъя.

Тэгэхээр хоёр дахь асуулт нь манай Байнгын хорооны дарга руу асуусан асуулт гэж ойлгож байгаа учраас.

Хоёр дахь асуулт дээр би өөрийнхөө бас байр суурийг хэлэхэд уг нь таны хэлээд байгаа их зүйтэй.

Тэгээд яг асуулга тавьсан гишүүнтэйгээ уулзаад ярилцахад хэзээд би нээлттэй шүү. Надад шууд хандах юм бол би хэзээ ч уулзахад бэлэн.

Тэгээд Үйлдвэрчний эвлэлээс бид саналуудыг Цогтгэрэл гээд Үйлдвэрчний эвлэлийн хорооных нь даргатай байнгын холбогдож ярилцаж, Та бүхний зөвлөгөөнд манай яамны холбогдох бүх л шатын дарга нар оролцож хоорондоо нэлээн сайн ярилцаж явж байгаа.

Үнэхээрийн сайн ярилцаад ирэхэд гаргаж байгаа журмууд чамбайрч байгаа нь харагдаж байгаа.

Тэгэхээр энэ бол бид дэмжээд шат шатандаа энэ ажлыг Та бүхэнтэй ярилцаад, олон нийтэд захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа захиргааны ерөнхий хуулийн дагуу хэлэлцүүлэхээр бид журмын төслүүдийг яамныхаа веб хуудсанд хэлэлцүүлж оруулж ирдэг.

Тэр болгон олон нийтэд дэлгэж харуулж байгаад саналыг нь аваад явдаг.

Мөн холбогдох байгууллагууд руу албан бичгээр явуулж саналыг нь авдаг.

Тэгэхээр энэ процессоо бид цаашдаа ч гэсэн илүү сайн мөрдөж явна. Энэ дээр холбогдох улсууд руу нь, ер нь бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэж ярьдаг. Яг л ийм процессын хуулиар заасан хүрээнд нь хандана гэдгээ хэлье. Баярлалаа.

Г.Дамдинням: Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Багш нарын цалингийн хэмжээг Та дунджаар гээд танилцуулсан. Сая бас танилцуулж байх шиг байна.

Энэ дээр Та зөвхөн танилцуулаад зогсохгүй, илүү тодруулаад өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

Татварын татварын өмнө үү, хойно уу? Жишээ нь. Тийм. Яах вэ, үүнтэй уялдаад нэлээд их санал гомдол гарсныг Та бүхэн сонссон байх. Сошиалаар нэн ялангуяа.

Багш нар ийм их цалин авдаг, авдаггүй гэдэг ийм нэг маргаан гараад байна.

Таны танилцуулж байгаа тоо баримт хаанаас гаргасан тоо баримт юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам юм уу, Боловсролын яам юм уу? Хаанаас гаргасан тоо юм бэ? Нэгд.

Хоёрт, яах вэ, ер нь сонсоход их өндөр сонсогдож байгаа. Ялангуяа багш нар итгэхгүй байдалд хүрээд байх шиг байна. Ийм их цалин бид авдаггүй шүү дээ гэсэн санал, гомдол нэлээд их харагдаж байна.

Тэгэхээр мэдээж төрийн сайд хүний хийж байгаа мэдээлэл хариуцлагатай мэдээлэл байгаа болов уу гэж ойлгож байна. Түүнээс санаанаасаа тоо хэлэхгүй байх.

Тэгэхээр ямар тоо байгаад байгаа юм. Зүгээр бодоход орон нутагт, ялангуяа суманд 40 хувь, аймагт 20 хувийн нэмэгдэл өгч байгаа. Энэ нэмэгдэл ороод ингэж өндөр сонсогдож байна уу?

Одоо яг энэ нэмэгдэл гарахаас өмнө өнгөрсөн хавар авч байсан мэдээлэлтэй зөрөөд байгаа юм л даа. Энэ цалин их өндөр байх шиг байгаа юм.

Хоёрт, цалингийн хэмжээ өндөр сонсогдож байхаас гадна тэр авч байгаа хувь. 17 мянган багш гэххэв үү. Би буруу хэлж байж магадгүй шүү. Тоог нь.

2 сая 500 мянгаас дээш гэж байсан уу. Гэх мэтчилний мэдээллүүд байгаа.

17 мянган багш гэдэг чинь их олон шүү дээ. Бидэнд ямар мэдээлэл байгаад вэ гэхээр тэр бүх нэмэгдлүүдээ авч байгаа цөөхөн тооны багш өндөр цалинтай байгаа.

Масс, дийлэнх багш нар, ялангуяа залуу багш нар. Ер нь багш нар ч их залуужиж байгаа шүү дээ. Цалин нэлээд бага. Гар дээр нь 1 сая 200, 300-аас илүү ирэх. Чадахгүй байгаа гэсэн. Тийм мэдээлэл байсан. Өнгөрсөн хаврын мэдээлэл шүү.

Тэгэхээр 1 сая 200. Би багш нартай уулзаад гар дээр чинь яг дунджаар хэд ирж байна гэхэд ер нь саяас сая 200 л байсан санагдаад байгаа байх. Багш нар ч гэсэн яг үүнийгээ яриад байна л даа.

Тэгэхээр та цалингийн мэдээлэл дээрээ тодруулга хийж өгөхгүй юу?

Г.Дамдинням: П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя.

Сая Та бүхэнд хэлсэн энэ мэдээлэл бол Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээллээс авсан мэдээлэл.

Яг хэлээд байгаа энэ цалингийн тоо нь татварын өмнөх шүү.

Тэгээд багш нарын үндсэн цалин 2023 онд **1 сая 273 мянга**. Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор тогтоосноор.

→ *Сургуулийн боловсролын сургуулийнх 1.3 сая байсан нь сая Засгийн газрын 2024 оны 128 доор тогтоолоор 1.4 сая.*

→ *Сургуулийн өмнөх боловсролын багш нар 1.47 буюу 1 сая 471 мянга болж өөрчлөгдсөн.*

“Цалингийн нэмэгдэл”, “Нэмэгдэл хөлс” гэж тусдаа байдаг.

“Цалингийн нэмэгдэл” гэдэг нь “мэргэжлийн зэрэг”.

Энэ нь “заах аргач”, “тэргүүлэх”, “зөвлөх” гээд нэмэгдэл авдаг.

- ▶ “Заах аргач” нь **10 хувийн**
- ▶ “Тэргүүлэх” нь **15 хувь**,
- ▶ “Зөвлөх” нь **20 хувь**,
- ▶ “Докторын зэрэг” нь **20 хувь**.

“Орон нутгийн нэмэгдэл” гэж байна. Энэ бол

- ▶ *аймгийн төв дээр 20 хувь,*
- ▶ *сумын төв дээр шууд 40 хувийн нэмэгдлийг тооцож олгож байгаа.*

▷ “Ур чадварын нэмэгдэл” **5-аас 25 хувь**,

▷ “Төрийн алба хаасны нэмэгдэл” **ажилласан жил тутам 1 хувь** нэмэгдээд явж байгаа.

▷ Цэцэрлэгийн багш “заах аргын нэгдэл удирдсан” **5 хувь** байдаг.

“Нэмэгдэл хөлс” дээр би ахиад ярья.

Сургуулийн багш

- ▶ *анги даасны 10 хувь,*
- ▶ *заах аргын нэгдэл удирдсан 5 хувь,*
- ▶ *кабинет лаборатори хариуцсан 5 хувь,*
- ▶ *илүү цаг заавал 1.5-аар тооцож олгодог.*

Бусад нэмэлт чиг үүргийн гээд.

“Гүйцэтгэл”, “Үр дүнгийн урамшуулал” гэж бас бий.

Энэ дээр 6 индексээр үнэлж байгаа.

▷ 2024 онд 1 дүгээр индексээр нийт багш нарын үнэлэгдсэн багшийн тоо **2346**,

▷ 2 дугаар индексээр **6324** гэх мэт ийм тоонууд байгаа.

▶ 1 дүгээр индексээр үнэлэгдвэл цалингийн шууд **40 хувийн** урамшууллийг авч байгаа.

▶ 2 дугаар индекс нь 25,
▶ 3 дугаар нь 20,
▶ 4 дүгээр нь 15,
5, 6 бол урамшуулал авахгүй байгаа.

→ Багшийн үйл ажиллагааг дэмжих бусад зардал дээр

▶ нөхөн хангалтын зардал,
▶ хичээл практикийн зардал,
▶ мэдээлэл технологийн зардал,
▶ багшийн хөгжлийг дэмжих зардал,
▶ эрүүл мэндийг дэмжих зардал гээд явж байгаа.

Багш нарын 2024 оны 5 дугаар сарын цалингийн мэдээллийг “гүйцэтгэл”, “үр дүнгийн урамшуулал” ороогүй дүнгээр ярихад

▶ ур чадварыг 9911 багш,
▶ анги даалт дээр 21 мянга 448 багш,
▶ орон нутгийн 26 мянга 164 багш,
▶ мэргэжлийн зэрэг дээр 26 мянга 658 багш,
▶ алба хаасны хугацаан дээр 38 мянга 600.../минут дуусав/

Г.Дамдинням: П.Наранбаяр сайдад 1 минут өгье.

П.Наранбаяр: Ингээд авсан байна.

2024 оны 5 дугаар сард олговол зохих цалингийн мэдээллийг харахад

▶ 1.2-оос 1.5 сая төгрөгийн цалин авсан 734 багш,
▶ 1.5-аас 1.7 сая төгрөгийн цалин

авсан 2381 багш,

▶ 1.7-гоос 2 сая хүртэл 4599 багш,
▶ 2-оос 2.5 сая төгрөгийн цалин авсан багш 15 мянга 651,
▶ 2.5-аас дээш.

Би дахиад хэлье. Энэ татварын өмнө шүү.

▶ 2.5-аас дээш 17 мянга 221 багш,
▶ 3.5-аас дээш саяас дээш цалин авсан багш 3041 багш гээд байгаа юм.

Энэ бодитой тоонууд шүү гэдгийг Та бүхэнд хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Дамдинням: Ц.Мөнхтуяа гишүүн асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Боловсролын сайд П.Наранбаярын анхны тушаал 2024 оны 7 сарын 10-ны А/01 тушаал. Хичээлийн жилийн бүтцийг батлах тухай байсан.

Мэдээж бодлогын яам сайдаар томилогдсон хүн судалгаа, шинжилгээ хийсэн гэж бодож байгаа.

Гэхдээ өмнөх сайдын үед 3 улиралтай байсныг нийцэхгүй байна гээд буцаагаад 4 улиралтай болгосон.

Гэтэл үүнийг буцаагаад дахиад 3 улиралтай болгох шаардлага байхгүй гэдгийг багш нар маш их шүүмжилж байгаа.

Манай П.Наранбаяр сайдад нэг дутагдал байна.

Та хөрсөн дээр ажиллаж байгаа багш нараа сонсмоор байна. Өнөөдөр зүгээр нэг сайхан агаарын тоог хэн ч цээжлээд яриад байж чадна.

Хөрсөн дээрээ ажиллаж байгаа, амьдралын зовлон жаргалдаа буцалж байгаа хүмүүстэйгээ нэг уулзаадхаач ээ.

Миний хувьд 2017 онд багшийн цалин 535 мянган төгрөг байхад анх багшийн цалинг 1.6 саяд хүргээд өгөөч ээ гэж нийгэмд шүгэл үлээгч багш хүний хувьд, өөрөө энэ боловсролын салбарын халуун тогоонд 23 жил багш хийж буцалсан хүний хувьд танд нэлээн үнэтэй хөрсөн дээр буусан зөвлөгөөнүүдийг өгнө.

Гэтэл яг уулзъя гэхээр та өөрөө уулзахгүй яваад байгаа. Намайг харахаараа доошоо хараад хулмалзаад алга болж байгаа. Тийм ээ. П.Наранбаяр сайд тэгж байгаа шүү дээ.

Тэгэхээр сайдтай би яаж уулзах вэ гэхээр танаас хүсэлт байна.

Би 200 багш цуглуулчихъя. Би худлаа яриад байгаа бол би сургууль сургуулийн төлөөлөл 200 багш цуглуулчихъя.

Тэгээд хоёулаа яг урдаас нь харж сууж байгаад асуудлаа ярья гэдгийг танд урилга хүргүүлье.

Үүнийг Та эхлээд хэрэгжүүлж хийчихмээр байна. Миний үгийг сонсоод бас инээгээд шоолоод байх шиг байна.

Түрүүн чуулганы индэр дээр би хоёр удаа танаас үг хэлж асуулт асуусан.

Тэгэхэд та нэлээн дооглонгуй шоолонгуй. Тийм ээ. Ийм өнгө аясыг гаргаж, хүмүүсийн дургүйцлийг их хүргэсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр хамгийн түрүүнд Та хөрсөн дээр ажиллаж байгаа багшаа сонс. Тэгээд хоёулаа яг өөдөөс нь харж суугаад. Би 200 багшаа өөрөө цуглуулчихъя. Сургууль сургууль руу хүсэлт явуулаад. Ийм байна.

Үйлдвэрчний эвлэлийн төлөөллүүдтэй уулзаж байгаа гэж байна. Манай Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо бол одоо энэ Монгол Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо маань бас ажлаа сайн хийж чадахгүй байна.

2017 онд жагсаал цуглаан хийгээд, 2018 оны 2 сард бид мэргэжлийн үйлдвэрчний эвлэлийн холбоог байгуулсан юм. Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо гээд Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуулийн хүрээнд.

Хуулийн хүрээнд явж байгаа ийм байгууллага байдаг шүү гэдгийг танд бас сануулж хэлье.

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл багш нартай Та уулзаач ээ гэдгийг дахиж хэлье, сануулъя гэж хэлмээр байна.

Тэгээд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5.2-г заасан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 сарын 01-ний өдрөөс дараа оны 6 сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ гэж заасан.

6 сарын 15 хүртэл хичээллэх ёстой гэсэн үг биш. 6 сарын 15-ыг хүртэл хичээллэнэ гэсэн санаа. Түүнээс хойш хичээллэхгүй гэдэг л ийм санааг агуулж байгаа гэж би ойлгож байгаа.

Гэтэл П.Наранбаяр сайд багш байсан, сургуулийн захирал байсан гээд өөрөө их ярьдаг.

Тэгэхээр 6 сар гарахаар шалгалт шүүлэг аваад хичээл ороход ямар хүндрэл бэрхшээл хүүхдүүд, багш нарын дунд байдаг вэ гэдгийг Та өөрөө мэдэж байгаа байх. Надаар хэлүүлэлтгүй. Тийм ээ.

Тэгэхээр хичээлийн жилийн бүтэц бол нэг их тийм оролдоод байхаар зүйл биш байсан шүү.

Одоо энэ OECD-ийн гишүүн орнуудын 19.4 хувь нь 3 улиралтай, 33.3 хувь нь 4 улиралтай гээд ийм хариулт өгсөн байна л даа.

Тэгээд ер нь манай яамныхан, энэ дарга нар дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишиг гэж их ярьдаг.

Тэгвэл тэр жишгээ дуурайх гээд байгаа юм бол, хичээлийн жилийн бүтцийг нь аваад ирж байгаа бол тэр сургалтын орчныг нь аваад ир, тэр цалин хөлсийг нь аваад ир. Тийм ээ.

Багшлах боловсон хүчнээ яаж бэлтгэдэг юм. Тэрийг нь хуулаад аваад ир. Дандаа нэг тийм өөрсдөдөө ашигтай юмыг нь хуулж авчраад өрөөлд, багш нарт, хүүхдүүдэд хэрэгтэй юмыг нь болохоор хуулдаггүй ийм дутагдал надад ажиглагддаг.

Надад ч гэх юмгүй манай багш нар үүнийг шүүмжлэлтэй ханддаг.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д холбогдох хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалт, сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан танхимын бус хэлбэрээр зохион байгуулна гэхсэн байгаа.

Хичээлийн жилийн нэгдүгээр улирлын 18 дахь долоо хоногт гамшиг болно гэдгийг урьдчилан тооцоолоод ахлах ангийн сургалтыг цахимаар явуулахаар заачихсан.

Үүнийг нь асуухаар Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.6-д заасан сургалтын цахим систем хөгжүүлэх.../минут дуусав/

Г.Дамдинням: Ц.Мөнхтуяа гишүүн ээ, та нэмэлт асуултын минутыг одоо авах уу, хариултынх нь дараа авах уу?

П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Ц.Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя.

Би нэг их хулмалзаад, нэг их хүнээс зугтаад байдаг ч хүн биш. Тийм юм байхгүй. Та надад яг уулзъя гэсэн хүсэлтээ ерөөсөө тавьж байгаагүй.

Та надад албан бичгээр асуулгууд, асуултуудаа ирүүлдэг. Хуулийнх нь заасан хүрээнд би хариултыг нь өгдөг.

Зүгээр би мэдээж бүхий л сургууль, цэцэрлэгийнхээ эрхлэгч, захирлууд, багш нартай уулзаад явж байгаа. Шаардлагатай бол уулзана. Энэ бол нэг их тийм юу байхгүй шүү. Таны яг

хэлсэнчлэн ийм юм байхгүй гэдгийг би хариуцлагатайгаар мэдэгдье.

Та ч гэсэн өөрөө бас багш хүн, би ч багш хүн. Тэгээд үгээр хоёр биенээ идээд яах вэ дээ. Тийм биз.

Та үгийнхээ сонголт юмнуудыг жоохон бодох шаардлагатай болов уу гэж би бодож байна.

Монголын үйлдвэрчний эвлэлийн тухайд манай яамны зүгээс Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нэг ийм заалт байгаа юм.

Хамтын хэлэлцээр байгуулах санаачилга гаргасан этгээдийн тооноос үл хамааран тухайн түвшинд нэг хамтын хэлэлцээр байгуулна гээд.

Тэгэхээр Боловсролын яам болон Монголын боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний холбооны хооронд хамтын хэлэлцээрийг байгуулахад Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтарч байгуулах эсэх асуудлаар тодруулга авахаар 2023 оны 1А/4589 дугаартай албан бичгийг Монгол Үйлдвэрчний Эвлэлийн Холбоонд бид хүргүүлсэн юм.

Тус холбооноос, одоо өөрөөр хэлбэл холбооных нь Ерөнхийлөгч нь таны цаана сууж байгаа шүү дээ.

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь, Монгол Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо болон Монголын боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоонд гишүүнчлэлгүй, төлөөлж оролцох боломжгүй талаар хариу ирүүлчихсэн юм.

Тэгэхээр надтай ингэж зууралдахынхаа оронд тэнд байгаа яг тэр үйлдвэрчний эвлэлийнхээ холбоотой яриад хоёр холбоог би учраа олоод нэг болоод л ороод ирье л дээ. Ийм л юм хэлээд байгаа шүү дээ.

Г.Дамдинням: Ц.Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: Монгол Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоог орох эсэхийг тогтоодог субъект нь биш л дээ.

Тийм учраас Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль дээр хэд хэдэн үйлдвэрчин байж болно.

Нэгдээд тооныхоо харьцаагаар орох эрх нь хуулиараа байхад зориуд санаатайгаар манай холбоог оруулахыг эсэргүүцдэг ийм үйл ажиллагаа их олон жил. Одоо 6 жил, 7 жил энэ үйл ажиллагаа явагдаж байгаа юм.

Тэгэхээр Л.Энх-Амгалан сайдын үед янз бүрийн тийм юугүй, тэгшхэн харьцаад явж байсан юм. Учраа олоод бас.

Одоо энэ удаа бид хуулийнхаа хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу бид бичгээ өгсөн байгаа. Албан бичгээ.

Тэгэхээр үйлдвэрчний эвлэлүүд тэгш эрхтэй. Хэн нь хэнийгээ захиргаадаа заагаад орно, орохгүй гэдгийг заадаг субъект нь биш ээ. Хуулийн хүрээнд. Нэгдүгээрт.

Тэгээд үйлдвэрчний эвлэлдээ хэрвээ та юу яаж байгаа бол хоёр

үйлдвэрчинтэй тэгш харьцаарай. Тийм. Яг адилхан эрх тэгш субъект.

Г.Дамдинням: Гишүүний асуулт боллоо.

Надад хоёр, гурван асуулт байна. Яах вэ, та хоёрынхоо ярилцаж байгааг харахад бид нарын ажил мэтгэлцэх.

Тэгэхээр яаж яримаар байгаа нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал байх.

П.Наранбаяр сайд аа, Та гүйцэтгэх засаглалын хүн. Өөрийнхөө хариуцаж байгаа салбарын төрийн бодлогыг барьж байгаа хамгийн дээд байгууллагад ажиллаж байгаа.

Асуултад хариулж байгаа учраас одоо бас Их Хурлын гишүүнтэйгээ гишүүдийн асууж байгаа асуултад тодорхой хариулаад явж байсан нь дээр байх. Нэг.

Хоёрдугаарт, Их Хурлын гишүүн бас уулзъя гэж байгаа бол уулзаж л байх ёстой байх л даа.

Засгийн газрын тухай хуульд ч гэсэн, Улсын Их Хурлын тухай хуульд ч гэсэн “Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана” гэдэг заалт байгаа шүү.

Тэгэхээр энэ асуудлуудаа та нар хоорондоо ярьчихвал уг нь зүгээр.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хэдэн асуулт байна.

Багш нартайгаа, амьдралын дунд явж байгаа хүмүүстэйгээ уулзаач ээ, яриач ээ, нийтийн дунд орооч ээ гэдэг энэ асуултыг манай тойргийн гишүүд ч ярьж

байгаа, манай тойргийн багш нар ч ярьж байгаа.

Зарим шийдвэрүүд. Яах вэ, сайд нар шинээр томилогдоод л гоё харагдах гээд л зөндөө юм хийдгийг мэднэ. Байдаг. Шинэ ч юм биш, гоё ч юм биш. Зүгээр гол асуудал нь энэ багш нартайгаа уулзаач ээ гээд байгаа энэ асуудлыг нь хүлээж аваач. Яагаад уулзаж болдоггүй юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, багш хомсдолын асуудлаар нэлээн яриа гарсан. Би Монгол Улсын Боловсролын Их Сургуулийг Багшийн их сургууль байхад нь төгссөн. Сурган, сэтгэл судлалыг 4 жил үзэж төгссөн хүн байхгүй юу. 4 жил тасралтгүй үзэж.

Дараа нь түүгээрээ магистр ч хамгаалаад явсан.

Хүүхдэд хичээл заана гэдэг бол мэргэжлийн ажил. Энэ бол хүний сэтгэл зүйтэй ажилладаг ажил. Өндөр хөгжилтэй улс орнууд, ер нь дэлхийн бүх улс орнуудад эмчтэй зүйрлэж үздэг, хуульчтай зүйрлэж үздэг.

Тэгэхээр энэ ажлыг багш дутагдаж байгаа нэрээр 45 хоногт бэлдэнэ гэдэг бол тийм ч сайн сонсогдохгүй байгаа.

Би өөрөө 2023 оны 7 дугаар сарын 07-нд батлагдсан Боловсролын ерөнхий хуулийг болон хамт өргөн мэдүүлсэн нийт 8 хуулийг 4 хууль болгож баталж гаргахдаа таны хэрэгжүүлэх гээд байгаа энэ багш бус хүнийг багш болгодог тогтолцоог хуульд нь хийж өгсөн.

Гэм буруутайг нь олоод ир гэвэл би байна.

Тэгэхдээ хэрэгжүүлэхдээ “бушуу туулай борвиндоо баастай” гэж сайд нь өөрөө журам гаргаад хэрэгжүүлэх ёстой эрхийг нь олгосон. 45 хоногт бэлдэнэ гээд байгаа чинь ямар учиртай юм. Энэ бол боломжгүй.

Кредитийг нь цуглуулж байгаад, суулгаж байгаад ингээд хийх тухай асуудлыг яриач ээ. Ингэж болдоггүй юм уу? Эсвэл та нарын нийгэмд ойлгуулах аргачлал чинь буруудчихсан юм уу?

Дараагийн асуудал. Энэ багш дутагдаж байгаа асуудлыг шийдэх дараачийн боломж бол одоо энэ онлайн сургалт. “Мэдлээ” [\[https://medle.mn\]](https://medle.mn) сургууль уг нь танай яамны дэргэд байгаа.

Монголын бүх сайн, мундаг гэгддэг багш нарын бичлэг, хичээлүүд танай тэр сургууль дээр чинь байж байгаа.

Энэ онлайн сургалтын орчныг бүрдүүлээд өгчихсөн байхад энэ багш дутагдлын асуудлаа шийдэх чиглэлд Та нар энэ дээр ямар санал санаачилга гаргаж ажиллаж байна?

Дэлхий даяар л онлайнаар сурч байна. Дэлхий даяар л хэнээс л хэнээс хичээл авч үзэж болж байна шүү дээ. Хэдэн ч удаа асууж, хэдэн ч удаа үзэж харж байгаад сурчхаж болж байна шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү Та нар ер нь ямар санаачилга гаргаж байгаа вэ?

Дараагийнх нь, би таны саяын танилцуулгаас харлаа. Сурах бичгийг өөрчлөх тухай л асуудал яригдах юм даа.

Тэгээд Боловсролын сайд болгон томилогдохоор сурах бичиг өөрчлөх юм

ярих юм. Больчихвол яадаг юм та нар үүнийгээ.

Хэдэн хэвлэлийн компанийн лоббид ороод л явдаг л байдал руу орчхоод байдаг юм шүү дээ.

Тэгээд үүнийгээ больчихвол яадаг юм.

Харин үүнийхээ оронд Та нар “сургалтын хөтөлбөрүүдийг үзэл баримтлалтай болгоно” гэдэг заалт байгаа шүү дээ. Уг нь. Энэ хүрээнд ямар ажлууд хийгдэж байна?

Дуртай болгон нь өөрчлөөд тодрох гээд оролдоод байдаг байдлыг болиулья л гэж байгаа шүү дээ. Нэг батлагдсан хөтөлбөр 12 жил явдаг байя л гэдэг хуулийн зохицуулалтыг бид хийж өгсөн шүү дээ.

Тэгэхээр үүний хэрэгжилт ямар байна?

Төгсгөлд нь бид багш, багш, багш гэж явсаар байгаад хөөрхий нөгөө муу сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, менежер, удирдах ажилтнуудаа хаясан байна лээ шүү. Хаясан байна лээ.

Нөгөө нэмэгдлүүд байхгүй, нөгөө нийгмийн баталгаа нь байхгүй.

Одоо ер нь хөөрхий тэр сургуулийн хамаг ачааллыг үүрээд менежмент хийгээд явж байгаа хүмүүст дэмжлэг байхгүй болсон байна лээ. Энэ дээр ер нь ямар бодлого барих вэ?

Тэр чинь бас л хүмүүс. Адилхан л алс орон зайд ажиллаж байгаа. Адилхан л хүүхдийн дунд бужигнаад явж байгаа. Адилхан л олон цагаар ажиллаж байгаа.

Тэр бүү хэл мань мэтийн хэрэгтэй хэрэггүй асуулт хариулт зөндөө асууж, хэрэгтэй хэрэггүй дарга болж шалгаж очдог хүмүүст байнга загнуулж чирэгдүүлж тэр орон нутагтаа ингээд явж байгаа хүмүүс шүү дээ. Бид нараас авхуулаад олон даргатай. Асар ачаалалтай хүмүүс байхгүй юу.

Тэгээд боловсролын салбарыг удирдаад явж байгаа энэ хүмүүсийнхээ нийгмийн асуудлыг бид бас бодох ёстой юм байна лээ шүү.

Энэ дээр ер нь ямар бодлого барих вэ? Ийм асуултууд байна.

П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр Г.Дамдинням гишүүний хэлээд байгаа саналуудыг хүлээн зөвшөөрнө өө.

Миний бие сайдаар томилогдоод 7 сарын 10-нд томилогдсоноос хойш одоо 3 сар орчим болж байна.

Нийслэлийнхээ бүх сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай уулзчихсан. Дархан хотод очиж бас Боловсролын газрынхантайгаа уулзсан. Дорноговь аймагтаа очиж бас боловсролын газар, захирлууд, зарим нэг багштайгаа уулзсан.

Ер нь уулзалтуудыг эрчимжүүлнэ. Таны хэлсэнчлэн яг л багш нарынхаа дуу хоолойг сонсох гэж л энд би сууж байгаа шүү дээ.

Ц.Мөнхтуяа гишүүний хэлээд байгаа ч гэсэн багш нартай уулзахад би бэлэн байна. Бодитой байдлаа эгцлэн хараад сайхан ярьцгаая. Энэ бол зүйтэй.

Багшийн хомсдол бодитой нүүрлэхээд байгаа юм. Байхгүй байна гэж хэлээд байгааг би ойлгохгүй. Энэ “алт нарыг алгаараа хаавч болдоггүй” гэдэг шиг тэр бодитой асуудал чинь өөрөө байгаад байна.

6 багц арга хэмжээ байгаа.

→ *Багш мэргэжлээр төгссөн болон багшийн ажил эрхлээгүй байгаа хүний нөөцийг ашиглах;*

→ *Тэтгэвэрт гарсан багш нарыг бага цагаар багшлуулах;*

→ *Шинжлэх ухааны чиглэлээр их дээд сургууль амжилттай төгссөн, эсвэл 3, 4 дүгээр ангид суралцаж байгаа оюутнуудыг багшийн ажилд татан оролцуулах;*

→ *Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах;*

→ *Багш бэлтгэх их дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар ажиллуулах;*

→ *Цахим сургалтыг багшийн дутагдал өндөр байгаа хичээл, сургалтад илүү эрчимтэйгээр хэрэгжүүлэх гээд.*

Энэ бол таны хэлээд байгаа яг тэр “Мэдлээ” гээд тэр сургууль.

“Мэдлээ” сургууль дээр одоо бараг 20 мянга гаруй болчихсон байгаа. Тийм ээ. Хичээл бэлтгэгдчихсэн байж байгаа.

Үүнийгээ цахим орчинд өөрсдөө ороод үздэг, **“3D”** орчин шиг. Тийм ээ. **“Metaverse”**. Ийм хэлбэр лүү оруулж илүү таатай үзэх боломжийг бий болгохоор ажиллаж байна.

Энэ бол яг багшийн хомсдолыг арилгахад, ялангуяа зайн дарангуйлалд байгаа, алсын зайд байгаа энэ хүүхдүүдэд хэрэгтэй.

Тэгээд Та бүхэнд уриалахад, “хүүхэд бүрд компьютер” гэсэн хэрэгтэй заалт байсныг нь дэмжээгүй шүү.

Тэгэхээр тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд цахим сургалтын арга барил хэрэгтэй гэдгийг шууд хүлээн зөвшөөрнө.

Сурах бичиг өөрчлөх өөрөө хуультай болсон. Үндэсний хөтөлбөр 10 жил тутамдаа, 10-аас 12 жил тутамдаа.

Үүнтэйгээ уялдуулаад зарим нэгэн сурах бичгээ өөрчлөх ажлыг яг хуулийн дагуу л хийнэ.

Түүнээс биш нэг сайд гарч ирээд өөрчлөөд байх юм бол одоо байхгүй болсон. Хуулиараа хориотой болсон. Энэ чинь.

Жишээлбэл, сургуулийн өмнөх боловсрол дээр “Түмэн бодис” гэдэг хичээл орохоор бичигдэж байна. “Унших бичиг” хичээлийн асуудал бас орж ирж байна.

Ингээд ийм зүйлүүдийг дагасан сурах бичгүүд ингээд мэргэжлийн хүмүүс нь яагаад. Тэгээд бид тохирцыг нь яг энэ хуульд заасны дагуу боловсролын.../минут дуусав/

Г.Дамдинням: Нэмэлт 1 минут?

П.Наранбаяр: Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэйгээ хамтраад явж байгаа.

Тэгээд Та бүхэнд явцыг бид мэдээлэхэд бэлэн байна. Яг ямар хэмжээнд байна.

Үзэл баримтлал нь батлагдчихсан байгаа. Боловсролын үндэсний хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлал нь батлагдчихсан байгаа.

Таны хэлж байгаа яг үнэн. Сургуулийн, цэцэрлэгийн эрхлэгч, захирлуудын цалин хангамж багшаасаа доогуур орчихсон байгаа.

Энэ нэмэгдлийг нь олгох шаардлага байна. Энэ дээр би тооцоогоо хийгээд явж байгаа. Би бүх хүмүүстэй уулзаад явахад үүнийг яг хэлж байна.

Ялангуяа тэр цэцэрлэгийн эрхлэгч нарт тэр балансын нөгөө урамшууллийг нь олгочихоор аудит нь очоод торгочихдог.

Энэ асуудлыг ч гэсэн бид аудитын байгууллагад нь хандаж байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Тэгэхээр П.Наранбаяр сайд, асуудлуудыг хэдүүлээ хуралдаанууд дээр сайхан хэлээд явах нэг хэрэг.

Дарга нартай уулзаад тойроод яваад байх даргын л ажил. Тийм.

Яг багшлах боловсон хүчинтэйгээ уулз аа, П.Наранбаяр сайд аа. Багшлах боловсон хүчинтэйгээ уулз. Өөр юм ярьдаг юм шүү.

Боловсролын хуулийг бид өөрчлөхдөө боловсролын хямралд орчихсон байна гэж үзээд босоо тогтолцоо руу шилжүүлчихсэн. Үр дүн нь гарах ёстой.

Та өөрөө шууд халж болдог тогтолцоо руу орчихсон учраас, шууд таны томилгоогоор ажиллах хүмүүс танд бодит амьдралыг хэлэхгүй шүү.

Багш нартайгаа уулз. Багш нартайгаа Их Хурлын тухай асуудлуудыг ярь. Аймаг аймгаар нь уулз. Би ч гэсэн тантай багш нараа уулзуулахад бэлэн байна. Асуудалгүй. Багш нар уулзах ёстой. Ялангуяа Ц.Мөнхтуяа гишүүн асуулга тавиад.

Энэ асуулгыг харвал яг багш нар бичсэн байгаа байхгүй юу. Яг багш нар бичсэн байгаа. Яг амьдралд нь тулгамддаг бэрхшээлүүдийг хэр баргийн хүн мэдэхээргүйгээр хийчихсэн байна.

Тэгэхээр эд нар дээрээ анхаармаар байна.

Тэр 45 хоногийн багш гэдэг юмаа больж үзээрэй дээ. Хэдүүлээ бас нэг ойлголцолтой. Төр байна даа. Тэгж тоглоом хийгээд яах вэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар асуулт асуусан гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа гишүүн 5 минут.

Ц.Мөнхтуяа: Сая асууж байгаад дутуу орхисон асуултуудаа асууна.

Энэ ингэж байгаа юм. Боловсролын сайдын 2024 оны 7 сарын 25-ны өдрийн А/06 тушаалын талаар.

Энэ тушаал нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах, багийн бүрэлдэхүүн батлах тухай заасан байгаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хамаарах чухал салбар болохын хувьд асуудлын ач холбогдол, хамрах хүрээг нь бодож үзсэн ч энэ сэдвийн хүрээнд Байнгын хорооноос олон нийтийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, асуудлыг нэлээн дэлгэрэнгүй авч үзэх хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол сургалтын хөтөлбөрөө баталчихдаг, сурах бичгээ баталчихдаг. Дараа нь “өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө” гэдэг шиг бөөн асуудал дагуулдаг.

Тэгэхээр энэ дээр манай П.Наранбаяр сайд маань нэг сайн бодолцоорой. 200 гаруй хүн сонгоод хийж байгаа гээд нэг тушаал гарчихсан байсан л даа. Тэрийг нь харж байсан.

Гэхдээ яг тэнд орсон хүмүүсээс чинь бас над руу гомдол ирээд байгаа л даа. Нэг тушаалд нэр орсон. Ерөөсөө бид уулзаагүй байгаа, юу ч яриагүй байгаа гээд.

Тэгэхээр энэ ам, ажил хоёр чинь зөрөөд байна гэдгийг сануулж хэлэх нь зүйтэй байх.

Би хүний нүднээс далдуур ярьдаггүй. Нүүрэн дээр нь шууд хэлдэг.

Тэгэхээр хүмүүст их таалагддаггүй байж магадгүй.

Араар нь муулж явснаас нүүрэн дээр нь хэлсэн нь дээр гэж бодож байна.

Дараагийн асуудал бол багш, ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмын талаар миний зүгээс Боловсролын яамнаас ирүүлсэн багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмын төсөлтэй танилцаад, өөрийн цахим хаягтаа багш нарт танилцуулж, санал авч байгаа бөгөөд саналаа цуглуулж дуусаад нэгтгэсний дараа Боловсролын сайдад албан бичгээр хандана.

Үүнийгээ танд эртхэн дуулгая гэж бодож байна.

45 хоногийн курсийг би Г.Дамдинням гишүүнтэй үнэхээр санал нэг байна. Багшийн мэргэжил 4 жил сурч, сурган сэтгэл судлал бүтэн үздэг ийм нарийн нандин мэргэжил.

“Нарт хорвоод эгнэшгүй нандин сайхан албыг гагцхүү багш хүнд заяажээ” гэж тэр үг зүгээр хоосон гараагүй байх гэж ойлгож байна.

Тэгэхээр багшийн мэргэжлийг зүгээр жирийн өөр мэргэжлийн хүмүүсээр 45 хоногийн курсээр бэлдэнэ гэдэг бол үнэхээр бүтэхгүй.

Харин тэтгэвэрт гарсан багш нараа бага цагаар багшлуулна гэдэг чинь их зөв. Сая П.Наранбаяр сайд дурдсан. Тийм ээ.

Тэгэхээр шинжлэх ухааны чиглэлээр их дээд сургуульд амжилттай төгссөн, эсвэл 3-аас 4 дүгээр курст суралцаж байгаа оюутнуудыг багшийн ажилд татан оролцуулах энэ ажлыг

Л.Энх-Амгалан сайдын үед хийж эхлүүлсэн.

Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах. Янз бүрийн ийм аргууд байна.

Харин энэ 45 хоногийн курс чинь үнэндээ таалагдахгүй байгаа гэдгээ бас хэлье.

Боловсролын салбар боловсон хүчний хомсдолд орсон. Тийм ээ. Үндсэн шалтгаан нь ерөөсөө л цалин.

Түрүүн манай Д.Бум-Очир гишүүн хэлж байна.

Ерөөсөө цалингаа л дорвитойхон нэмж байж энэ салбарт чинь хүмүүс өрсөлдөөнтэй орж ирнэ.

Ийм бага, мянган доллар хүрэхгүй, 300-аас 400 долларын хооронд цалин авч байхад мундаг боловсон хүчин ирэх үү.

Ер нь та нар хар ухаанаар бод доо. 300-аас 400-хан долларын цалин дээр Та нарын өндөр хөгжилтэй оронд төгсөөд ирчихсэн тэр мундаг залуус чинь ирээд ажиллах уу. Яг энэ мэргэжил дээр.

Энэ дээр бүгдээрээ хөрсөн дээрээ бууя. Г.Дамдинням гишүүн ч гэсэн Боловсролын ерөнхий хуулийг батлуулахад өөрөө манлайлж ахалж орсон хүний хувьд хоёулаа энэ дээр бас хамт дуугаръя. Цалин дээр.

Тэгэхгүй бол манай Галаа захирал ч сая хэлж байна. Үнэгүй магистр тэтгэлгээр явуулаад явуулаад ирээд ажиллах уу. Нөгөө 300 доллар дээр чинь.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ жоохон бодитой ажил хиймээр байна. Үнэхээр багшийн цалин бол арай л дэндүү бага байна. Тэгээд багш нар чинь ажлаасаа зугтааж байна. Бүгдээрээ Солонгос явах хүсэлтэй. Визэнд орж байна шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ яаж аргалах юм бэ. Бүгдээрээ нэг тийм тойрсон юм л яриад байх юм. Тулга тойрсон. Гол асуудал руугаа ормоор байна. Гол асуудал чинь ерөөсөө л цалин. Ийм байна.

Г.Дамдинням: Ц.Мөнхтуяа гишүүний асуултын хариултыг сонсож дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн хуралдаанууд дээр асуулт асуух. Мөн албан ёсоор асуулт асуух гэж тусгай бланкаар асуулт асуудаг.

Тэрний дараагийн арга хэмжээ асуулга явуулах гэж. Монгол Улсын ерөнхий сайд руу ханддаг ийм дэгтэй.

Тэгээд үүнийг Байнгын хороо, Их Хурлын чуулган дээр сонсдог дэгтэй.

Тэгээд шаардлагатай бол асуулгын үр дүнгээр Байнгын хороо, Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарч ажиллаж үүнийгээ үргэлжлүүлээд явдаг ийм дэг байгааг бас Ц.Мөнхтуяа гишүүнд зөвлөө.

Тэгээд гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүдийн хэлж байгаа саналуудыг ажил хэрэг болгож дараагийн ажлууд дээрээ тусгаад явна гэдэгт найдаж байна.

Тэгээд хэлэлцэх асуудал дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг өндөрлүүлж байна. Идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД